

Ш.Оюунцэцэг, Ц.Өнөрбаян, Б.Мөнгөнцэцэг, Л.Олзвой

МОНГОЛ ХЭЛ ХІ

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн
11 дүгээр ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны
зөвшөөрлөөр хэвлэв.

Гурав дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2019 он

ННА 74.2
ДАА 373
М-692

Монгол хэл XI: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 11 дүгээр анги
(Оюунцэцэг.Ш, ба бусад; Ред- Ө.Цэндсүрэн УБ., 2017. - 72х)

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар,
хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн
тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын
Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл
хэлбэрээр бүтнээр эсвэл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн
санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар
ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN: 978-99978-61-31-3

ГАРЧИГ

I БҮЛЭГ. ҮЙЛ ЯВДЛЫН ОРОН ЦАГ, НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ДҮРСЛЭН, МЭДРЭМЖ СЭТГЭГДЛЭЭ ИЛЭРХИЙЛЭХ

Аян замын тэмдэглэлийн сэдэв, гол санаа, агуулгын уялдаа холбоог дүгнэх.....	6
Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээ	14
Аялсан газрынхаа нөхцөл байдлыг мэдрэмж, сэтгэгдэлтэйгээ холбон бичих.....	17

II БҮЛЭГ. БАРИМТ, НОТОЛГОО, ДҮГНЭЛТИЙН УЯЛДАА ХОЛБООГ ТОДОРХОЙЛОХ

Шинжлэх ухааны хялбаршуулсан эхэд байгаа дүгнэлт, баримт нотолгоонд дүн шинжилгээ хийх.....	24
Угсарсан нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээ.....	31
Бичихдээ эшлэл, зүүлт, ном зүй ашиглах	36

III БҮЛЭГ. АСУУДЛЫГ СЭТГЭГДЭЛ, ҮЗЭЛ БОДОЛТОЙГОО ХОЛБОН ОЛОН ТАЛААС НЬ ЭРГЭЦҮҮЛЭХ

Эргэцүүлсэн эсээний дэвшүүлсэн асуудалд дүн шинжилгээ хийх	44
Холимог нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээ	52
Тодорхой асуудлыг сэтгэгдэл, үзэл бодолтойгоо холбон олон талаас нь эргэцүүлэн бичих.....	55

VI БҮЛЭГ. ТОЛЬ БИЧИГ, ТҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ

Толь бичгийн төрөл, тэдгээрийн үүрэг, зориулалт	60
Монгол толь бичгийн уламжлал.....	65
Толь бичиг ашиглах тухай.....	70

СУРАХ БИЧГИЙН АГУУЛГА

Бүлэг	Унших эх	Эхэд задлал хийх	Хэл зүй	Бичих
Үйл явдлын орон цаг, нөхцөл байдлыг дүрслэн, мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэх	Ж.Золбаяр Мөхөх аюулд буй соёл иргэншилд (аян замын тэмдэглэл) “Монгол бадарчин” номоос	Аян замын тэмдэглэлийн сэдэв, гол санаа, агуулгын уялдаа холбоог дүгнэх	Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээ	Аялсан газрынхаа нөхцөл байдлыг мэдрэмж, сэтгэгдэлтэйгээ холбон бичих
Баримт, нотолгоо, дүгнэлтийн уялдаа холбоог тодорхойлох	М.Саруул-Эрдэнэ Монголд цоохор нуур, цэхэр уул, саарал говь бий (шинжлэх ухааны хялбаршуулсан эх)	Шинжлэх ухааны хялбаршуулсан эхэд байгаа дүгнэлт, баримт нотолгоонд дүн шинжилгээ хийх	Угсарсан нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээ	Бичихдээ эшлэл, зүүлт, ном зүй, ашиглах
Асуудлыг сэтгэгдэл, үзэл бодолтойгоо холбон олон талаас нь эргэцүүлэх	Л.Түдэв Үнэр идэгч (эргэцүүлсэн эсээ)	Эргэцүүлсэн эсээний дэвшүүлсэн асуудалд дүн шинжилгээ хийх	Холимог нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээ	Тодорхой асуудлыг сэтгэгдэл, үзэл бодолтойгоо холбон олон талаас нь эргэцүүлэн бичих
Толь бичиг, түүний хэрэглээ	Толь бичгийн талаарх бичил эхүүд	Толь бичгийн төрөл, тэдгээрийн үүрэг, зориулалтыг мэдэх	Өвөрмөц ба хэвшмэл хэлцийг толь бичигт тусгах нь	Толь бичгийг зөв ашиглах



I БҮЛЭГ

ҮЙЛ ЯВДЛЫН ОРОН ЦАГ, НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ДҮРСЛЭН, МЭДРЭМЖ СЭТГЭГДЛЭЭ ИЛЭРХИЙЛЭХ

Эзэмших мэдлэг, чадвар

- Аян замын тэмдэглэлийн сэдэв, гол санаа, агуулгын уялдаа холбоог дүгнэх
- Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээ
- Аялсан газрынхаа нөхцөл байдлыг мэдрэмж, сэтгэгдэлтэйгээ холбон илэрхийлэх

АЯН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛИЙН СЭДЭВ, ГОЛ САНАА, АГУУЛГЫН УЯЛДАА ХОЛБООГ ДҮГНЭХ

“Архангайн замд”, “Харь нутагт байгаа монголчууд эх орноо чин зүрхнээсээ санадаг” хоёр эхийг уншихдаа бодит байдал, зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлийг ялган тэмдэглэж уншаарай.

Архангайн замд

1976 оны бороо ногоо тэгш сайхан зун С. Эрдэнэ тэргүүтэй хэдэн зохиолч уул даваа, ус гол гаталсан урт зам туулж, Архангайн Хорго, Тариат хүрлээ. Шөнө нь бороо орж, өдөр нь нар гарч, цаг агаар тусгай хөтөлбөртэй мэт байв. Гол усны хөвөөн дээр майхнаа барин, хээр хөдөө унтаж, өглөө нь машиндаа ачаалан, аян замдаа гарна.

Нэг өдөр бид хэд Хоргын тогооны ирмэг дээр зогсож байлаа. Гүн ёроолдоо хар ногоон устай энэ ”тогоо”-г хадан ирмэг дээрээс нь харахад аймаар, хөл алдвал дууслаа гэж бодсон сон.

Хорго үзсэний дараа С. Эрдэнэ нэг орой ”Би нэг шуналтай хүний тухай бичих санаа оллоо. Хомхой шуналаасаа болоод галт уулын тогоо руу орчихсон хүний тухай “Занга” богино өгүүллэг бичье” гэж тэр дороо л шинэ санаа олж бидэнд яриу.

Хорго, Тариатын нутгаас буцаж явахдаа бид Суман гол, Чулуут голын бэлчир дээр хүрч ирлээ. Хоёр ширүүн гол хар эрчээрээ явж, нэгэн хавцалд уулздаг аж. Зохиолч С. Эрдэнэ үүнийг “Цагаан устай Чулуут, хар устай Суман, хадан цээжтэй хатуу газрыг хага цохин нийлжээ. Нийлэх гэж тэмүүлэн тэмүүлсээр үүрд салшгүй нийлжээ. Чулуут, Суман хоёр эвлэрэн нийлэх гэж үзэлцсэн нь үнэхээр залуу хар эрэн барс, цагаан арслан хоёр уулнаас үсрэн бууж ноцолдон байх мэт” гэж уран сайхан дүрээр буулган хэлж байлаа.

Би Суман голыг хараад:

- Аргагүй жавхлантай гол юм гэсэнд С.Эрдэнэ:

- Юу гэнээ хө гэв. Би дахин:

- Жавхлантай гол юм аа гэвэл,

- Үүнийг чинь юманд оруулна даа хө гэж хэлж байна. Тэгээд “Долгорын Нямаа Суман голыг жавхлант гол гэж яруу найрагчийн ёсоор онож хэллээ” гэж надад урам өглөө. Ийм маягаар оносон нэг үгэнд ч олзуурхаж явдаг нь нарийн гярхай нүдтэй бичгийн хүний төрх араншин мөн ажээ.

Долгорын Нямаа

Асуулт даалгавар

1. Зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлийг ялган тэмдэглэснээ ярилцана уу.
2. Зохиолч С. Эрдэнийн маш ажигч гярхай зан чанарыг жишээ татан тайлбарлаарай.
3. ”Занга” өгүүллэгийг бичихэд Долгорын Нямаагийн “хөл алдвал дууслаа” гэж бодсон бодол, Хоргын тогоо хоёр зохиолчид ямар санаа төрүүлснийг таамаглан хэлэлцүүлэг өрнүүлээрэй.
4. Зохиож найруулан бичихэд онож сонгосон нэг үг ямар үнэ цэнтэй байдгийг тайлбарлаарай.
5. Зохиолчид аян замаас ямар олз омогтой буцаж ирснийг дүгнэн ярилцана уу.

Аян замын тэмдэглэлийн онцлог

Аян замын тэмдэглэлийг гадаад улс орон, эх орны өнцөг булан бүрээр аялж явах, томилолтоор ажиллах үедээ ажигласан шинэ сонин зүйл, улс гүрний хөгжил, ард түмний аж байдал, нийгмийн байгууллын онцлог, байгалийн өвөрмөц тогтоц, үзэгдэл, үйл явдал зэргийг уншигчдад сонирхуулах, танин мэдүүлэх зорилгоор бичдэг. Ийнхүү аялсан тухайгаа бичихэд зохиогчоос өргөн дэлгэр мэдлэг, ажигч гярхай чанар, цаг хугацаа шаарддаг.

Зохиогчийн хувийн сэтгэгдэл, тайлбар, уянгын халил, үнэлэлт дүгнэлт чөлөөтэй орно.

Аян замын тэмдэглэлийн онцлогийг судалъя

Бид Африк тивд аялсан Амайн бичсэн аян замын тэмдэглэлийг унших тул Намиби улсын тухай товч мэдээлэлтэй танилцъя.



Бүгд Найрамдах Намиби Улс
Африк тивд оршдог.
Нутаг дэвсгэр- 824,3 мянган км².
Хүн ам- 2,1 сая
Нийслэл- Виндхук.
Англи хэлээр ярьдаг.
Намиби улс хүн амын сийрэг суурьшлаар
Монголын дараа ордог. Дотоодын нийт
бүтээгдэхүүний 25%-ийг уурхайн олборлолтоос
бүрдүүлнэ. Ялангуяа ураны том үйлдвэрлэгч
орон.

Аян замын тэмдэглэлээс дараах асуудлыг анхаарч уншаарай.

1. Үйл явдлын дэс дарааллыг яаж тайлбарласан байна вэ?
2. Чухал мэдээллийг ялган, яаж тайлбарласан байна вэ?
3. Үйл явдлын учир шалтгаан, үр дүнг яаж ил болгож тайлбарласан байна вэ?
4. Агуулгыг тодорхой болгохын тулд ямар жишээ татаж тайлбарласан бэ?

Мөхөх аюулд буй соёл иргэншилд

I. “Монгол Бадарчин” 1-р аян, 29 дэх улс. Африк тивийн баруун урд нутгийн Намиби улсын хойд бүс Руацана суурин. Замд гараад хоёр жил болж байна. Өнөөдөр 2008 оны 01-р сарын 25.

Голын эхэнд барьсан усан станцын даланг түр хугацаагаар хаасан тул голын урсгал нам болж, урсгалын дагуу эгнэж хэвтсэн матрын сүрэг дундуур гарах гэж байгаа загасны амь дүйсэн тэмцэл нүдний өмнө харагдаж байна. Матрын ам руу үсэрч орох загас ч байна. Байгалийн амьдрал, бодит төрх.

Дэлхийн бөмбөрцгийн экватораас урагшаа цаг агаар эсрэг болдог нь сонин. Одоо Монголд ес эхэлсэн, тачигнаж байгаа, харин энд зуны дунд сар. Африк тивд нар шарж байна. Гадаа удаан байхын аргагүй. Голын нөгөө талд Ангол улс. Хэд хоногоос тийшээ хөдлөх тул санаа түгшиж байна. Гуч гаруй жил үргэлжилсэн иргэний дайны гал зогсоод тавхан жил болж байгаа нутаг. Байдал ямар байгаа бол оо?

Бичлэгийн аргыг ажиглая.

- Зохиогч очсон газраа нэг бүрчлэн тоочиж тайлбарласан жишээг ялгана уу.
- “... урсгалын дагуу эгнэж хэвтсэн матрын сүрэг дундуур гарах гэж байгаа загасны амь дүйсэн тэмцэл нүдний өмнө харагдаж байна. Матрын ам руу үсэрч орох загас ч байна. Байгалийн амьдрал, бодит төрх” гэсэн өгүүлбэр эхийн аль хэсэгтэй утгын холбоотой болохыг анхаарч уншаарай.

II. Ботсвана улсаас Намиби улс явах замдаа Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын иргэн Жон гэх европ царайтай тарган байрын хүнтэй танилцсан юм. Тэрээр Намибиас Ангол руу явах замд гэртээ очихыг урьсан. Тэднийх яг хил дээр, суурингаас зайдуу амралтын газар байгуулах санаатай жижиг байр тохижуулжээ. Ажил нь арай дуусаагүй байна. Байршил бол гайхамшигтай. Зэрлэг байгальд загас идэж буй матар харж сууна шүү дээ. Аж ахуйг нь авч явдаг нутгийн африк хүмүүс питон гэх аварга том могойд азарган тахиагаа алдсан тул маргааш нь өөрийг олохоор нутгийн суурин руу явах боллоо. Тахианы торонд ороод азарган тахиаг нь идсэн могойг нутгийнхан бариад арьсыг нь өвчсөнөө үзүүлээ.

- Жоныг танилцуулахдаа тайлбарлах ямар арга хэрэглэсэн бэ?




III. Халуун шөнө унтах гэж их бүгчимдлээ. Өглөө цайгаа уугаад азарган тахиа олж ирэхээр шороон замаар нэлээд яваад, архи пивоны шил хөглөрсөн нэгэн газар ирлээ. Ямар их шил байна аа! Түүнийг хараад би гайхлаа, бас харамслаа. Манай зарим газар иймэрхүү дүр зураг харагддагийг саналаа. Монголд байхдаа анзаардаггүй байсан ч гадны оронд ирээд өөрсдийнхөө арчаагүй байдлыг мэдрэх сэтгэл төрдгийг энд ойлголоо. Эд бол архи сархдад дарлуулж буй хүмүүс байна.

- Намиби, Монгол хоёр улсын онцлогийг харьцуулан тайлбарласан аргыг хаана хэрэглэсэн байна вэ?
- “... би гайхлаа, бас харамслаа” гэсэн хэсгээс зохиогч юу мэдэрснийг таамаглаарай.
- Зохиогчийн сэтгэгдлээ илэрхийлэхдээ дэмжсэн зарим зүйлийг олж, учрыг тайлбарлана уу.

Ардын засаглалын үед манайд архи, ундааны шилийг буцаан авч, дахин ашигладаг байсан системийг Европын орнууд хэрэглэж эхэлж байна. Үүнийг аль ч улс оронд хэрэгжүүлбэл хэрэгтэй санагдлаа. Сүрлэн дээвэртэй, модон ханатай, таван ханат гэрийн хэмжээтэй жижиг оромжууд, бас амбаарууд байна. Гэрийн үүдний гишгүүрийг доош харуулсан пивоны шилээр хийжээ.

IV. Намиби улсын нийслэл, хотууд нь цэвэр, хөгжил сайтай байсан. Африк тивдээ хамгийн цэвэр нь байх. Гудамжаар нь явж байхдаа замын хажуугаар элдэв бэлэг дурсгал, зарах зүйл



өрөөд суусан, жуулчдаас гуйлга гуйж байгаа Ова химба гэх омгийнхны заримыг нь харж байсан. Харин одоо Ова химба буюу улаан хүмүүсийн нутагт нь ирсэн байна. Улс орныхоо хөгжил, чиглэлээс хоцорсон, дагахыг хүсээгүй, өөрийн соёл иргэншлээрээ амьдрахыг сонгосон, соёлоо хамгаалж үлдэхийг зорьсон ийм хүмүүс улс бүрд байдаг билээ. Ова химба гэдэг

омог Хэрэро омгийн салаа мөчир бөгөөд хагас нүүдэлчин хүмүүс. Өвөлжөө хаваржаа гэдэг шиг өөр өөрийн бэлчээр нутагтай. Тэр бүр махаар хооллох нь ховор. Олдоц бага. Ихэвчлэн гурилан төрлийн хоол. Үхэр олонтой бол нэгээс олон эхнэртэй байж болдог “полигам” гэр бүлийн бүтэцтэй. Эмэгтэйчүүд нь нутгийн улаан шаврыг тостой холиод биедээ түрхдэг уламжлалтай. Тэрхүү өөхтэй шавар нь арьсыг нарны хурц туяа, шумуул шавжнаас хамгаална. Үнэр тааламжгүй. Үзэмж өвөрмөц.

Эдийн засгийн эх үүсвэр гээд байх зүйлгүй тул хот орж гуйлга гуйна, эсвэл сонин үнэр танар, загвартай гар урлалаа зарна, мөнгөөр зургаа татуулна. Өнөө цагт устаж мөхөх аюул нүүрлээд байгаа энэ химба гэх эртний омог сайндаа л 20000-50000 хүн амтай гэсэн. Өөрсдөө исгэж зараад байгаа халтар алчуураар бүтээсэн, бохир савтай ундааг нь амсахаар шийдлээ.

- Энэ омгийнхон мөхлийн ирмэгт ойртоод байгаа гэдгийг зохиогч юугаар тайлбарласан бэ? Чиний бодлоор өөр юугаар нэмж тайлбарлах вэ?

Ариун цэвэр энэ тэрээ гээд гомдоллохоо болиод удаж буй миний ходоод 10 орчим хэмийн согтууруулах чадвартай, барашиктай төстэй ч бага зэргийн тунадастай шингэнийг хүртлээ.

Бид тосгоноос азарган тахиа олоод, буцах замдаа бас нэгэн дэлгүүрээр орлоо. Байдал ялгаагүй, энэ удаа эрчүүдийн дунд Ова химба омгийн авгай сууж байна. Тэрээр надтай нутгийн хэлээрээ яриад

–Надад мөнгө өгчих, хоол авч идье! гэж гараараа дохилоо. Бас согтуу. Өдөржин ингэж сууна гэж бодохоор нэг бодлын санаж бодох зүйлгүй сайхан ч юм уу, нөгөө бодлын энэ жинхэнэ эмгэнэл байв.

Эд бас л мөнгө шаналгаж байгаад нэг төмпөн аз жаргал, амар амгалангийн ундаагаа авхуулчихлаа. Энэ бол ойрын хоёр цагтаа хангалттай. Гэхдээ дахиад хэзээ энд гадны хүн ирж мөнгө өгнө гэж Африкийн шороон замтай энэ газар хүлээж суух вэ?

Унаандаа суугаад, буцаад байрандаа ирлээ. Гар чийдэнгээр шөнийн зэрлэг байгалийн амьдралыг саравчин дээрээс харж байгаад унтлаа.

V. Монголчуудад виз санхүүгийн бололцоо гайгүй байсан бол хэд нь ингэж дэлхий даяар юм үзэж нүд тайлахаар явах байсан бол оо? Хэд нь брэнд, эд хогшил авах байсан бол оо гэж бодлоо.

Монголчууд бид соёл уламжлал, ёс заншлаа хамгаалж, төр болон иргэдийн зүгээс зөв бодлого хэрэгжүүлэхгүй бол өөрийн онцлогийг алдаж, даяаршиж, бүгд адил болж, нэг

удирдлагад орж буй дэлхийд төөрөн, алга болж магадгүй юм байна гэдгийг сүүлийн үед гүн бат ойлгох боллоо. Дэлхийн соёл иргэншил францжиж, англижиж, америкжиж, одоо хятаджих гэж байгаа өнөө үед монгол үндэстэн бид бусдыг дагаж дуурайгаад сайнаа олж долоохгүй нь ойлгомжтой. Өөрсдийн арга замыг олох хэрэгтэй байна.

Африкийн зэрлэг омгийнхонтой таарч үзэх тухай өмнө олон удаа бодож байснаа ажил хэрэг болголоо. Зөвхөн Африк төдийгүй дэлхийн олонх өвөрмөц соёл иргэншлүүд устаж байгааг анзаарлаа. Мөдхөн үгүй болох аюултай нөхцөлд буй өнө эртний соёл иргэншлийн дараагийн нэг жишээг харлаа.

Замаа үргэлжлүүлье...

Амай буюу Жамбалсүрэнгийн Золбаяр

Ойлголтоо нэгтгэе:

- Тавдугаар цогцолборт дэвшүүлсэн асуудлыг ярилцаарай.
 - Уламжлал, ёс заншил, даяаршил, соёл, иргэншил, өвөрмөц соёл иргэншил, эртний соёл иргэншил гэсэн үг хэллэгийн утгыг тайлбарлаарай.
 - Дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэх арга замын талаар саналаа солилцоорой.
- Дэвшүүлсэн асуудлыг цогцолбор бүрийн утга санаатай холбон тайлбарлаарай.



- “Мөхлийн аюулд буй соёл иргэншилд” гэж нэрлэсний учрыг батална уу.
- Санаагаа лавшруулахад уран дүрслэл, хэлц ямар үүрэгтэйг тайлбарлана уу.

Уран дүрслэл, хэлцийн жишээ	Тайлбар
... аз жаргал, амар амгалангийн ундаагаа авхуулчихлаа.	<i>Хөгжил дэвшилээс хоцорсон Ова химба омгийнхон архи уугаад мөхлийн ирмэгт байгааг егөөджээ.</i>
Эд бас л мөнгө шаналгаж байгаад	
Ариун цэвэр энээ тэрээ гээд гомдоллохоо болиод удаж буй миний ходоод...	
Хэд нь ингэж дэлхий даяар юм үзэж нүд тайлахаар явах байсан бол оо?	
Бид бусдыг дагаж дуурайгаад сайнаа олж долоохгүй нь ойлгомжтой.... дэлхийд төөрөн, алга болж магадгүй юм байна	

5. Эхээс зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлсэн хэсгийг ялган тайлбарлана уу. Жишээ нь:

“Ямар их шил байна аа” - Зохиогч өмнө нь ийм их архи ууж, шил нь хөглөрсөн газар хаа ч хараагүй байсан тул дуу алдаж цочирдон хүлээж авсан мэдрэмжээ илэрхийлсэн байна.

“Түүнийг хараад би гайхлаа, бас харамслаа” - Эндэхийн хүмүүс ингэж их архи уудаг юм байх даа гэж бодохоос гайхах сэтгэл төрж байна. Гайхсан сэтгэл нь сүүлдээ энэ хүмүүс мөхлийн ирмэгт ирснийг мэдрээд харамсаж байгаа санаагаа илэрхийлсэн байна.

6. Эхийн эхлэл, төгсгөл хэсэг агуулгын хувьд яаж холбогдсоныг тайлбарлацгаая. Юуг юутай адилтгасан байна вэ?

“... урсгалын дагуу эгнэж хэвтсэн матрын сүрэг дундуур гарах гэж байгаа загасны амь дүйсэн тэмцэл нүдний өмнө харагдаж байна. Матрын ам руу үсэрч орох загас ч байна. Байгалийн амьдрал, бодит төрх”...

... Дэлхийн соёл иргэншил францжиж, англижиж, америкжиж, одоо хятаджих гэж байгаа өнөө үед... зөвхөн Африк төдийгүй, дэлхийн олонх өвөрмөц соёл иргэншилүүд устаж байгааг анзаарлаа.

Агуулгын хувьд ямар холбоотойг таамаглан тайлбарлаарай.

7. Эхээс зохиогчийн үзэл бодол, тайлбар, тайлбарлагдаж байгаа юм зэргийг ялгаж бичье.
- Эдгээрийн аль хэсэгт дүрслэл илүү хэрэглэсэн байна вэ? Учрыг нь ярилцаарай.
 - Зохиогчийн үзэл бодлоо илэрхийлсэн хэсгийг олж, өөрсдийн үзэл бодолтой харьцуулан хэлэлцүүлэг өрнүүлээрэй. Жишээ нь:

“Дэлхийн соёл иргэншил францжиж, англижиж, америкжиж, одоо хятаджих гэж байгаа өнөө үед монгол үндэстэн бид бусдыг дагаж дуурайгаад сайнаа олж долоохгүй нь ойлгомжтой. Өөрсдийн арга замаа олох хэрэгтэй байна” гэж зохиогч үзэл бодлоо илэрхийлсэн байна.


Эдгээр санааг задалбал:

- “Дэлхийн соёл иргэншил францжиж, англижиж, америкжиж, одоо хятаджих гэж байгаа өнөө үед...” гэдгийг юу гэж ойлгох вэ?
- Яагаад “.. монгол үндэстэн бид бусдыг дагаж дуурайгаад сайнаа олж долоохгүй нь ойлгомжтой” гэж хэлэх болов?
- “Өөрсдийн арга замаа олох хэрэгтэй байна”- Тэгвэл бид яаж амьдрах ёстой вэ?

8. Энэ аян замын тэмдэглэлийг уншаад төрсөн сэтгэгдлээ бичнэ үү. Ямар асуудал дэвшүүлэх вэ?

Задлан шинжилж, нэгтгэн дүгнэе.

- Уншсан эхийн бүтцэд тулгуурлан агуулгын уялдаа холбоог гаргана уу.



2. Дээрх загвараас эхийн эхлэл, төгсгөл яаж холбогдсоныг ажиглаад, улаан сумаар заасан хэсгийн учир шалтгааныг олж тайлбарлаарай.
3. “Мөхөх аюулд буй иргэншилд” эхэд дүн шинжилгээ хийнэ үү. Жишээ нэмж олоод хэлэлцүүлэг өрнүүлээрэй. Үлгэрлэвэл:
 - а. *Үйл явдлыг хүүрнэн бичихдээ нөхцөл байдлыг тайлбарлан бичсэн байна. Жишээ нь: Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын иргэн Жон гэх европ царайтай тарган байрын хүнтэй танилцсан юм. ... Тэднийх яг хил дээр, суурингаас зайдуу амралтын газар байгуулах санаатай жижиг байр тохижуулжээ. Ажил нь арай дуусаагүй байна. Байриил бол гайхамшигтай. Зэрлэг байгальд загас идэж буй матар харж сууна шүү дээ” - Жоныг танилцуулахдаа нэг бүрчлэн тоочжээ.*
 - б. *Нөхцөл байдлыг тайлбарлахдаа өөрийн мэдрэмж сэтгэгдлийг илэрхийлсэн байна. Жишээ нь “Надад мөнгө өгчих, хоол авч идье! гэж гараараа дохилоо. Бас согтуу. Өдөржин ингэж сууна гэж бодохоор нэг бодлын санаж бодох зүйлгүй сайхан ч юм уу, нөгөө бодлын энэ жинхэнэ эмгэнэл байв” - хийх ямар ч ажилгүй, байнга согтуу байгаа Ова химба омгийнхныг хараад зохиогч төрсөн сэтгэгдлээ илэрхийлжээ.*
 - в. *Аян замын тэмдэглэл бичихдээ орон, цагийг тодорхой бичсэн байна.*
4. “Мөхөх аюулд буй соёл иргэншилд” эх нь аян замын тэмдэглэлийн ямар ямар шинжийг агуулсныг нягтлаарай.

№	Асуулт	✓	№	Асуулт	✓
1	Гадаад улс оронд болсон		7	Үйл явдал	
2	Ард түмний аж байдал		8	Зохиогчийн санаа бодол	
3	Нийгмийн байгуулалтын онцлог		9	Орон, цаг	
4	Ёс заншил		10	Уянгын халил	
5	Шинэ сонин зүйл		11	Үнэлэлт дүгнэлт	
6	Байгалийн байдал				

ЗЭРЭГЦСЭН НИЙЛМЭЛ ӨГҮҮЛБЭРИЙН УТГА, БҮТЭЦ, ХЭРЭГЛЭЭ

1. Зэрэгцэх холбоонд суурилсан үг, өгүүлбэрийг сэргээн санацгаая.
- а. Дараах өгүүлбэрийг чөлөөт холбоо үг болгон задлаад, зэрэгцэх холбоонд байгаа үгсийг тайлбарлаарай.

Элсний чийгэнд бургас, хайлаас, яргай ургана.

↓
элсний чийг

бургас
||
хайлаас
||
яргай
→ ургах

↓
чийгэнд ургах

- б. Дараах нийлмэл үгсийг яагаад зэрэгцсэн нийлмэл үг гэж нэрлэснийг тайлбарлаарай. бэлэг дурсгал, аз жаргал, амар амгалан, санаж бодох, архи сархад
- в. Өгүүлбэр дэх зэрэгцсэн холбоонд байгаа үгсийг ялган тайлбарлаарай.
- С.Эрдэнэ тэргүүтэй хэдэн зохиолч уул даваа, ус гол гатлан, урт зам туулж, Архангайн Хорго, Тариат хүрлээ.
2. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийг задлан шинжилж, онцлогийг нь мэдье.
- а. Дараах А, Б өгүүлбэрийн гол гишүүдийг ялгаж харьцуулна уу.


Үйл ажиллагаа	А өгүүлбэр	Б өгүүлбэр
Үйл өгүүлэхүүнд асуулт тавьж тэмдэглэх	Дөрөвдөгч галавын үед Хангайн нурууны Цагаан азарга голын эхэнд галт уул дэлбэрэн оргилж, Орхоны хөндийг уруудан урсаж, хэдэн арван км зузаан хүрмэн чулуун хучлага үүсгэжээ.	Ононгийн олон татуурга саваа халин мэлтэлзэж, зарим газраа намаг бамбалзаад хилчид мориор, эсвэл завиар л явж энэ хавийн хилийн зурвасаа шалгадаг гэнэ.
Өгүүлэхүүнээсээ ургуулан үйлийн эзэн өгүүлэгдэхүүнийг олж тэмдэглэх	<u>Галт уул дэлбэрэн оргилж, уруудан урсаж, үүсгэжээ.</u>	<u>Татуурга халин мэлтэлзэж, намаг бамбалзаад, хилчид явж, шалгадаг гэнэ.</u>
Үйл өгүүлэхүүнүүдийн холбоог олж тайлбарлах	дэлбэр-н	мэлтэлз-ж
Утга	?	?
А, Б өгүүлбэрийн ялгаа	?	?

- б. Дээрх харьцуулалтаа ажиглан, ижил ба ялгаатай шинжийг дүгнээрэй.
- Ижил шинж нь:
 - Ялгаатай шинж нь:
 - Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийг тодорхойлбол:
- в. Дараах өгүүлбэр хэдэн энгийн өгүүлбэрээс бүтэснийг задлан тайлбарлаарай. Шөнө нь бороо орж, өдөр нь нар гарч, цаг агаар тусгай хөтөлбөртэй мэт байв.

Нийлмэл өгүүлбэрийг энгийн өгүүлбэр болгон задлахад

- ямар холбоогоор холбогдсон нь
- нэг аялгад захирагдсан нь
- утга, үүргээр нэгдмэл байгаа нь мэдэгдэнэ. Эдгээр шинжийг мэдвэл тухайн утга нь зэрэгцэх эсвэл угсарч буюу дараалж болсныг ойлгоход хялбар болно.


Хоёр ба түүнээс дээш энгийн өгүүлбэр хоорондоо өгүүлбэр зүйн аль нэг холбоогоор холбогдон, нэг аялгад захирагдан, утга үүргийн хувьд нэгдмэл болсныг нийлмэл өгүүлбэр гэнэ. Нийлмэл өгүүлбэр нь хэд хэдэн санаа илтгэнэ.



Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн онцлог

- Зэрэгцэх холбоонд суурилна.
- Өгүүлбэрийн нэг нь нөгөөдөө захирагдахгүй.
- Өгүүлбэрүүд нь өөр хоорондоо тэгш эрхтэй холбогдох тул байрыг нь сольж найруулах боломжтой.

Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийг холбох хэрэглүүр



- а. Дараах өгүүлбэрүүдээс зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийг ялгаарай.
- б. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийг дараах алхмаар задлан тайлбарлана уу.
 1. Хэдэн энгийн өгүүлбэрээс бүтсэнийг задална.
 2. Өгүүлэхүүнийг зурж тэмдэглэнэ.
 3. Өгүүлэхүүнээс ургуулан, үйлийн эзэн буюу өгүүлэгдэхүүнийг олж зурна.
 4. А, Б өгүүлбэрүүд ямар нөхцөл, холбох үгээр холбогдсоныг тодорхойлно.
 5. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр мөн болохыг батална.

Ажиллах өгүүлбэр:

- “Халуун элгэн нутаг”-аа дуулан, аньсага нь чийгтэж, сэтгэл нь уярч, зүрхэндээ омогшдог юм, тэд.
- Намиби улсын нийслэл, хотууд нь цэвэр, хөгжил сайтай байсан.
- Өглөө цайгаа уугаад азарган тахиа олж ирэхээр шороон замаар нэлээд яваад архи пивоны шил хөглөрсөн нэгэн газар ирлээ.
- Эх орны уулс толгод ухааныг цэгцэлж, урсгалт сайхан гол мөрөн минь хатуу зөөлнөөрөө бүхнийг тэнцүүлнэ.
- Тэрээр Намибиас Ангол руу явах замд гэртээ очихыг урьсан.
- Гоёмсог цэцэгс, модод өнгө өнгөөр алаглаж, их мөрөн эргээ цохилон давлагаална.

Үлгэрлэвэл:

Эргэн тойрон эгц эгц өндөр ханан хад сүндэрлэж, хавцал гол хоёрын хоорондох нарийн жим улам нарийсаж, дээр хөх тэнгэр л мэлтийнэ.

1. *А өгүүлбэр: Эргэн тойрон эгц эгц өндөр ханан хад сүндэрлэнэ.
Б өгүүлбэр: Хавцал, гол хоёрын хоорондох нарийн жим улам нарийсна.
В өгүүлбэр: Дээр хөх тэнгэр л мэлтийнэ.*
 2. *Эргэн тойрон эгц эгц өндөр ханан хад сүндэрлэж хавцал гол хоёрын хоорондох нарийн жим улам нарийсаж, дээр хөх тэнгэр л мэлтийнэ.*
 3. *Хад сүндэрлэж, жим нарийсаж, тэнгэр л мэлтийнэ.*
 4. *А, Б, В өгүүлбэрүүд нөхцөлдүүлэн холбохын -ж, -ч нөхцөлөөр холбогдсон.*
 5. *Энэ өгүүлбэр нь зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр мөн. Яагаад гэвэл:*
 - *Хоёр буюу түүнээс дээш энгийн өгүүлбэрээс бүтсэн.*
 - *Гурван үйл өгүүлэхүүн тус бүр нэг өгүүлэгдэхүүнтэй.*
 - *Үйлийн зэрэгцүүлэн холбох нөхцөлөөр холбогдсон.*
 - *Үйл явдал зэрэгцэж нэг цагт болсон утга зааж байна.*
4. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн мэдлэгийг хэрэглэе.
- а. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн А, Б өгүүлбэрийн байрыг солин найруулж, дүгнэлт гаргаж ярилцаарай. Жишээ нь:
*Намрын шөнө одод гялалзаж (А) чийглэг сэрүүн агаар нуруу жиндүүлнэ. (Б)
Намрын чийглэг сэрүүн агаар нуруу жиндүүлж (Б) шөнө одод гялалзана. (А)*
 - б. Эхийг уншаад агуулгыг сэтгэлдээ дүрслэн зураглаарай. Нэг цагт хэчнээн үйл явдал зэрэгцэж, найруулгын ямар хэв маягийг бүтээж байна вэ?.

Өвөл

Саруул талын явган шуурга нүд гуядан үлээгээд
Салхин зээрд агсам хүлэг чадал мэдэн тэмүүлнэ.
Хүлэг морины хурдан явдал зөөлөн цасыг бужигнуулан
Хүйтэн цагийн жихүүн салхи үхэрчин хүүтэй тэмцэлдэж
Хөлдүү мөсөн оргилууд үдшийн наранд туяараад
Хөндий, жалга, гуу сувгаар үхэр сүрэг алхална. *Д.Цэвэгмид*

- в. Дараах эхийг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.
 1. Найруулгын хэв маягийг тодорхойлно уу.
 2. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийг задлан тайлбарлаарай.

Тэрхийн цагаан нуур

Тэрхийн цагаан нуур Хангайн нурууны ард оршино. Усны талбай нь 61.1 хавтгай дөрвөлжин км, 20 гаруй метр гүн бөгөөд нуурын гол дунд нь 28 метр өндөр арал цухуйсан байна. Энэ арал голдуу шохойн чулуунаас тогтсон бөгөөд тэнд сайхан үнэртэй санхам ургана. Зуны цагт нуурын дундах энэ бяцхан толгойд нүүдлийн шувууд цугларан өндөглөж, хар галуу мэт томоохон шувууд тэр ургамлаар нэг метр шахам өндөр үүр засаж, нуурын ёроолын лаг шавраар шавардаж бэхэлдэг байна.

Тэрхийн цагаан нуур бол манай орны загасаар баялаг нуурын нэг төдийгүй цурхай, тул, алгана зэрэг загас элбэг оршдог.



АЯЛСАН ГАЗРЫНХАА НӨХЦӨЛ БАЙДЛЫГ МЭДЭРЧ СЭТГЭГДЛЭЭ БИЧИХ

1. 1. Бичихийн өмнө аян замын тэмдэглэлийн зарим жишээтэй танилцаж, тус бүрийн бичлэгийн онцлог ялгааг тайлбарлаарай.

Алс газар сурахаар явагч

- А. Алс газар сурахаар очих замд
Намрын салхи өмнөөс сэржигнэнэ
Өвсний толгой намилзан халиурахын дундуур
Түүний гэрийн утаа цэнхэрлэн холдоно. ...
- Б. ... Өнгөрсөн ирээдүйг шүүмжлэх зуур
Олон одон жарав жирэв
Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас
Хүний хүү тэгж эрдэм өвөртөлж харина.

Д.Нацагдорж

Энэтхэг орноор...

А. "...Амьд зааныг анх удаа ойроос харж байгаа минь энэ. Биеийнх нь арьс хөхөлбий болоод зургаадугаар сарын чилдэн хөх тэмээдийг санагдуулна. Нүд нь хундаган чинээ, тийм том биед ийм жаахан нүд заяах гэж. Чих нь дал модны мөчир адил салбан далбан. Лай л болмоор. Хөлийнх нь тавхай тэгшхэн тайрсан царсны суурь лугаа адил, хумс нь загийн үндэс мэт.

Б.Золбаяр

Тал нутаг минь бидний жаргалын өлгий

А. Бидний замд хонь хариулж явсан нэгэн эмэгтэй тааралдав. Насаар миний үеийн л байх. Бараг надаас дүү ч байж мэднэ. Түүнээс зам асуух зуур хэсэг хөөрөлдөв. Танан цагаан шүдээ нарны гэрэлд туяартал инээмсэглэх сайхан бүсгүй байв. Эрүүл цагаан шүд нь бүр атаархал хөдөлмөөр. Хотын биднийх бол яаж ч угааж арчлаад ийм сайхан байхгүй дээ.

Б. ... Өврөөс нь номны булан цухуйсанд сониучирхан асуувал тэрээр нэлээд хуучирсан "Саран чулуу" гэж ном гаргаж ирэв. Би бага байхдаа уншиж байсан ном байсан тул энэ ном таалагдаж буй эсэхийг асуухад "Эмэгтэй хүн уншууштай л ном" гэж тов хийтэл нь хариулав.

Б.Эрхэмбаяр

Алтай

А. ...Нисэх онгоцоор Ховд хотоос Өлгий хот орж явахад Цамбагаравын дүлий цагаан оргил зэрэгцээд ирэхийн үес тэр оргилын хүйтэн жихүүн амьсгал онгоцны бөөрнөөс нэвг үлээх мэт ар нуруу руу хүйт оргиж байв. Тэртээ умар зүгт Хархираа, Түргэний шовх шовх оргилууд гялбалзан харагдана. Тэдгээрийн наад захынх нь асар том болор талстууд мэт гэрэл цацруулан, цаад захынх нь уул, үүл алин болох нь ялгагдахгүй хөхрөн зураж байв.

С.Эрдэнэ

б. Дөрвөн өөр аян замын тэмдэглэлийг уншлаа. Аялынхаа тухай уншигчдад яаж ойлгомжтой тайлбарласныг ярилцаад, уран дүрслэл, зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлсэн хэсгийг олж бичээрэй.

Эхийн нэр	Цогцолбор	Тайлбарлах арга	Уран дүрслэл, хэлц хэллэгийн жишээ	Зохиогчийн мэдрэмж сэтгэгдлийн жишээ
Алс газар сурахаар явагч	Б	тоочин тайлбарласан		
Энэтхэг орноор	А	шинжийг тоочин тайлбарласан	Адилтгал	
Тал нутаг минь бидний жаргалын өлгий	А	харьцуулан тайлбарласан	Адилтгал	
	Б	эш татан тайлбарласан		
Алтай	А	нарийвчлан тоочин тайлбарласан	Адилтгал	

2. Дараах үг хэллэгийг ажиглан, ямар үүргээр хэрэглэснийг тайлбарлаарай.

а. “тийм том биед ийм жаахан нүд заяах гэж”

б. “лай л болмоор”

в. “...тэр оргилын хүйтэн жихүүн амьсгал онгоцны бөөрнөөс нэвт үлээх мэт ар нуруу руу хүйт оргиж байв”

Эх орныхоо байгалийн сайхнаар болон гадаад орноор аялсан тэмдэглэлийг уншиж дараах аргуудад тохирсон жишээ цуглуулцгаая.

- Үйл явдлыг нэг бүрчлэн тоочин тайлбарласан
- Гадаад, дотоод талыг зураглан тоочиж тайлбарласан
- Зохиогчийн үзэл бодлыг илэрхийлсэн
- Уран дүрслэл, хэлц үг хэллэг хэрэглэсэн

3. Одоо аян замын тэмдэглэл бичих дадлага хийцгээе. Жинхэнэ аялалд оролцоогүй ч гэсэн төсөөлөн бодоод бичиж болно.

“Улаанбаатараас Өвөрхангай аймгийн Орхоны Улаан цутгалан хүртэл” сэдвийн дор бодит байдалд хандах мэдрэмж, сэтгэгдлээ уялдуулан бичнэ. Юуг тайлбарлан таниулж, өөрийн бодол санаагаа илэрхийлмээр байна вэ? Ямар асуудлыг дэмжин сайшааж, эсвэл шүүмжилмээр байна вэ?

Эхлэл хэсэгтээ ямар чухал санааг гаргамаар байна вэ? Цаашид яаж үргэлжлүүлж бичмээр байна вэ? Дараах жишээг ажиглаад сонгон ашиглаарай.

Баримт	Бичигчийн төвлөрөх асуудал
<p>22-ын товчоо</p> <p>Нийслэлээс баруун зүгт гарч байгаа болон орж ирж байгаа авто машины хөдөлгөөнийг энд бүртгэн зохицуулдаг. Саяхан бүрэн автомат тоног төхөөрөмж бүхий хаалттай болголоо. Уг хаалт нь тээврийн хэрэгслийн улсын дугаарыг бүртгэх дугаар таних системтэй бөгөөд 2 секундын дотор нээгдэж хаагдана. Дугаар таних систем ба хяналтын камерыг Нийслэлийн авто замын газрын төв сервер дээр шууд хянаж байдаг юм байна.</p>	<p>Тарваганы хорио цээр тавигдаагүй тул Мэргэжлийн хяналтын газраас шалгалт гарсан тухай</p>

<p style="text-align: center;">Туул гол</p> <p>Туул гол нь Хэнтийн нуруун дахь Горхи, Тэрэлжийн байгалийн цогцолборт багтах Хагийн хар нуур, Номингийн голоос эх авч, нийслэл Улаанбаатар хотын урд хэсгээр өнгөрөн Орхон голд цутгана. 11 сарын дундаас 4 сарын дунд хүртэл хөлдөнө.</p>	<p>Туул голын усны түвшин багасаж, эвгүй үнэртэй болж, мал уухаа больсон тухай</p>
<p style="text-align: center;">Элсэн тасархай</p> <p>Төв аймгийн Эрдэнэсант, Өвөрхангай аймгийн Бүрд, Булган аймгийн Гурванбулаг сумдын нутгийг дамнан Батхаан уулын баруун талаас эхэлж Хөгнө хаан уулын баруун талаар сунаж тогтсон 80 км орчим урт элсэн манхан юм. Төв зам элсэн манханг хоёр хувааснаар өмнөд хэсэг нь Монгол элс, хойд хэсэг нь Хөгнө Тарнийн элс гэж нэрлэгддэг. Тарнийн голын нөлөөгөөр тогтсон элсний чийгэнд бургас, хайлаас, яргай ургана. Говь хангай хосолсон нутаг. Зуны цагт жуулчдын хөл тасардаггүй байгалийн үзэсгэлэнт газар юм.</p>	<p>Гадаад, дотоодын жуулчдад унуулахаар бэлтгэсэн тэмээний эзэн өдөржин жуулчин хүлээж, тэмээгээ сахиж суугаа тухай</p>
<p style="text-align: center;">Эрдэнэ зуу хийд</p> <p>Эртний Монголын эзэнт гүрний нийслэл Хархорин хотын туурин дээр үлдсэн чулуун ханыг зөөж, одоогийн Эрдэнэзуу хийдийг босгосон түүхтэй. Монгол улсын хамгийн эртний бурхан шашны хийд юм. 108 суваргаар хүрээлэгдсэн, Буддын шашны хийд төдийгүй музей учраас жуулчдад нээлттэй ажиллаж байна.</p>	<p>Хүмүүсийн сэтгэлийг татах эртний түүх соёл бүхий их зүйлийг хийсэн тухай</p>
<p style="text-align: center;">Орхоны Улаан цутгалан</p> <p>Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд байрлах Улаан цутгалан хүрхрээ нь зуны дэлгэр цагт гадаад, дотоодын аялагч, жуулчдын үзэхийг хүсдэг хамгийн үзэсгэлэнтэй газрын нэг юм. Харин Орхоны хөндийн үзэсгэлэнт Улаан цутгалан татарчээ. 24 метрийн өндрөөс буух хүрхрээ хүний буруутай үйлдлийн улмаас байгаль экологийн тэнцвэрт байдал нь алдагдаж, татарсан гэж нутгийн иргэд хэлж байна. Нөгөө талаас, хур бороо бага байгаа нь бас нэг шалтгаан юм.</p>	<p>Энэ чинь өнөө Улаан цутгалан мөн үү?</p>

Гол хэсэгт


4. “Бичигчийн төвлөрөх асуудал” хэсгээс наад зах нь 3-ыг сонгон мэдрэмж, сэтгэгдлээ бичье. Жишээ нь:

Биднийг 22-ын товчоогоор дайран өнгөрөхөд “Тарваганы хорио цээр тавигдаагүй байсан тул Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас шалгалт гарсан байлаа” гэсэн хэсгийг сонгосон гэж үзвэл:


а. Энэ байгууллага халдварт тарваган тахлаас ард иргэдээ урьдчилан сэргийлэх ажлыг сайтар зохион байгуулсанд сэтгэл ханамжтай байгаагаа бичиж болно.

б. Тарвага агнах хорио 8-р сарын 15-аас тавигддаг. Энэ хуулийг зөрчдөгөөс тарваганы тоо цөөрч ховордон, улмаар устах аюул дагуулж байгаа талаар үзэл бодлоо илэрхийлж болно.

5. Дараах төлөвлөгөөний дагуу “Бичигчийн төвлөрөх асуудал” хэсгээс сонгон байгалиа хайрлан хамгаалах талаар саналаа илэрхийлэн, аян замын тэмдэглэл бичье. Аяллын замд таарах байгалийн үзэсгэлэнт болон түүхийн дурсгалт эдгээр газрын талаарх нэмэлт мэдээллийг интернэт, толь бичиг зэрэг эх сурвалжаас дэлгэрүүлэн судлаарай.



6. Төгсгөл хэсэгт хэсэг тус бүрд гаргасан өөрийн үзэл бодлоо нэгтгэн дүгнэж, агуулгаас хамгийн оновчтой гол үгээр гарчиг өгөөрэй.



7. а. Аливаа тэмдэглэлд зохиогчийн үнэлэлт, сэтгэгдэл туссан байдаг. Сэтгэгдлийг уншиж, дараах загвараар задлаад, сэтгэгдлээ хэрхэн илэрхийлж болох талаар ярилцаарай.

Юмс үзэгдэл → мэдрэмж сэтгэгдэл → бодрол ухаарал

Австрийн яруу найрагч М.Рильке “Парисын Луврын музейн “Аполлон*”-ы баримлыг хараад, өөрийгөө сая цоо шинээр ухаарч, Аполлон түүнийг “Чи амьдралаа өөрчил” гэж ятгаад байлаа” гэж бичжээ.

... “Юрий Нагибиний “Женя Румянцева” өгүүллийг уншаад чимээгүй уйлж, бага насаа үгүйлэв. Юутай сайхан цэвэр тунгалаг, мөрөөдөмтгий тусч хөвгүүн явж вэ? Тэр бүхнээсээ аажуухан хөндийрч аль нэг талаараа өөрөөсөө холдох зам руу хазайж л байж... Хэн нэгэнд гомдох, гомдлоо илэрхийлэх нь ичгүүртэй юм. Өөрийгөө өрөвдөж, өөрийгөө хайрладаг хүн л их гомдомтгой байдаг аж.

Алив бүхнийг уучилж чаддаг болсон цагтаа л чи хүн болно гэж өөртөө хэлж байна. Өөрийгөө ажиж өөрийгөө ямар хүн болохыг мэдэх сэн, өөрийгөө алив бүхэнд шалгах сан гэж л зүтгэж байна. Өөрийнхөө муу чанараас ангижрах юм сан гэж шаналж байна. Би амархан гомдомтгой хэтэрхий түргэн онгиороо зантай аж...

(О.Дашибалбар)

... Хэд хоногийн өмнө Третьяковын галерей* үзээд сэтгэл нэг л хачин болж, энэ өрөөнд ядахдаа ганц хонож энэ сүрлэг зургуудыг илбэж нэг үзэх сэн гэж хүртэл бодогдсон шүү...

(О.Дашибалбар)

* Аполлон- Эртний Грекийн яруу найргийн тэнгэр

* галерей- уран зургийн үзэсгэлэн

б. Эдгээр сэтгэгдлийг уншаад чамд ямар мэдрэмж, сэтгэгдэл төрж байна вэ? Төрсөн сэтгэгдлээсээ үүдэн чухам юу хийх хүсэл төрж байгаагаа ярилцаарай.

8. Аяны замд уулзаж учирсан хүмүүсийн хүсэл эрмэлзэл, зан байдал, үзэл бодлыг тэмдэглэлд дүгнэн бичдэг. Ингэхдээ магтаж бахархах, шүүмжилж дургүйцсэн хандлагаа ч илэрхийлж болдог.

а. “Монголчуудын түүх” номоос хэсэглэн авсан тэмдэглэлийг харьцуулан уншаарай.

Татаруудын аятай сайн ааш авирын тухайд

1246 оны 4 сар

Татаруудын* талаар мэдье гэвэл, тэд хорвоогийн бүх хүн хар ч бай, шар ч бай хэнээс ч илүү эзэндээ уг дуугүй захирагдаж, юу юунаас илүү тэднийгээ хүндэтгэж, хэзээ ч эзнээсээ урвадаггүй гэдгийг санах хэрэгтэй.

Тэд хоорондоо маргаж хэрэлдэнэ гэж бараг үгүй, мөн тэнд үнэт зүйл дээрэмдэх, хулгай хийх гэж байхгүй тул гэр орон, тэрэг бараагаа түгжиж цоожлохыг үл мэднэ. Ямар нэг мал алдаж гэмээ нь тэр алдуул малтай дайралдсан хэн боловч нэг бол ийм мал харж адуулах албатай тусгай хүмүүст тууж аваачих буюу үгүй бол зүгээр орхин явна.

Тасхийм хүйтэн, аагим халууны аль алинд ч морь унахдаа тун тэвчээртэй улс. Ер нь тэд эрх танхил булбарай улс биш.

Бие биедээ агаархаж жөтөөрхөх, бие биеэ үзэн ядаж өсөрхөн муудалцах явдал тэдэнд бараг үгүй бөгөөд харин ч чадал чинээнийхээ хэрээр зүйл бүрээр нэг нэгнээ дэмжинэ.

б. Хоёр эхийн нэгийг сонгож цогцолбороор ялгана уу. Цогцолбор бүрийн санааг хэлцээр илэрхийлээрэй. Үлгэрлэвэл:

Морь нохой мэт зүтгэх

Үгийн сайныг хэлж, үнэгэн сүүлээр хуурах

в. Гадны хүний тэмдэглэсэн эдгээр зан чанар бидэнд бий эсэх талаар шүүн хэлэлцээд, сэтгэгдлээ бичээрэй. Үлгэрлэвэл:

Энэ замын тэмдэглэлийн “Татаруудын аятай сайн ааш авирын тухайд” хэсгийг уншаад үзэсгэлэнт баян эх орон, мөнхөд дурсагдах эзэн богд Чингис хаан, уужим ухаант өвөг дээдэс, элбэрэл хайрын дээд ээж ааваараа бахархах, омгорхох сэтгэл өөрийн эрхгүй төрлөө. Ийм л ард түмний үр сад болон төрсөндөө эрэмшинэ. Би ухаантай, зоригтой, эрдэмтэй жинхэнэ эр хүн болж, Монголынхоо нэрийг ертөнцөд дуурсгах болно.

(сурагч Б.Байдар)

г. Аяллын ямар ямар нэвтрүүлэг мэдэх вэ? Аяллын тухай ямар ном уншсан бэ? Тэдгээрийг үзэж, уншихад ямар сэтгэгдэл төрснөө ярилцаарай.

* Татар- XIII-XIV зууны үед монголчуудыг нийтээр нь татар гэж нэрлэж байжээ.

д. Ярьснаа дараах шалгуураар үнэлээрэй.

Шалгуур	Маш сайн	Сайн	Дунд зэрэг	Хангалтгүй
Сэдэв, агуулгын уялдаа холбоо тохирсон уу?				
Сэтгэгдлээ дүрсэлж ярьсан уу?				
Дүгнэлт нь оновчтой болж чадсан уу?				
Нөхцөл байдал, сонсогчоо мэдэрч, дууны өнгөө тохируулсан уу?				
Өөртөө итгэлтэй ярьсан уу?				
Яриа хэт хурдан биш, нийт сурагчдад ойлгогдохоор байсан уу?				

ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

1. Бичсэн эх дараах шалгуурт таарч байвал ✓ тэмдэглэл хийнэ үү?

Шалгуур	Үзүүлэлт
Эхлэл хэсэгт чухал санаа гарсан эсэх	
Чухал санаагаа үргэлжлүүлэн бичиж чадсан эсэх	
Төлөвлөгөөний дагуу үйл явдал өрнөсөн эсэх	
Гол хэсэгт гурваас дээш санаа тусгаж чадсан эсэх	
Уран дүрслэлтэй бичсэн эсэх	
Хэлц үг хэллэг хэрэглэсэн эсэх	
Баталгаатай эх сурвалжаас эш татан бичсэн эсэх	
Байгаль хамгаалах талаар үзэл бодлоо илэрхийлж чадсан эсэх	
Эхлэл, гол, төгсгөл хэсгийг уялдуулан холбож чадсан эсэх	

2. Аян замын тэмдэглэл бичихдээ дараах алхмаар ажилла.

- Интернэтээр аялал жуулчлалын сайт руу орж, монгол хүний заавал очиж үзэх газрууд болон Монголын есөн гайхамшиг, түүх соёлын дурсгалт газраас сонгоорой.
- Сонгосон газрынхаа онцлог байдлын талаар материал цуглуулах
- Ямар асуудлыг хөндөж бичихээ төлөвлөх
- Бичсэнээ дахин дахин унших
- Найруулгын алдааг засаж сайжруулах
- Сийрүүлэн бичих

3. а. Дараах цогцолбор хэдэн үйл явдлаас бүтсэн бэ? Тэдгээр нь хоорондоо хэрхэн холбогдсон байна вэ? б. Дараах өгүүлбэрүүдийн үйл явдал цуварч, эсвэл зэрэгцэж байна уу гэдгийг тодорхойлоорой.

Хацар чимхэх жавартай цагаан хөндийг туулан, өвлийн хатуу хайрууд өлчиржиж, хаврын хахир хавсарганд нүүр нүдгүй шилбүүрдүүлэн өвс мэт газар налтлаа гуядуулж, найртай зуны цэцгэн дунд зовлон бэрхийг мартаж, эрхлэн тарваадсаар намрын хонгор салхинд шувуу буцахын гунигийг даган нулимсаа бөмбөрдүүлж, өвөл, хавар, зун, намрын ааш аранинг авсан билээ.

(Г.Мэнд-Ооёо)



II БҮЛЭГ

БАРИМТ НОТОЛГОО, ДҮГНЭЛТИЙН УЯЛДАА ХОЛБООГ ТОДОРХОЙЛОХ

Эзэмших мэдлэг, чадвар

- Шинжлэх ухааны хялбаршуулсан эхэд байгаа дүгнэлт, баримт нотолгоонд дүн шинжилгээ хийх
- Угсарсан нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээ
- Бичихдээ эшлэл, зүүлт, ном зүй ашиглах

ШИНЖЛЭХ УХААНЫ ХЯЛБАРШУУЛСАН ЭХЭД БАЙГАА ДҮГНЭЛТ, БАРИМТ НОТОЛГООНД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

“Шавж” (1), “Шавж” (2) хоёр эхийг уншихдаа мэргэжлийн үг, нэр томьёог 1, уран дүрслэлийг 2, жишээ, тоо баримтыг 3, сэтгэгдэл мэдрэмжийг 4, дүгнэлтийг 5 гэж тус тус ялган тэмдэглээрэй.

Шавж (1)

...Тусгайлан тооцоолж бодсоноор манай ертөнц дэх шавжийн тоо ойролцоогоор 10^8 миллиард (минимум) болно. Өөрөөр хэлбэл, дэлхийн хүн амын нэг бүрд 250 сая орчим шавж ногдох жишээтэй. Энэ үй түмэн шавж байгалийн элдэв үйл ажиллагаанд маш идэвхтэй оролцоно.

Шавжийн байгаль дахь үүрэг ач холбогдол асар их юм. Шавж олон янзын цэцэгт ургамлын тоосыг хүртээдэг. ...Ургамлын тоос хүртээгч шавжаас нэгдүгээрт хальсан далавчтан ялангуяа балт зөгий, үхэр хэдгэнэ, хоёрдугаарт хос далавчтан, гуравдугаарт хайрсан далавчтан буюу эрвээхэй орно. Хөрс үүсэх процесст шавжууд ялангуяа термит* ба шоргоолжнууд их ач холбогдолтой. Эдгээр нь бусад авгалдайн адил газрын хөрсийг нүхлэн сийрэгжүүлж, агаар, чийг, дулааны солилцоог сайжруулах ба ургамал амьтдын үлдэгдлийг задалж, ялзмагаар баяжуулна. Шавж элдэв амьтдын ялгадас, хүүр, сэг ургамлын хагдралыг задалж, ариутган цэвэрлэх үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ байгаль дахь бодисын эргэлтийг нөхцөлдүүлж түүнийг түргэсгэнэ. Шавж идэштэн шувууд ба сүүгээр бойжигчид цөөнгүй.

Шавжийн байгальд үзүүлэх хор хөнөөл мөн асар их. Манай орны хувьд 1929-1939, 1946-1948, 1954-1956 онд царцаа хадлан, бэлчээрт ихээхэн хохирол учруулж байсан түүхтэй. Царцаанаас гадна няслуур цохны утсан өт, нил хар цохны хуурамч утсан өт үр тарианы ургамлын үндсийг идсэнээс ургац сийрэгждэг бол газар дээрх хэсгийг (иш, навч, түрүү) нь үр тарианы бор бүгэг швед ялаа, бясаа, ургамлын бөөс, навч идэгч цох зэрэг 30 шахам зүйлийн хортон шавж голлон гэмтээдэг.

Манай орны ой модыг Сибирийн хүр эрвээхэй, ерөөсгөл эрвээхэй, якобсоны эрвээхэй, нарсны төөлүүр, сахалт цох зэрэг хортон шавж багагүй гэмтээж байна. 1956 оны судалгаагаар манай орны

* термит- жомны төрлийн шавж

Шавж (2)

Дэлхий дээр шавжгүй газрыг олоход бэрх. Бид тэдэнтэй усанд, агаарт, ойд, цөлд, тариалангийн талбайд, хотод болон газар сайгүй дайралддаг.

Шавж олон янз байдгаараа байгалийг чимж байдаг. Эрвээхэйг цэцэгтэй зүйрлэх дуртай байдаг. Тэр бүү хэл, шавжийн хээ угалз шиг гайхамшигтай зохицсон будаг цэцгэнд ч ховор тохиолдоно. Тиймээс эрвээхэйн далавчны хээг хувцасны шинэ хэв маяг зохиоход ашигладаг нь тохиолдлын хэрэг биш.

Гэвч шавж биднийг үргэлж баярлуулж байдаггүй, заримдаа бидэнд өөрийнхөө аймшигт хүчийг харуулдаг билээ. Жишээлбэл, 1930-аад оны үед Африкт өргөнөөрөө нэлээд хэдэн километр зай эзэлсэн царцааны сүрэг гурван өдрийн турш үргэлжлэн нисэж, буух үед нь тэдний хүнд жинд мод хугарч байсан бол, хэдэн зуун км үргэлжилсэн энэ замд нэг ч ургамал үлдэлгүй зөвхөн хар зурвас газар үлдсэнийг эрдэмтэд ажиглажээ. Ийм царцаа Ази, Африкийн орнуудын олон сая га үр тариаг устгасан баримт бий.

Шавж бол хумхаа мэтийн аюултай өвчнийг тараах ба адгуусан амьтныг шимэгчлэх, таримал ургамлыг идэж сүйтгэхээс гадна ургамлын тоос хүртээж, бидний зарим дайсныг устган,

ойн 63790 га талбайд Сибирийн хүр эрвээхэй (*Dendrolimus sibiricus*) тархан дэлгэрч, 17700 га талбайн хар модыг идэж сүйтгэснээс бүрмөсөн хатаж байжээ.

Хүн ба адгуусан амьтдыг паразитлагч шавж асар олон бий. Хөх түрүү, шумуул, дэлэнч зэрэг хос далавчтан шавж хүн, сүүн гэжээлт амьтдын цусыг сорж амьдардаг. Зарим шавж элдэв халдварт өвчнийг тараан дамжуулдаг. Ийм шавжийн нэг бол Африкийн өмнөд ба төв хэсэгт тархсан цеце ялаа (*cloosina*). Бүүрэг бол хүн, амьтдад тахал тараагч гол эзэн. Хүн ба амьтны бөөснөөс (*anoplura*) гадна шалз, ширх зэрэг (*mallorngo*) эктопаразит нь амьтдын өд, хайрс, үсээр хооллож, гэмтэл учруулна. Амьтдын бие дотор амьдардаг (эндопаразит) шавж цөөнгүй.

(Чөлөөт нэвтэрхий толь-Википедиагаас)

• торгоны мяндас, бал гаргаж өгдөг билээ.

(Биологийн ухааны дэд эрдэмтэн Л.Медведев, Шинжлэх ухаан амьдрал сэтгүүл, №2, УБ., 1973)

Асуулт даалгавар

1. Энэ хоёр эх дэх шавжийн тоо, ач холбогдол, хор хөнөөлийг илэрхийлсэн хэсэг тус бүрээс гол санаа илэрхийлсэн өгүүлбэрийг олж бичнэ үү. Эдгээрийг юугаар, яаж дэлгэрүүлэн тайлбарласныг ярилцаарай.

Тайлбарласан зүйл	Тайлбарласан арга	
	Шавж (1)	Шавж (2)
Шавжийн тоо		
Шавжийн ач холбогдол		
Шавжийн хор хөнөөл		

2. Хоёр эхээс баримт, дүгнэлт, нэр томьёо, уран дүрслэл, зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлсэн хэсгийг олж, эдгээрийг ямар зорилгоор ашигласныг ярилцъя.

Асуулт	Шавж (1)	Шавж (2)
Баримт		
Дүгнэлт		
Нэр томьёо		
Дүрслэл		
Мэдрэмж сэтгэгдэл		

3. Эндээс дүгнэлт хийе.

- Хоёр эхийг хэнд зориулж, ямар зорилгоор бичсэн бэ?
- Эхийн сэдэв юу вэ?
- Дээрх дүгнэлт, дараах тайлбар зэрэгт үндэслэн “Шавж (1)”, “Шавж (2)” гэсэн хоёр эхийн аль нь шинжлэх ухааны хялбаршуулсан эх болохыг ярилцаж, тодорхойлно уу.

Шинжлэх ухааны хялбаршуулсан эх

Шинжлэх ухаан, техник технологийн нээлт, ололт амжилт, шинэ содон юм, үзэгдэл, ойлголтыг өргөн олон уншигч, сонсогчдод тайлбарлан таниулсан бүтээлүүд байдаг. Ийм бүтээлийг шинжлэх ухааны хялбаршуулсан эх (зохиол) гэдэг. Ийм зохиолд янз бүрийн боловсрол, ажил мэргэжилтэй хүмүүс буюу олон нийтэд зориулсан ном товхимол, өгүүлэл, тайлбар, таницуулга зэрэг багтана.

Шинжлэх ухааны хялбаршуулсан эх нь уншигч, сонсогчдод ойлгомжтой байдаг онцлогтой. Учир нь:

1. Мэргэжлийн нэр томъёо харьцангуй цөөн.
2. Хааяа уран дүрслэлийн аргыг ашигласан байдаг.
3. Үгийг шилжсэн утгаар нь сонгож болдог.
4. Тодотгол тайлбар, жишээ ихтэй.
5. Хүснэгт, загвар, эшлэл, зүүлт ашигладаггүй.

Жишээ нь:

... Говийг үхмэл цөл гэж үздэг хүмүүс олон. Гэтэл говь маань Хятадын өмнөд нутагт үржил шимийг хүргэж өгдөг гэж уншигч та дуулсан уу? Говь нутгийн чулуу гэнэт хөрч халснаас болж, бутарч нунтаг болохыг алтан хэмэрлэг боллоо гэх бөгөөд энэ хэмэрлэг салхинд хийсэж өмнө зүг нүүдэг байна. Салхин унаа хөлөглөж, олон зуун жилийн турш өмнө зүг нүүсээр Хөх мөрний сав зэрэг газар алтан хэмэрлэг хөрс тогтсон байдаг. Энэ хөрс үржил шим сайн учир тэнд баян амьдрал өрнөжээ.

Энэ эхэд адилтгал (цөл үхэх, алтан хэмэрлэг), амьдчилал (говь ... хүргэж өгөх, салхин унаа хөлөглөх) зэрэг уран дүрслэл ашиглаж, найруулгыг хялбаршуулсан байна. Мөн “... гэж үздэг хүмүүс олон, ... гэж уншигч та дуулсан уу?”, “... алтан хэмэрлэг боллоо гэх” зэргээр зохиогч бусдын санаа бодлыг эш татан уншигчдад хандсан нь итгэл үнэмшил төрүүлэхээр болжээ.

г. “Шавж (1)”, “Шавж (2)” хоёр эхийн алийг нь шинжлэх ухааны хялбаршуулсан эх гэж үзсэнээ тайлбарлаж бичнэ үү. Говийн тухай тайлбарласныг дуурайж, тайлбар бичээрэй.

Шинжлэх ухааны хялбаршуулсан эхийг судалъя.

“Монголд цоохор нуур, цэхэр уул, саарал говь бий” эхийг уншихдаа дараах асуултад хариулт олохыг хичээгээрэй.

- Судалгаа хийх зорилгыг яаж гаргасан бэ?
- Газар усны нэрийн утгыг ямар аргаар тайлбарласан байна вэ?
- Уншигчийн сонирхол татах ямар арга хэрэглэсэн байна?
- Дүгнэлт нь аль вэ?

Монголд цоохор нуур, цэхэр уул, саарал говь бий

(Газар усны нэр судлал буюу топонимикийн тухай)

Үгийн санд газар усны нэрийг судлах ухаан байх агаад тэр ухааныг олон улсын нэр томъёогоор топонимикс (toponymics) хэмээнэ. Газар усны нэр судлал хэмээх ухаан чухам юуг сонирхон үздэгийг харуулах үүднээс хэдэн жилийн өмнө хийж байсан нэгэн бичил судалгаанаас та бүхэнд толилуулсу.

Өмнө дурдсанчлан монголчууд газар усны хэлбэр хэмжээ, овор дүр, байгалийн баялаг зэргээр нь нэрийдэхээс гадна өнгө зүсээр нэрлэх нь ихэд түгээмэл байна. Монголчууд ямар өнгөөр уул усаа илүүтэй нэрлэдэг, газрын нэрд орохдоо ямар өнгө юуг бэлгэддэг, өнгөний цаана өөр далд утга байж болох эсэхийг тодорхойлох үүднээс ардын багш цол хүртсэн Ш.Шагдар багшийн “Монгол газар зүйн нэрийн товч толь бичиг” дэх өнгөөр нэрлэсэн газар усны нэрийг түүж ажиглав. Уг тольд нийт 8000 орчим нэр орсноос 4200 нь уул нуруу, тал хөндий, 520 гаруй нь гол мөрөн, 230 орчим нь нуур цөөрөм, 290 орчим нь элс, говь нутаг аж. Ер нь мэргэжлийн хүмүүс болон нутгийн ардын тооцоогоор Монгол орны 1.5-2 ам дөрвөлжин километр нутаг бүр өөрийн гэсэн оноосон нэртэй байдаг гэнэ. Энэ тооцоогоор бодвол, Монгол улсын одоогийн нутаг дэвсгэр нэг сая шахам газар усны нэртэй байх нь.

Толь бичиг дэх 8000 гаруй нэрээс өнгөөр нэрийдсэн 830 нэрийг бүртгэсэн нь монгол газар усны нийт нэрийн 10 илүү хувь нь өнгөөр нэрлэгдсэн байдаг гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Хэрвээ өнгө заасан үг орсон бүхнийг бүртгэсэн бол үүнээс хавьгүй их тоо гарах байлаа. Тухайлбал, Улаан уул гэснийг оруулахаас бус, Улаан ямаат уул гэсэн нэр нь уулын улааныг биш, ямааны улааныг заасны учир бүртгэлдээ оруулсангүй.

Ингээд өнгө бүрийг давтамжаар нь дараалуулан авч үзье. Өнгөөр нэрийдсэн газар усны нийт нэрийн 185 нь буюу 22.2% “цагаан” байгаа нь хамгийн өндөр давтамж болж байна. Тал нутгийнхан газар усаа “цагаан” хэмээн нэрлэх илүү дуртай бололтой. Зөвхөн Сүхбаатар аймагт гэхэд 17 цагаан уул, 3 цагаан нуур байхад, Дорнод аймагт 8 цагаан уул, 4 цагаан гол байна.

Удаад нь “улаан” орно. Улаан өнгө нь уулын тодотгол болох нь ихэд түгээмэл юм. Нийт 142 “улаан” газар уснаас 104 нь уул аж. Манай говьд улаан газар их байдаг юм байна. Монгол даяар байгаа 19 улаан нуурын 12 нь зөвхөн Дундговь, Дорноговь аймагт оршдог ажээ.

“Хар” өнгөтэй газар усны нэр нийт өнгө бүхий нэрсийн 12.4% (105)-ийг эзэлж байна. Газар усны нэрийг дотор нь хуурай газрын нэр буюу ороним, усны нэр буюу хидроним хэмээн ангилдаг бөгөөд монголчууд хидроним, ялангуяа гол горхио хар өнгөөр тодотгох дургүй хүмүүс аж. Ердөө хоёрхон хар гол Монгол нутгаар урсаж байна.

“Хөх” өнгөөр тодотгосон газар усны нэр 72 (8.67) байгааг харахад ихэнх нь уул бөгөөд мөн л хөх гол горхи гэж бараг байдаггүй юм байна. Уул, нуур зэрэг тогтвортой газрууд “хөх”, харин гол горхи зэрэг хөдөлгөөнт газар ус “цэнхэр” байдаг аж.

Үүнээс цааш “шар”, “шарга” (65), хүрэн (51) газрууд дараална. Хүрэн, бор хоёр хидроним буюу усны нэрд огт тохиолддоггүй. Үүнчлэн 27 “буурал”, 25 “алаг”, 20 “эрээн”, бас 20 “хонгор” газар бүртгэгдэв. 12 “цэнхэр” газар усны нэрийн 5 нь гол бөгөөд “цэнхэр” уул, нуруу гэж бараг байдаггүй нь тогтонги газар усыг монголчууд “хөх” гэж нэрлэдэг уламжлалтай холбоотой.

Цаашилбал, “ухаа” (11), “гялгар, гялаан” (10), “ногоон” (8), “цэгээн” (7), халтар (6) газар ус цөөн боловч байна. Хамгийн ховор газруудыг тоочиход Монгол нутагт 4 “халиун” уул, 2 “цоохор” уул, нэжгээд “ягаан” уул, тал, 2 “загал” уул, 1 “саарал” говь болон нэжгээд “цэхэр” уул болон гол оршдог аж.

Өнгөөр газар усыг нэрлэхдээ монголчууд голчлон уг газрын жинхэнэ өнгийг харгалздаг байна. Энэ уламжлал өнөөг хүргэл үргэлжилж байгаа бөгөөд ойрхны жишээ татахад 1957 онд Говь-Алтай аймагт газар хөдлөлтөөр хэд хэдэн нуур үүссэн нь цайвар ногоон, хар ногоон болон хар өнгөтэй байсан тул судлаачид анх Билүүтийн ногоон нуур, Улиастайн ногоон нуур, Улиастайн хар нуур хэмээн нэрийдсэн байна. Гэвч нуггийн ард түмэн хожим нь эдгээр нуурын нэрийг уг өнгийг хадгалсан эрдэнийн чулууд болгон Оюу, Номин, Биндэрьяа хэмээн солин нэрлэжээ.

Маш сонирхолтой нэгэн зүйл болбоос, газар усны нэр дэх өнгө нь олон тохиолдолд жинхэнэ өнгөнөөсөө өөр утгыг илэрхийлдэг явдал юм. Бидний дээр гаргасан тооцоогоор цагаан, улаан, хөх (цэнхэр), хар, шар (шарга) гэсэн таван өнгө газар усны нэрд хамгийн түгээмэл бөгөөд нийт өнгөөр нэрийдсэн газар усны нэрийн 70 орчим хувийг эзэлж байна. Гэтэл эртний монгол-түрэг соёлд энэ таван өнгө үндсэн дөрвөн зүг болон төвийг илтгэдэг байсан байна. Үүнд, зүүн зүг-хөх, урд зүг-улаан, баруун зүг-цагаан, хойд зүг-хар өнгөтэй дүйх бөгөөд шар өнгөөр төв хэсгийг бэлгэддэг байв. Судлаач Н.Л.Жуковская яг энэ бэлгэдлийг баримтлан Чингис хааны үр сад Их Монгол улсын баруун хэсгийг “Цагаан орд”, зүүн хэсгийг “Хөх орд” хэмээн нэрлэсэн гэж үзсэн байна. Түүнийхээр монголчууд Оросын хааныг “Баатар цагаан хаан”, “цагаан орос” хэмээн хэлэлцдэг нь мөн баруун зүгийг заасан үг гэнэ.

... Газар усны нэрд өнгө жинхэнэ утгаараа болон зүг чиг зааж орохоос гадна өөр бусад утгыг зааж болохыг үгүйсгэх аргагүй. Жишээ нь: зөвхөн “хар” гэсэн үг монгол, түрэг хэлнүүдэд ямар ямар утга илэрхийлдгийг бүртгэн үзвэл: 1. хар өнгө, 2. дан (хар цай гэвэл хар өнгөтэй цай бус, сүүгүй дан хар цай, хар шөл гэвэл махнаас өөр юмгүй дан шөл, радиод хар яриа гэвэл хөгжимгүй дан яриаг хэлдэг.) 3. том (киргиз: кара мал буюу хар мал- бод мал), 4. хүчтэй, чанга (хар шуурга, хар эрчээрээ), 5. газрын, хөрсний (турк: кара сулари буюу хар ус- газрын ус), 6. тоолшгүй, маш их (хар мянга), 7. доод язгуурын, энгийн (хар ажил, хар хүн, харц ард) гэх мэт.

Өнгөний талаар цаашид сонирхон судалъя хэмээвээс С. Дулам багшийн бичсэн “Монгол бэлгэдэл зүй” номыг уншихыг зөвлөөд газар усны нэрэн дэх өнгөний талаар хийсэн бичил судалгаанаасаа хоёр сонирхолтой ажиглалт дурдан өгүүлээ өндөрлөсү.

Хар-цагаан, хөх-цэнхэр, хүрэн-бор гэсэн эсрэгцлээр газар усны нэрүүдийг авч үзэхэд өнгө нь улам гүн, бараан болох тусмаа уг газар нь өндөр, ус нь гүнзгий, тогтвортой болж байхад эсрэгээрээ цайвар, гэрэлтэй өнгөөр хөдлөнгө, гүехэн ус хийгээд нам доор газрыг нэрлэдэг байна.

Монгол хэлэнд зэрэгцсэн тодотголууд хатуу дэс дараатай байдаг. Гурван том хар чулуу гэхэд эхлээд тоо, дараа нь хэлбэр хэмжээ, хамгийн сүүлд өнгө заасан тодотгол нэрийн өмнө байрлана. Хар гурван том чулуу гэж ярихгүй. Гэтэл маш олон газар усны нэрд Улаан өндөр уул, Хар өндөр уул гэсэн дараалал тохиолдож байна.

М. Саруул-Эрдэнэ

Эхийн агуулгыг судалъя.

1. Дараах асуултын хариултыг гүйцээж бичээрэй.

Асуулт	Хариулт
Яагаад судалгаа хийх болов?	
Юуг судлав?	
Судалгаанд юу ашиглав?	
Яаж судлав?	1. Өнгөөр нэрлэсэн газар усны нэрийг түүж, давтамжийг тооцоолсон. 2. Газар усыг нэрлэсэн өнгөний утгыг харьцуулсан.
Судалгаанаас юу юу илрэв?	1. Уг тольд нийт 8000 орчим нэр орсноос , 290 орчим нь элс, говь нутаг. 2. цагаан-185, улаан-142, хар-105, шар, шарга- 65, буурал-27, алаг-25, эрээн-20 ... гэх мэтээр өнгө тус бүрээр нэрлэгдсэн газар усны нэрийг тоолж, тооцоолсон.
Ямар ямар дүгнэлт хийв?	1. Монгол газар усны нийт нэрийн 10 илүү хувь нь өнгөөр нэрлэгдсэн байдаг. 2. Газар усыг нэрлэхдээ: а. голчлон уг газрын жинхэнэ өнгийг харгалздаг, б. , в. бусад утга зааж болохыг үгүйсгэх аргагүй.
Дүгнэлт бүрийг юугаар дэлгэрүүлж тайлбарласан бэ?	2.а. 2.б. байсныг тайлбарлаж, Жуковскаягийн судалгаанаас эш татсан. 2.в. “хар” гэсэн үг монгол, түрэг хэлэнд ямар ямар утга илэрхийлдгийг тайлбарласан.

2. Эхэд задлал хийж, нэгтгэн дүгнэе.

а. Зохиогч яагаад энэ эхийг бичих болсны учрыг тайлбарлана уу.

б. Юуг үндэслэж “Монгол газар усны нийт нэрийн 10 илүү хувь нь өнгөөр нэрлэгдсэн” гэж дүгнэсэн бэ?

в. Эхийн агуулгыг эргэцүүлэн бодоод, бүтцийг нь загварчилна уу. 13-р хуудасны тулгуур бичиглэлийг үлгэр болгоорой.

Эхлэл

Гол хэсэг

Төгсгөл

3. Эх нь шинжлэх ухааны хялбаршуулсан эх мөн гэдгийг баталъя.

а. Эхээс мэргэжлийн үг, нэр томъёог түүж бичээд, утгыг нь тодруулан тайлбарлана уу.

Мэргэжлийн хүмүүсийн ярианы хэлэнд тархсан, албан ёсны бус үг хэллэгийг мэргэжлийн үг гэнэ. Шинжлэх ухаан, техник технологи, улс төр, нийгмийн салбарт тогтмол нэг утгаар хэрэглэгдэх тусгай тогтоосон үгийг нэр томъёо гэнэ.


б. Эхэд уран дүрслэл, шилжсэн утгаар нь хэрэглэсэн үг байна уу? Яагаад хэрэглэсний учрыг тайлбарлаарай.

в. Эхийг сонирхолтой болгосон ямар хэсэг байна? Зохиогч яагаад эхийг “Монголд цоохор нуур, цэхэр уул, саарал говь бий” гэж нэрлэсэн бэ?

г. Эхээс баримт, дүгнэлт, тайлбар, таамаглалыг ялгаж, эдгээрийн холбоо хамаарлыг тайлбарлана уу. Үүнийг 2-р цогцолбороор үлгэрлэн үзүүлэв. Эхийн бусад хэсгээс сонгон, энэ аргаар ажиллаарай.

1	<i>Өмнө дурдсанчлан монголчууд газар усны хэлбэр хэмжээ, овор дүр, байгалийн баялаг зэргээр нь нэрийдэхээс гадна өнгө зүсээр нэрлэх нь ихэд түгээмэл байна.</i>	Дүгнэлт
2	<i>Монголчууд ямар өнгөөр уул усаа илүүтэй нэрлэдэг, газрын нэрд орохдоо ямар өнгө юуг бэлгэддэг, өнгөний цаана өөр далд утга байж болох эсэхийг тодорхойлох үүднээс ардын багш цол хүртсэн Ш.Шагдар багшийн “Монгол газар зүйн нэрийн товч толь бичиг” дэх өнгөөр нэрлэсэн газар усны нэрийг түүж ажиглав.</i>	Тайлбар
3	<i>Уг тольд нийт 8000 орчим нэр орсноос 4200 нь уул нуруу, тал хөндий, 520 гаруй нь гол мөрөн, 230 орчим нь нуур цөөрөм, 290 орчим нь элс, говь нутаг аж.</i>	Баримт
4	<i>Ер нь мэргэжлийн хүмүүс болон нутгийн ардын тооцоогоор Монгол орны 1.5-2 ам дөрвөлжин километр нутаг бүр өөрийн гэсэн оноосон нэртэй байдаг гэнэ. Энэ тооцоогоор бодвол, Монгол улсын одоогийн нутаг дэвсгэр нэг сая шахам газар усны нэртэй байх нь.</i>	Таамаглал

д. Зохиогчийн бичлэгийн онцлогоос шалтгаалж, зарим нь судалгаанаас хийсэн дүгнэлтээ эхэлж бичээд, дараа нь баримтаар баталж тайлбарладаг бол зарим нь баримт нотолгоог эхэлж дурдаад дараа нь дүгнэн бичдэг. Энэ эхийн бичлэг аль загварт нь тохирч байна вэ?



е. Аль загварыг нь сонгосон үндэслэлээ тайлбарлан бичнэ үү. Бичихдээ эхэд зохиогчийн хэдэн дүгнэлт байгаа, үүнээс хэд нь цогцолборын эхэнд, эсвэл төгсгөлд байгааг тооцоолж, үндэслэл болгоорой.

УГСАРСАН НИЙЛМЭЛ ӨГҮҮЛБЭРИЙН УТГА, БҮТЭЦ, ХЭРЭГЛЭЭ

1. Угсруулах холбоонд суурилсан үг, өгүүлбэрийг сэргээн санацгаая.


а. Дараах нийлмэл үгсийн холбогдсон аргыг ажиглаад, хоёр хэсэг болгон бичээрэй.

үхэр хэдгэнэ, балт зөгий, сарьсан далавчтан, өрөөсгөл эрвээхэй, нарсны төөлүүр, сахалт цох, хөх түрүү, алтан харгана, таван салаа, усан үзэм, өмхий өвс, газрын сорвоо, үхэр гоньд, морин шарилж, ямаан ари

б. Дараах өгүүлбэрийг чөлөөт холбоо үг болгон задлаад, дагуул үг, цөм үгийг ялгана уу. Үлгэрлэвэл:



в. Нийлмэл үгийн талаарх мэдлэгээ сэргээн ярилцана уу.



г. Дараах хоёр өгүүлбэрийн утга, бүтцийг ажиглаад, нийлмэл өгүүлбэр яаж холбогдож байгааг дүгнээрэй.

Ажиллах өгүүлбэр:

(А) Бидний дээр гаргасан тооцоогоор цагаан, улаан, хөх (цэнхэр), хар, шар (шарга) гэсэн таван өнгө газар усны нэрд хамгийн түгээмэл.

(Б) Хэрвээ өнгө заасан үг орсон бүхнийг бүртгэсэн бол үүнээс хавьгүй их тоо гарах байлаа.

2. Угсарсан нийлмэл өгүүлбэрийг задлан шинжилж, онцлогийг нь мэдье.

а. Гишүүн өгүүлбэрийг дараах асуултын дарааллаар шинжилж, ямар гишүүн өгүүлбэр болохыг таамаглан дүгнэнэ үү.

- Нийлмэл өгүүлбэр хэдэн энгийн өгүүлбэрээс бүтсэн байна? Тус бүрийн өгүүлэхүүн гишүүнийг зурж тэмдэглээрэй.
- Энгийн өгүүлбэрүүд ямар аргаар холбогдсон байна вэ? (нөхцөлөөр, холбох үгээр)
- Гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн нь гол өгүүлбэрийн ямар гишүүнд захирагдсан байна вэ?
- Гишүүн өгүүлбэр бүхэлдээ ямар гишүүний асуултад хариулагдаж байна вэ?


- Гол өгүүлбэрийг ямар утгаар нэмэн дэлгэрүүлж байна вэ? (шалтгааны, орны, цагийн, зорилгын гэх мэт)
- Гол өгүүлбэрт ямар гишүүний үүрэгтэй байна вэ?
- Нийлмэл өгүүлбэрийн бүтцийг тодорхойлоорой.

Ажиллах өгүүлбэр:

1. Амьтдын бие дотор амьдардаг шавж цөөнгүй.
2. Зөвхөн хар зурвас газар үлдсэнийг эрдэмтэд ажиглажээ.
3. Үр тарианы ургамлын үндсийг өт идсэнээс ургац сийрэгждэг.
4. Газар усны нэрд өнгө жинхэнэ утгаараа болон зүг чиг зааж орсноороо ялгагдаж байна.
5. Монголчууд газар усны хэлбэр хэмжээ, овор дүр, байгалийн баялаг зэргээр нь нэрийдэхээс гадна өнгө зүсээр нэрлэх нь ихэд түгээмэл байна.

б. Нийлмэл өгүүлбэрт гишүүн өгүүлбэр ямар утга, үүрэгтэй байгааг эргэцүүлж, тохирох тодорхойлолтын ард ямар гишүүн өгүүлбэр болохыг нь бичээрэй. Мөн тохирох өгүүлбэрийн дугаарыг тэмдэглээрэй.

- Шууд тусагдахуун гишүүн өгүүлбэр
- Шууд бус тусагдахуун гишүүн өгүүлбэр
- Тодотгол гишүүн өгүүлбэр
- Байц гишүүн өгүүлбэр
- Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр



Тодорхойлолт	Гишүүн өгүүлбэр	Тохирох өгүүлбэр
Гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн нь харьяалахын тийн ялгал болон үйлийн тодотгон холбохын нөхцөлөөр хэлбэржин, гол өгүүлбэрийн нэрээр илэрсэн гишүүнд захирагдаж, түүнийг тодотгох үүрэг бүхий өгүүлбэр <u>Асуулт:</u> ямар, аль, яасан, яах, яадаг; яасны, яадгийн	<i>Тодотгол гишүүн өгүүлбэр</i>	<i>1-р өгүүлбэр</i>
Гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн нь өгөх-орших, гарах, үйлдэх, хамтрахын тийн ялгалаар хэлбэржиж, гол өгүүлбэрийн өгүүлэхүүнд захирагдсан өгүүлбэр. <u>Асуулт:</u> яаснаар, яасанд, яаснаас, яасантай		
Гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн нь заахын тийн ялгалаар хэлбэржиж, гол өгүүлбэрийн өгүүлэхүүнд захирагдсан өгүүлбэр. <u>Асуулт:</u> яасныг, яасан тухай		
Гол өгүүлбэрийнхээ өгүүлэхүүнд захирагдаж, түүнийг шалтгаан, зорилго, дүр байдал, орон, цагийн утгаар нэмэн дэлгэрүүлэх үүрэг бүхий өгүүлбэр. <u>Асуулт:</u> • Шалтгааны: яагаад, ямар учраас, юуны учир, юуны тул • Орны: хаана, хаагуур, хаанаас, хаашаа • Цагийн: хэзээ, хэдийд, хэдий үеэс, хэзээнээс, аль үеэс • Зорилгын: яахаар, яах гэж		
Гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн нь нэрлэхийн тийн ялгалаар хэлбэржиж, гол өгүүлбэртээ өгүүлэгдэхүүний үүрэгтэй байна. Гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн нь “минь, чинь, нь, бол, хүртэл” зэрэг тодотчилогчтой байдаг. <u>Асуулт:</u> яах нь, яадаг нь, яасан нь		

Угсарсан нийлмэл өгүүлбэр

Хэд хэдэн үйл явдал бие биеэс үл хамааран зэрэг болохоос гадна бие биеэс хамаарсан дарааллаар өрнөдөг. Жишээ нь: “Газар усны нэрийг дотор нь хуурай газрын нэр буюу ороним, усны нэр буюу хидроним хэмээн ангилдаг бөгөөд монголчууд хидроним, ялангуяа гол горхио хар өнгөөр тодотгох дуртай хүмүүс аж.” гэсэн өгүүлбэр нь “бөгөөд” гэдэг холбоос үгээр холбогдсон, учир зүйн хувьд хоорондоо хамааралтай биш байна.

Үйл явдал дараалж болоход аль нэг үйл явдал нь гол үүрэгтэй байна. Иймээс угсарсан нийлмэл өгүүлбэр нь гол өгүүлбэр, гишүүн өгүүлбэр гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

Гол өгүүлбэрийн утгыг нэмэн дэлгэрүүлж, түүнд захирагдаж, ямар нэг гишүүний үүрэг гүйцэтгэж байгаа өгүүлбэрийг гишүүн өгүүлбэр гэнэ.

Гишүүн өгүүлбэрээр утга нь дэлгэрч, дагуулж захирсан өгүүлбэрийг гол өгүүлбэр гэнэ.

нөхцөлөөр холбогдсон

1. Өнгөөр газар усыг нэрлэх-д-ээ (гишүүн өгүүлбэр)
2. монголчууд уг газрын жинхэнэ өнгийг харгалздаг байна. (гол өгүүлбэр)

Гол өгүүлбэрийн “харгалздаг” гэсэн үйл үгэнд “өнгөөр газар усыг нэрлэхдээ” гэсэн гишүүн өгүүлбэр захирагдаж байна.


Гишүүн өгүүлбэрийг гол өгүүлбэрт ямар гишүүний үүрэг гүйцэтгэж байгаагаар нь тодотгол гишүүн өгүүлбэр, шууд ба шууд бус тусагдахуун гишүүн өгүүлбэр, байц гишүүн өгүүлбэр гэж ангилдаг. Жишээ нь:

юуны?
(1) Шавж-ны хор хөнөөл^{ж.н} асар их.


Энэ өгүүлбэрт (1) “шавжийн” гэсэн үг нь нэр үгээр илэрсэн гишүүнд захирагдан, юуны? гэсэн асуултад хариулагдаж, **тодотгол гишүүн** болно.

ямар? яах?
(2) [Шавжийн байгальд үзүүл-х] хор хөнөөл^{ж.н} асар их.

“Шавжийн байгальд үзүүлэх” гэсэн өгүүлбэр (2) нь гол өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн гишүүнд захирагдаж, уул өгүүлбэр нь ямар? гэсэн асуултад хариулагдаж байгаа тул **тодотгол гишүүн өгүүлбэр** болно.



3. Угсарсан нийлмэл өгүүлбэрийг задлан шинжилж, гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүнийг утга, хэлбэрийн талаас тодорхойлж. Тодорхойлохдоо дараах загварыг ашиглаарай.



Үлгэрлэвэл:


1. 1957 онд Говь-Алтай аймагт газар хөдлөлтөөр **үүс-сэн**
2. хэд хэдэн нуур цайвар ногоон, хар ногоон болон хар өнгөтэй байжээ.

үүс-сэн

1. “нуур” хэмээх үгэнд найран захирагдах ба
2. өнгөрсөн цагийг заасан утгатай
3. үйлийн тодотгон холбохын “-сэн” нөхцөлөөр хэлбэржиж
4. “үүдэх, эхлэх, бий болох”* гэсэн утгатай
5. эс тусах үйл үгээр илэрсэн
6. тодотгол гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн гишүүн болно.

Ажиллах өгүүлбэр:

- Газар усны нэрийг судлах ухаан чухам юуг сонирхон үздэгийг харуулья.
- Хэдэн жилийн өмнө хийж байсан нэгэн бичил судалгаанаас та бүхэнд толилуулсу.
- “Хөх” өнгөөр тодотгосон газар усны нэр 72 (8.67) байгааг харахад ихэнх нь уул байна.
- Хэрвээ өнгө заасан үг орсон бүхнийг бүртгэсэн бол үүнээс хавьгүй их тоо гарах байлаа.



*“үүсэх”- үгийн утгыг монгол хэлний тайлбар толь (хэвлэмэл, цахим)-иос тодруулж ярилцаарай.

4. Угсарсан нийлмэл өгүүлбэрийн мэдлэгээ хэрэглэе.

Дараах өгүүлбэрүүдийг ажиглаад:

- а. Хэдэн өгүүлэхүүн төвтэй байна вэ? Задлал хийж харьцуулаад, дүгнэлт гаргана уу.
 б. Онцолсон холбоосыг өөр ямар үг, нөхцөлөөр солин найруулж болох вэ? Угсарсан нийлмэл өгүүлбэрийг хувиргаж найруулаарай.

- Монголчууд ямар өнгөөр уул усаа илүүтэй нэрлэдэг, газрын нэрд орохдоо ямар өнгө юуг бэлгэддэг, өнгөний цаана өөр далд утга байж болох эсэхийг тодорхойлох **үүднээс** ардын багш цол хүртсэн Ш.Шагдар багшийн “Монгол газар зүйн нэрийн товч толь бичиг” дэх өнгөөр нэрлэсэн газар усны нэрийг түүж ажиглав.
 - “Хөх” өнгөөр тодотгосон газар усны нэр 72 (8.67) байгааг **харахад** ихэнх нь уул бөгөөд мөн л хөх гол горхи гэж бараг байдаггүй юм байна. Уул, нуур зэрэг тогтвортой газрууд “хөх”, харин гол горхи зэрэг хөдөлгөөнт газар ус “цэнхэр” байдаг аж.
 - Улаан ямаат уулын нэр нь ямааны улааныг заасны **учир** бүртгэлдээ оруулсангүй.
- в. Эхийн 3-р (Толь бичиг дэх 8000 гаруй... оруулсангүй) цогцолборт байгаа өгүүлбэрүүдийг дараах маягаар тонгоргон найруулж бичнэ үү.

Уг өгүүлбэр



Тонгоргож найруулсан хувилбар

Өнгөөр газар усыг нэрлэхдээ (1) Монголчууд голчлон уг газрын жинхэнэ монголчууд голчлон уг газрын жинхэнэ өнгийг харгалзаж, (2) газар усыг өнгөөр өнгийг харгалздаг байна. (2) нь нэрлэдэг байна. (1)

- г. Дараах өгүүлбэрийн гол ба гишүүн өгүүлбэрийг сольж, утгыг нь алдагдуулахгүй найруулна уу. Ямар өөрчлөлт гарч байгааг ярилцаарай.

Ажиллах өгүүлбэр:

- Гурван ямхын хулсан үзгийг барьж, эндүү ташаа бичих минь гутал оймсыг баргал явж, нэр ашгийг хөөхөөс дээр. (Гулиранс)
- Хар ус нуурын мандалд лянхуа цэцэг дэлгэрсэн тэр цагаар би Явуугийн гаргасан алдарт шүлгүүдийн мөрөөр тэнд анх очсон юм. (С.Эрдэнэ)
- Гэгээн эрдмийн үрийг суулгаа нь үгүйсэн бол орчлонг таних оюун хаанаас тодрох билээ. (Д.Отгонсүрэн)
- Уран Занабазарын нүдний ур, ухааны ур, гарын ур гурав хэрхэн цогцолсныг түүний ногоон дар эх, цагаан дар эхийн нууц увдисаас мэдэж болно. (Д.Даржаа)

- д. Энгийн өгүүлбэрийг тохирох холбоосоор холбож, зөв найруулгатай нийлмэл өгүүлбэр бүтээж бичээрэй.

“Хөх” өнгөөр тодотго-	-сон -х -дог	газар усны нэр 72 (8.67) байгааг хар-	-х-д -х-аар -вал -тал	ихэнх нь уул байна.
-----------------------	--------------------	--	--------------------------------	---------------------

- Өгүүлбэрийн холбоосыг солиход утга, бүтцэд ямар өөрчлөлт гарч буйг ярилцаарай.
- Зохиосон өгүүлбэрээ гишүүдээр ялган тэмдэглэнэ үү.

БИЧИХДЭЭ ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ, НОМ ЗҮЙ АШИГЛАХ

1. “Тогтвортой хэллэгийг үндэстний сэтгэлгээний баримт гэж үзэхийн учир” өгүүллийн хэсэгт эх сурвалжийг яаж тэмдэглэснийг ажиглаарай. Эшлэл, зүүлт, ном зүйг бичвэрийн хаана, яаж тэмдэглэсэн байна вэ?

Тогтвортой хэллэгийг үндэстний сэтгэлгээний

баримт гэж үзэхийн учир*

Зүүлтийн
тэмдэг

... Өвөрмөц хэллэгийг нэг хэлнээс нөгөө хэлэнд орчуулах нь байтугай төрөлх хэлнийхээ зарим өвөрмөц хэллэгийн утгыг бүрэн дүүрэн, үнэн зөв тайлбарлана гэдэг тийм ч амар биш.

Өвөрмөц хэллэг, зүйр цэцэн үг зэрэг тогтвортой хэллэг нь тухайн хэлээр харилцагч үндэстний сэтгэлгээний хэв шинж буюу ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан байдлын илэрхийлэл, энэ шинжээрээ тухайн үндэстний эдийн болон оюуны соёлын баримт болох ёстой хэмээн бидний энд онцлон тэмдэглэж байгаа санааг манай эрдэмтэн судлаачид зохиол бүтээлдээ ажиглан тэмдэглэсэн зүйл мэр сэр бий. Тухайлбал, Чой.Лувсанжав “**Ер нь өвөрмөц хэллэг гэдэг бол гагцхүү тухайн үндэстний хэлэнд буюу тухайн соёлын хүрээнд багтах улсын хэлэнд байдаг ... тогтворжсон нийлэмж үгийн нэр юм. Энгийн арав хорин үгээр гаргах санааг ганц хоёрхон үгэнд хураагаад хүний ой тойнд тов тод оруулж өгөх ид чадал чухамхүү хэл хэлний өвөрмөц хэллэгт л байдаг юм ... Монгол хэл мэддэг гэж боддог бид нар ч монгол өвөрмөц хэллэгээ тэр бүрийд мэддэггүй ажам.**” [1970:3] гэж онож тэмдэглэсэн нь бий.

Г.Аким “Монголчуудын байгаль орчин, нийгэм түүх, аж ахуй, амьдрал үйлс, зан заншил, хувцас хунар нь хүртэл өөрийн онцлогтой тул монгол өвөрмөц хэлц тэр бүхнийг ямар нэг хэмжээгээр тусгасан байдаг. Жишээлбэл, “Эсгий гэрээс холдож, энгэр газар ойртох” гэсэн хэлцэд монголчуудын эсгий гэрт суудаг, үхэгсдийнхээ шарилыг нарнаа ээвэр энгэр газар хөдөөлүүлдэг ёс туссан байна. “Нохойн дуу ойртох” гэдэг хэлц нь нохой хуцвал очих гэж байгаа айл маань ойртож байна гэж баримжаалдаг байсан нүүдэлчин ардын аж амьдралаас үүсэж, хожим утга шилжин “ямар нэгэн ажлыг хийж дуусахад ойртох”-ыг хэлдэг болсон байна. [Аким 1982:8, Лувсанбалдан 1986:139-140] гэжээ.

Эшлэл
(эшилсэн)

Үнэндээ өвөрмөц хэллэгийн утгыг ийнхүү үндэстний соёл-хэлний баримт болох талаас нь зөв ойлгон тайлбарлаж гэмээнэ түүнийг өөр хэлээр орчуулах, эсвэл өөр хэлний тухайн өвөрмөц хэлцийг эх хэлээрээ зөв онолдуулан дүйлгэх боломжтой болох ёстой гэдэг.

Ном
зүй

Ном зүй:

1. Аким Г. Монгол хэлний өвөрмөц хэлцийн товч тайлбар толь, УБ., 1982
2. Лувсанжав Чой. Орос-монгол өвөрмөц хэллэгийн толь, УБ., 1970
3. Лувсанбалдан Х., Шагдарсүрэн Ц. Монголчуудын үсэг бичиг, үг хэллэгийн түүх гарлаас, УБ., 1971, 1986

Зүүлтийн
тайлбар

* Тогтвортой хэллэгийг үндэстний сэтгэлгээний баримт гэж үзэхийн учир // Ж.Баянсан. Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ, УБ., 2016, 104-р тал

2. Эшлэл, номзүй, зүүлтийг яагаад хэрэглэдгийн учрыг ойлгоё.


а. Дараах тайлбарыг уншаад “Тогтвортой хэллэгийг үндэстний сэтгэлгээний баримт гэж үзэхийн учир” эхэд эх сурвалжийг тэмдэглэсэн байдалд үнэлгээ өгнө үү. Учрыг ярилцаарай.

Эшлэл, зүүлт, ном зүйг яагаад хэрэглэдэг вэ?

Бичигч нь санаагаа баяжуулах, батлах зорилгоор бусдын бичсэн болон хэлсэн үг, судалгааны үр дүн, онол үзэл баримтлалыг судлан ашигладаг. Бусдын бүтээлийг ашиглагчаад эшлэл, зүүлт хийхгүй бол оюуны хулгайд тооцогддог. Ийм учраас ашигласан бүтээл буюу эх сурвалжийг нь бичиж байгаа зүйлдээ заавал тэмдэглэх учиртай. Энэ нь дараах ач холбогдолтой. Үүнд:

- Бичиж байгаа хүний хэр гүнзгий уншиж судалсныг харуулна.
- Оюуны өмчийн санамсаргүй хулгайгаас сэргийлнэ.
- Бичигчийн гаргасан санаа нь зөвхөн өөрийнх нь гэдгийг батална.
- Зарим уншигч цаашид шаардлагатай мэдээллийг олоход дэмжлэг болно.

Бүтээлд эх сурвалжийг тэмдэглэдэг нийтлэг гурван арга байна. Үүнд:



б. Эдгээр нэр томъёоны тайлбартай танилцаж, утгыг ойлгоорой.

Эх сурвалж

Эш татсан тухайн хэсгийг хэн гэдэг зохиогчийн хэдэн онд хэвлүүлсэн бүтээлээс авсныг баримтаар харуулсан хэсэг.

Эшлэх, эш татах

Бичиж байгаа зүйлдээ бусад хүний бүтээлээс хэсэглэн авч оруулахыг шууд эш татах гэдэг бол бусдын санааг дурдан тайлбарлахыг дам эш татсан гэдэг.

Зүүлт, тайлбар

Бичихдээ ашигласан зарим хэлц, харь үг, хүн, газар усны нэр, он цаг, эд өлгийн зүйл, зан заншил гэхчлэн нэмэлт мэдээлэл шаардсан хэсгийг тэмдэглэж, тусгайлан тайлбарладаг.

Ном зүй

Бичихдээ ашигласан, эш татсан зохиол бүтээлийг жагсаан бичсэн хэсэг. Ном зүйг тусгай стандартын дагуу бичдэг. Ном зүй хийхдээ зохиогчийн нэрийн үсгийн дарааллыг баримтална.

3. Эшлэл, зүүлт, ном зүйн хэрэглээг судалъя.
- а. Өөрсдийн уншиж, судалж байгаа ном, сурах бичигт ашигласан дараах жишээ тус бүрээс хоёрыг олж бичнэ үү.
- шууд эш татсан жишээ
 - дам эш татсан жишээ
 - зүүлт ашиглаж тайлбарласан жишээ
 - ном зүй хийсэн жишээ
- б. Эдгээрийг бүтээлд яаж тэмдэглэснийг ажиглаад, дараах асуултын дагуу ярилцаарай.
- Шууд эш татсан хэсгийг яаж тэмдэглэсэн байна вэ?
 - Ямар үед хаалт хэрэглэдэг вэ? Жишээ нь: [Аким 1982:8]
 - Зүүлтийг юу, юугаар тэмдэглэсэн байна? Түүний тайлбарыг хаана бичсэн байна?
 - Дам эш татах нь шууд эш татахаас ямар ялгаатай байна?
4. Эх сурвалж ашиглан эх зохиож бичье.
- а. Эхэд үнэлгээ өгье. Интернэтэд сэтгүүлчийн ангийн нэг оюутан “Эх хэлээ эвдэхгүй юм сан” өгүүлэл нийтэлжээ.

Өсвөр насны хүүхэд, залуучуудад зориулсан нэгэн сонинд “Эх хэл-үндэсний тусгаар тогтнол” тусгай булан нээжээ. Сонины редакцийн хамт олон энэ буланд сурагчдын бүтээлээс нийтэлж эхлээд байгаа аж. Иймд та бүхэн эх хэлнийхээ өнөөгийн байдлын талаар эргэцүүлэн бодоод эх зохиож бичих алхмыг мөрдөж бичээрэй.

Та нарын бичсэн эх дараах шаардлага хангавал тус сонинд нийтлэгдэх болзол хангах болно.

1. Өсвөр насны хүүхдүүдэд зориулсан байна.
2. Эх хэлний талаарх баримтаас бичих агуулгадаа тохирсон гурваас доошгүй эх сурвалжийг сонгож ашиглана.
3. Ашигласан эх сурвалжийг эшилж, зүүлт, ном зүйг хийнэ.
4. Компьютерт бичсэнээр нэг нүүр орчим /500 орчим үг/

Эх хэлээ эвдэхгүй юм сан

Монгол хэлээ мэдэж, ёс заншлаа нөмрөөгүй байж “гадны цуваар” гангарах хүмүүс олон болжээ. Одоо цагт үндэснийхээ бичгээр нэрээ ч бичиж үл чадах атлаа “эрлийз” хэлээр хэн хүнгүй л ярих болж. Гадаад үгийг монгол хөрсөнд буулган “нутагшуулахын” оронд шууд л шүүрэн “гангарах” хандлага газар авчээ.

Зөвхөн харь үг манай хэл соёлд яаж нөлөөлж байгааг авч үзье. Мэдээж, үгийн санг бохирдуулж, монгол сэтгэлгээг үгүйсгэж байгааг хэлэх ч юм биш. Үүний гол шалтгаан нь зарим хүн өрөөлийн хэлээр ярьж байгаагаа ч мэддэггүй. “Өшөө чанга” хэмээн орилох дуучин, “Өшөө ямар асуудал байна?” хэмээн асуух сэтгүүлч цөөнгүй байна. Гэтэл оронд нь хэрэглэх “өөр, ондоо, бас, дахиад, улам бүр...” гэх мэт хорь гаруй үг хэллэг монгол хэлэнд маань байх юм.

Сүүлийн үед “худалдан авалт хийх”, “өвдөлт өгөх”, “хөрс хуулалт хийх” гэх мэтээр ярих нь хэвийн зүйл мэт болж, улам бүр гаарсаар байгаа нь тун ч эмзэглэмээр. Гэтэл “худалдаж авах, өвдөх, хөрс хуулах” гэхийг ийнхүү нэршүүлж, хэрэглэж байгааг гажуудал гэж үзэхээс өөр аргагүй. Академич Ш.Лувсанвандан “Үйл үг бол эх хэлний манаач юм” хэмээн онцолсон байдаг. Үүний балгаар хэтдээ бид “Би хоол идэлт хийгээд цадалт авлаа”, Өвдөлт өгсөн үед эм уулт хийгээрэй” гэж орчуулгын “модон хэлээр” ярьж, бичдэг болбол

яана аа. Энэ аюул биш гэж үү?

Олон улсад хэрэглэдэг нийтлэг хэрэглэгддэг компьютер, машин, кино гэх мэт үгийг орчуулалгүй шууд авч хэрэглэж болох ч үүний далбаан доор өөрийн хэлээ “үхрийн элэг” болгох учиргүй ээ, бид.

Б.Ринчен гуайн хийсэн судалгаагаар (1970) монгол хэлэнд хэрэглэгдэж буй үгийн тоо давхцахгүйгээр хоёр сая таван зуун мянга гэж тодорхойлсон байдаг. Гэтэл бидний ярианы үгийн сан тавхан мянга дотор эргэлдэж байгаа нь та бид өөрөөсөө монгол хүн мөн билүү? гэдгээ нэг асуугаад үзмээр ч юм шиг. Эх хэлэнд харь үг “ноёлло” гээд яривал худал сүржигнэлээ гэх нэгэн хэсэг байх ч эх хэл минь бидний үндэсний оршихуй гэдэгтэй санал нэгдэх байх аа.

Эх хэлийг минь чимээгүйхэн “хэмлэж” буй энэ асуудлын гарц нь бидний хэлэх үг, хэрэгжүүлэх үйлдлээс шалтгаална. Мэдээж, иргэн бүрийн эх орноо, үндэсний оршихуйгаа гэх сэтгэл зүтгэлтэй байхаас гадна өөрсдийн үүх түүхээ эргэн нэг харж, монгол үнэрийг хайж, уламжлалт сэтгэлгээгээ эрхэмлэн ярих нь нэн чухал. Хэдийгээр харийн соёл бидэн рүү хүчтэй давлагаалж байгаа ч түүнээс урьтаж эх хэл, бичгээ дархлаажуулах нь бидний чин сэтгэлийн дуудлага, эрмэлзэл байх учиртай.

Оюутан Д.Ганзориг

б. “Эх хэлээ эвдэхгүй юм сан” эхийг сайжруулан бичнэ үү.

в. Эх хэлнийхээ талаар бичье.

Бичихдээ ашиглаж болох зарим баримт жишээ:

1. Эрдэмтэн судлаачдын тооцоолсноор XVI зууны эхэнд 145000 хэл байсан бол зуунаас зуунд улам цөөрсөөр XX зууны эхэнд 6703 хэл, XXI зууны босгонд 2997 болж, 50 гаруйхан жилийн дотор 3000-аад хэл устан үгүй болсон аж. Одоо хэрэглэж байгаа 3000 шахам хэлний заримаар нь хэдэн зуун саяас тэр бум хүртэл хүн, заримаар нь хэдхэн мянган хүн ярьдаг, тархацын орон зай, хэрэглээ нь харилцан адилгүй байна. Хэдий тийм боловч аливаа хэл нь тухайн үндэстнийхээ соёл, сэтгэлгээг илэрхийлж, үнэт зүйлсийг нэг үеэс нөгөө үед дамжуулан тээж явдаг мэдээллийн хүчирхэг сан хөмрөг, улаач юм.

(ШУА-ийн их чуулганаар хэлэлцэх материал, УБ., 2007, 3-р тал)

2. ...Хэл мөхөх үндсэн хоёр шалтгаан бий. Нэгд, тухайн хэлээр хэлэлцэгч үндэстэн үгүй болоход хэл нь дагаж мөхнө. Цагаан арьстнууд Америк, Австрали тивд суурьшихдаа уугуул нуггийн олон үндэстэн ястныг хэлнийх нь хамт “бурхан болгосон” нь гашуун үнэн. Уг үндэстэн нь оршин байвч өөр соёлд ууссанаар хэл үгүй болох нь хэлний мөхлийн хоёр дахь шалтгаан.

... Хэлийг мөхөлд хүргэх бас нэг тулгуур шалтгаан байдаг нь “хэлээ залгих”

Монголчуудын ярианд “хэлээ залгисан юм шиг”, “ус балгасан юм шиг” гэж дуугардаггүй хүнийг хэлэх хэлц үг байдаг. Хэл шинжлэлийн ойлголтоор бол “хэлээ залгих” гэгч нь нэг хэл нөгөөдөө уусах юм уу, дарагдаж мөхөхийг хэлдэг. ... Өөрт байгаа үгийг орхиж, өөр хэлний үг авахыг “залгих үзэгдэл” гэдэг. Монгол хэлээ хамгаалах нь Монгол улс хилээ хамгаалахаас ч нарийн арга ухаан шаардах цаг ирнэ.

(Л.Түдэв. Хэлний мөхөл)

3. Энэ хуулийн зорилт нь монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

(Монгол хэлний тухай хууль)

4. Яагаад хэлийг хамгаалах хэрэгтэй вэ? Яагаад гэвэл, хэлэнд үндэсний түүх соёл, зан заншил агуулагдаж байдаг. Яагаад гэвэл, хэл ард түмний сэтгэлгээг илэрхийлдэг. Яагаад гэвэл, хүн төрөлхтөнд үндэстэн бүрийн өвөрмөц ялгаа, онцлог хэрэгтэй, яагаад гэвэл, хэл өөрөө маш сонирхолтой тогтолцоо, яагаад гэвэл, яагаад гэвэл...

(М.Саруул-Эрдэнэ, “Сонирхолтой хэл шинжлэл” номд хэвлэгдсэн “Аялгуу сайхан монгол хэл аялгуудгүй болохын аюул” өгүүллээс, Блүүмингтон, Индиана, 2006, 23-р тал)

5. Хэрэв бид хэлээ алдвал үндэстнийхээ хувьд өв соёл, үнэт зүйлсээ алдана, улсынхаа тусгаар тогтнолоо алдана гэсэн үг. Тийм учраас хэлний тухай асуудал бол тухайн улс үндэстний тусгаар тогтнолын баталгаа, төрийн бодлогын тулгуур багана болж байх ёстой.

(Хэл шинжлэлийн ухааны доктор, академич Д.Төмөртоогоо, “Эх хэл” сэтгүүлд өгсөн ярилцлагаас, 2012 оны 11-р сар, №1, 31-р тал)

6. Ер нь монгол хэл цөөн хэрэглэгчтэй ч дархлаа сайтай хэл юм. Үүссэнээсээ хойш гурван цагийн хэлхээнд хэрэглэгч нь тасраагүй, нэн эртнээс бичгийн хэлээр дархлаажсан хэлний нэг юм. Ийм хэл мөхөх аюулаас хол байдаг. Өөрөөр хэлбэл, аман ба бичгийн хэлтэй, олон аялгуу, аман аялгууны өнгө төрхтэй, бүтэц байгуулал нь дэлхийн олон хэлний дундын шинжтэй учраас гадны нөлөөнд амархан өртөхгүй. Ийм ч учраас монгол хэл нь гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр амархан мөхөх хэл биш юм. Хамгийн гол нь монгол хэлийг тээгч буюу хэрэглэгчийн тоог олон болгох л чухал. Энэ бүхнээс үзвэл, монгол хэл мөхлөө, харийн хэл, соёлын нөлөөнд автсан байна гэж хэт туйлширч дүгнэж болохгүй. Гэвч эх хэлээ хайрлах хамгаалах, ариун дагшин байлгах талаар цаг ямагт анхаарч байх хэрэгтэй

(Ц.Өнөрбаян “Монгол хэл дархлаажсан учир мөхөх аюул хол” Икон вэбсайт, Сэтгүүлч Б.Энхзаяатай хийсэн ярилцлагаас, 2013 оны 10 сарын 30)

7. ...Энэтхэг-европ хэлний өгүүлбэрт орсон бүх нэр үгийг монгол хэлний нэр үгээр орчуулах гэсэн эрмэлзлээс үүдэж, монгол хэлний үйл үгээс нэр үг үүсгэх -л, -лт дагаврын хэрэглээ зохиомлоор өсөж, монгол хэлний зүй тогтлоор үйл үг юм уу, үйлт нэр байх газарт нэр үг орсноос ард нь өөр нэг үйл үгийн зохих хэлбэр эрхгүй шаардагдах тул нурууу, монгол хэлний зүйгээс гажсан, муухан орчуулга гэдгийг нь нотолсон зүйл газар авахад хүрсэн байдаг. Тэгээд ч зарим цэцэрлэгийн цагийн хуваарийг үзэхэд *өглөөний цай уулт, өдрийн унталт* гэж, эмч нар *өтгөн хаталт, цус гаралт* гэж ярьж бичих болжээ.

... Одоо гадаад хэлнээс үгийг хэл зүйн хэлбэртэй нь махчлан орчуулдгаас үүдэж монгол хэлний найруулга үлэмжхэн эвдэрч, түүнийг олон монгол хүн, ялангуяа залуучууд хэвийн мэт ухаарах болжээ. “...*Индонезид газар хөдлөлт болж, олон хүн...*” гэж мөнөөх -лт дагавраар нэр үг үүсгэснээс “... *Индонезид газар хөдөлж, олон хүн...*” гэвэл академич Ш. Лувсанвандан багшийн бичсэнчлэн үйл дохиогоор буулгаснаар юуны өмнө монгол хэлний найруулах ёсонд нийцнэ, бас “... *болж...*” гэдэг илүү үг нэмэх хэрэггүй болж хэлний арвилан хэмнэх ёсонд нийцэх байжээ. Энэ мэтээр “... *газар хөдлөлт боллоо*”, биеийн тамир дээр “... *давуулалт хийлээ*”, “*хууралт гүйцэтгэлээ*” гээд байгааг “... *газар хөдөллөө*”, “... *давууллаа*”, “*хуурлаа*” гэхэд л уг утга нь монгол хүнд илүү ойр тусаж, илүү нэг үг хэмнэгдэж монгол хэлний зүй, монгол найруулгад нийцэх болно.

(Ц.Шагдарсүрэн. Эх хэлээ эвдэхгүй юм сан, УБ., 2010, 34-35, 37-р тал.)

Дараах эхийг уншаад даалгаврыг гүйцэтгэнэ үү.

Үг зээлдэгчид

Мөнгө зээлдэгчид гэж урьд ч байсан. Одоо ч улам олширч байгаа билээ.

Мөнгө зээлдэгчдийг “бусдын мөнгийг түр аваад дараа нь өөрийнхөө мөнгийг бүр өгдөг” хүмүүс гэж ёжилдог. Харин орчин үед мөнгө биш “үг зээлдэгчид” буй боллоо. Урьд ч огт байгаагүй юм биш. Дээр үед энэтхэг, төвөд, нанхиад, манж үг “зээлдэгчид” байсан. Гэхдээ хорьдугаар зуунд дорноос биш өрнөөс “үг зээлдэгчдийн” шинэ үе төрж гарлаа.

...Хүмүүс мөнгөгүйдэхдээ бусдаас мөнгө зээлддэг. Тэгвэл манай өнөөгийн “үг зээлдэгчид” үгтүйдсэндээ биш, үндэсний хэлээ дутуу дулимаг сурсандаа, мөн гадаад үгийг орчуулах тэнхээ дутсандаа, зарим нь захиргаадалтаар бас залхуурч “бэлэнчлэх” саармаг зандаа хөтлөгдөж, гадаад үгийг “зээлдэцгээж” түүнийгээ хүчээр хүмүүсийн аманд “чихэж” ном, хэвлэл ялангуяа албан бичгүүдэд “шигтгэж” өгдөг нь бүр “өвчин” болон хувираад байна.

Өнгөрсөн зууны гучаад болон дөчөөд оны албан хаагчид, бас орос сургагч нарын дур зоргоороо “зээлдсэн”, “зээлдүүлсэн” зарим үгийг жагсаагаад харцгаая. Кино, театр, клуб, танец, пионер, лекц, билет, танк, концерт, гранат, фабрик, черниль, хор, колбаса, феодал, артель, комуна, генерал, арми, градус, партизан, чёрт гэхчилэн олон үг “зээлдсэн” юм.

Зээлмэл үгийг нь олон түмэн өөрсдийн хэлний журамд захирагдан “ка” гэхийг “ха” болгон кино, хлуб, халбаса, хомоон, хоор гэхчилэн дуудаж хэвшээд, “нойль”, “чоорт”, “өшөө”, “ий” гэдгийг бол бараг хэвээр нь авч, хүүхдүүдээ “нойлын ногоон тэг” гэж, ахмадууд нь “чөтгөр” гэдгийг “чоорт”, “еще” гэдгийг “өшөө” болгон дуудаж бараг л үг болгоны дагуул болгочихсон билээ. Ер нь “ка” үсэг дээр толь бичигт (А.Лувсандэндэв, 1957) 102 үг байгаа нь нэг ч монгол үггүй цөм гадаад үг ажээ.

Хөдөөний ардуудтай хотын нэгэн дарга уулзаж, яриа хийгээд явсны дараа нэгэн өвгөн: -Үгүй, энэ дарга байсхийгээд “ий” гээд ярих юм. Юунаас айдаг хэрэг вэ? Бас үе үе л “өшөө” гээд л байх юм. Юунд өшөө санадаг хүн юм бол гэж гайхан ярьсан гэдэг. Уул нь тэр дарга “и” гэдэг орос хэлний холбоос үгийг л “ий” гээд хэлдэг, мөн “бас” (ахиад) гэдэг утгатай “еще” гэдэг орос үгийг давтан давтан хэлээд сурчихсан хүн байжээ.


(Л.Түдэв)

1. Үг, мөнгө гэсэн хоёр үгийг ойролцоо ба эсрэг утгаар хэрэглэсэн өгүүлбэрийг олж, учрыг тайлбарлана уу.

- а. Эхэд дэвшүүлсэн асуудал, ашигласан баримт, тайлбар, дүгнэлтийг ялгаж бичнэ үү.
- б. Эхэд ашигласан эх сурвалжийг хэрхэн тэмдэглэсэн байна вэ?
- в. Эхийн агуулгыг товч зураглал хийж харуулна уу.
- г. Эхийг хураан найруулж бичнэ үү.


2. Угсарсан нийлмэл өгүүлбэрийг задлан шинжилье.

а. “зээлдэцгээж” -өгүүлэхүүнд захирагдаж буй шалтгааны утгатай байц гишүүн өгүүлбэрийг ялгаж бичнэ үү.



б. Дараах бүдүүвчийн дутуу хэсгийг гүйцээж, угсарсан нийлмэл өгүүлбэрийн утга, бүтцийн ангиллын талаарх мэдлэг ойлголтоо дүгнэнэ үү.

Угсарсан нийлмэл өгүүлбэрийн ангилал



ЭРГЭЦҮҮЛСЭН ЭСЭЭНИЙ ДЭВШҮҮЛСЭН АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Эргэцүүлсэн эсээний онцлогийг анхаарч уншъя

Эсээг уншихдаа дараах асуултад хариулт олохыг хичээгээрэй. Үүнд:

- Эсээнд харьцууллыг яаж гаргасан байна вэ?
- Эсээнд тухайн зүйлийн зөрчилт шинж чанарыг ямар аргаар гаргасан бэ?
- Эсээнд уран дүрслэлийг ямар зорилгоор ашигласан байна вэ?
- Эсээнд хэвшсэн ойлголт санаанаас шинэ сэдэл төрүүлсэн хэсэг байна уу?

Үнэр идэгч

(1) Үнэр идэгч хэмээх амьтан байсан тухай хуучны домог уншаад гайхлаа. Үнэр идэгч гэгч нь утгагүй юм шиг бодогдоно. Үнэрийг зөвхөн үнэрлэж болохоос идэж болохгүй нь лав. Тэгэхээр эцэг дээдэс юугаа ярьж байсан юм бол оо?

(2) “Үнэр идэгч дисаан” хоёр төрж дээд орныг эзэгнэв” гэж ном сударт гарна. Түүний мөрийг мөшгөн явсаар үнэрийн тухай, үнэрлэх эрхтэн хамрын тухай олон сонин юм сонсож мэдсэнээ уншигчдад ярья.

(3) Хүн эхлээд үнэрээр ертөнцийг танин мэджээ. Бас хүнийг хүн болгосон гол эрхтэн нь хамар ажээ. Тэрчлэн хүн анхандаа амаараа биш, хамраараа ярьдаг байжээ. Энэ бүхэнд одоогийн хүмүүс итгэхгүй нь лав. Гэхдээ л худал биш үнэн болох нь нэгэнт нотлогдсон юмыг энд ярих ёстой.

(4) Хүн эхлээд үнэрээр ертөнцийг танин мэдсэн нь маргашгүй юмаар нотлогджээ. Хүний танин мэдэх таван сайн зэвсгийн хамгийн ашиг багатай нь хамар юм шиг санагдана. Хоёр нүд, хоёр чих л хүнд юу юунаас чухал, юу юунаас илүү мэдээлэл, сэрэл өгч байна. Ам дараа нь орно. Гэтэл хамар ямар мэдлэг өгдөг билээ? Хамраар зөвхөн үнэрийг л ялгана. Өөр юухан байх вэ? Хамраар амьсгална. Тэр нь л гол үүрэг юм. Гэвч хамар дээр үед нүд, чихнээс илүү чухал байжээ. Дээр үед гэдэг нь аль дивангарын цагийг хэлж байна. Өөрөөр хэлбэл, хүн босоо явж сураагүй байх үе юм. Тэр цагт хүн хоол тэжээлээ бөхийж олдог, бөхийж иддэг байжээ. Хонь, ямаа, адуу, тэмээний адил эсвэл галуу, нугас, тагтаа, бүргэдийн ижлээр хүн хоол олж идэхдээ бөхөлзөн газар шүүрч байлаа. Гэвч хоёр хөл дээрээ боссон цагаас хойш амьд амьгад дотроос цор ганцаараа хоол олж идэхдээ бөхөлзөхөө байснаас эхлэн хүн болж, бүхий л адгууснаас онцгойрчээ. Бөхөлздөг байхдаа хүний хамар газарт их ойрхон байлаа. Үнэр авахдаа ч сайн байжээ. Харин босоо явах болсноос хойш хүн хамраа сөхсөн хэрэг. Хамар ч эх газраас холдож аажмаар мэдрэхүйн чадвараа гээсээр байгаад одоо зөвхөн хоёр гуравхан үнэр ялгадаг болчихжээ.

(5) Ийм болоогүй гэвэл үнэрийг тодорхойлсон хэчнээн үг мэддэгээ тоолоод үзье. Муухай, сайхан үнэр гэсэн хоёр ерөнхий үг бий. Сайхан үнэрийг хэчнээн үгээр тодорхойлдог вэ гэхэд хуруу дарах цөөн үг бий. Муухай үнэрийг л түүнээс арай олон үгээр томьёолно. Гэтэл нүдээр үздэг өнгөний тухай хавьгүй олон үг бий. Энэ маань бидний хамрын ялгах чадвар ядууг илтгэнэ. Үнэрийг бие даасан үгээр биш, харин уул үнэрийг хадгалагч эд юмсын нэртэй хавсарган тодорхойлно. Алимны үнэр, загасны үнэр, зөгийн балны үнэр гэвэл хүн

* ДИСАА “үнэр идэшт”, гандарваа; Хималайд байдаг Гандхамаадан (үнэрээр согтоогч) уулын цэцэгсийн үнэрт газраас гаралтай гэж домоглодог тэнгэрийн хөгжимчин, дуучин сахиулсан тэнгэр. (О.Сүхбаатар. Монгол хэлний харь үгийн толь. УБ., 1997, 84-р тал)

ойлгохоос биш улаан, цагаан, хөх гэдэг шиг шууд нэг үгээр үнэрийг нэрлэхэд бэрх болно. Хүн ярьдаг болохоосоо өмнө үнэрлэх чадвараа доройтуулсны гэрч энэ юм. Хэрвээ үнэг хэл мэддэгсэн бол түүний үгийн санд үнэрийн тухай маш олон үг байж таарна. Хүн, үнэг хоёр үнэрлэх чадвараар ойролцоо байсан цаг бий. Гэвч хүн босоо явдаг болсноос хойш, дээр хэлснээр, үнэрээс холдож, хамрын чадвар суларчээ.

(6) “Үнэртэх хэл” гэж амьтны ертөнцийн бие биенээ ойлголцох гол арга. Одоо бол хүн үүнд итгэхээргүй мартжээ. Учир нь, хүн нэг шоо дөрвөлжин сантиметр агаарт 700000000 молекул үнэр хуралдсан байвал сая анзаарна. Гэтэл нохой мөн тийм хэмжээний агаарт 9000-хан молекул үнэр байхад л мэдэрч чадна. Ингэхээр үнэрч чадавхаараа хүн нохойноос 800 мянга дахин дутуу буюу ердөө л битүү хамартай гэсэн үг. Сургуультай нохой бол 700-хан молекул үнэр нэг шоо дөрвөлжин сантиметр агаарт байхад мэдэрдэг байна. Хүн дөрвөн хөллөж явдаг амьтан байхдаа мөн л ийм сайн үнэрч явжээ.

(7) Хүн өөрөө 15 янзын үнэр гаргадаг, хоногт 800 см² үнэрийг хүрээлэн буй орчиндоо түгээдэг боловч тэр бүрийг хамраараа мэдэрдэггүй болжээ.

(8) Үнэр шинжих ухаан (одорология) хөгжиж, үнэр нь долгион хэлбэрээр, хийн маягаар, нэвчих юм уу шингэх аргаар тархан түгдгийг нэгэнт нарийвчлан мэджээ. Гэвч хүний хамар энэ бүхнийг төдий л сайн шинжих чадвар дутмаг болжээ. Арван мянга хүртэл янз бүрийн үнэр мэдрэх чадвартай энэ чухал эрхтэн одоо амьсгалах, хамгаалах, рефлекс үүсгэх, дуу зохицуулах үүргээ илүү биелүүлж, үнэр ялгах авьяасаа зөвхөн арын алба болгожээ. Үнэр ялгах эрхтнээр одоогийн хүн орчлонгийн тухай мэдээллийнхээ дөнгөж ганц хувийг авдаг байна.

(9) Дөрвөн хөллөж явдаг байхдаа хамраараа бүх мэдээллийн 80-аас доошгүй хувийг авдаг байжээ. Дөрвөн хөлтэй амьтад одоо ч тийм хэмжээний мэдээлэл хамраараа авдаг хэвээр юм. Хамраараа хаана хоол унд, аюул осол байгааг, ижил сүрэг нь хаагуур явсан, тэдэнтэй ямар тохиолдол учрал болсон, тэд юу хийцгээсэн, нутгийн хязгаар хаана дуусах тэр бүхнийг үлдээсэн үнэрээр нь ялган танина. Адгуус тэгээд үнэрээр бичсэн захидал, сонин хэрэглэдэг гэхэд болно. Садан төрлийнхөө хэд хэдэн омог, сүргийг ч үнэрээр нь ялгадаг аж.

(10) Эх нь үрээ үнэрээр нь танина. Хургаа голсон хонь, ботгоо голсон ингэ бодвол хурга, ботгонд нь өөр гаж үнэр шингэснээс болдог биз. Ишиг нь үхчихсэн ямаанд өөр ишиг авхуулахын тулд үхсэн ишигний нь арьсыг нөмрүүлж байж аргалдаг малчин аргын учир нь үнэрийн хэлнээ түшиглэсэн байдаг ажээ.

(11) Харилцааны болон мэдээллийн хэрэглүүр дуу авиагаар буюу механик аргаар л байж болно гэж үздэг үзэл одоо нэгэнт өөрчлөгдөж “үнэрийн буюу химийн хэл” гэгч бүхэл бүтэн систем нэмэгдлээ. Одоо “үнэрийн хэлний” үгийн сан, цагаан толгойг судалж байна. Амьтны хэл-үнэр. Энэ хэлийг бүрэн судалсан цагт амьтны ертөнцөд жинхэнэ аюул учрах болно. Өөрийнх нь хэлийг ашиглан амьтны ертөнцийг хүн гартаа бүрэн авна. Одоо болтол хүний мэддэггүй байсан ганц нууцыг хэрвээ ингэж алдвал амьтны ертөнц хамгаалалтгүй болж үлдэх юм. Гэвч хүн амьтны хэлийг өөрсөд нь тустайгаар ашиглах ухаан суужээ.

(12) Амьтны үнэрийн хэлийг судлахын тулд юуны урьд аливаа амьтны үнэрийн химийн бүтэц, кодыг танин мэдвэл зохино. Амьтны үнэрийн хэлний гол амин судас нь заар юм. Заарыг бүрэн судлах нь бараг л амьд ертөнцийн зүрхний нууцыг мэдэж авахтай адил.

(13) Хүдрийн заарыг дуунд оруулан монголчууд дуулдаг. Баавгайн заар, чонын заар, хуцны заарыг бид маш сайн ялган танина. Гэвч загасныхыг мэддэг монгол хүн тун ховор биз. Гэтэл загасны заар усан дотор хэдэн ч жил үнэрээ хадгалан үлддэг байна. Голын эхэнд төрцнөөс биеийг олсон яргай загас (лосось) урсгал даган уруудаж, их далайд очоод, тэнд хэдэн жил амьдарч байснаа олон зуун километр замыг буцаж туулж, урсгал сөрөн явсаар

голын эхэнд анх мэндэлсэн газартаа алдахгүй ирж төрцөө орхидог хуультайг эрдэмтэд хэдийн судалжээ. Ямар ч луужингүйгээр анх төрсөн усандаа эргэж ирдэг загасны ёсыг судлахад хэдэн зуун хослолоос бүрдсэн өвөрмөц заарны үнэрээр загас баримжаа авч, эх болсон газраа төвөггүй олж ирдэг ажээ. Тэр нууц үнэрийг нь танин мэдсэнээ ашиглан, загасны хэлээр аль нэг усан санд дуудан аваачиж, төрцийг орхиулан өсгөж үржүүлэх боломж нээгдэх юм.

(14) Ургамлын хортон шавжийг жигшээх үнэрийг хэрэглэж чадвал янз бүрийн хор цацахгүйгээр хортон шавжнаас сэрэмжилж болно. Ийнхүү үнэртнээр тогтоосон хил хязгаарыг ямар ч үед хортон шавж давж гарахгүй болно. Эсвэл ялаа шумуулын дуртай үнэрийг гарган авч, түүний тусламжаар ойр хавийн ялаа шумуулыг дуудан цуглуулж устгаж болно.

(15) Зарим ургамал хортон шавж хүрэлцэн очиход нь мөчир салаанаасаа муухай үнэр гаргаж тэр хорхойнуудыг хөөн жигшээдгээр барахгүй энэ аюулын тухай ойр хавьдаа зар тараадаг байна. Тэр зарыг авмагц мөнөөхөн ургамлууд бас л муухай үнэр гаргадаг хачин үзэгдлийг эрдэмтэд шинжиж мэджээ.

(16) Аливаа амьтан ургамлын заар нь бас үржлийн ач холбогдолтойгоор барахгүй оо энгэсэг, үнэрт усны адил гоёлын буюу дур булаах учир холбогдолтой юм. Үнэрийн хэл нь бусдад дуулдахгүй мөртөө харанхуйд ч хамар дамжин ойлгогддог өвөрмөц онцлогтой ажээ.

(17) Үнэрийн хэлний үгийн санд эр, эм, хүний, өөрийн, аюултай, аюулгүй, аймаар, гэмгүй, эрүүл, өвчтэй, өлсгөлөн, цагалан гэх мэтийн бараг хоёр зуугаад үг байгааг эрдэмтэд олж мэджээ.

(18) Ингээд бодоход хамар хүний гол эрхтэн байж, оюуны хөгжлийн эх үүсвэрийг тавьсан нь үнэн ажээ. Одоо ч тэр чанараа хадгалсаар байна. Хүний бие хөрч даарахыг хамгийн түрүүн хамар мэдэрч найтааж дохио өгдөг. Найтаасан хүнийг “бурхан өршөө!” гэж ерөөдөг. Хүн хамраа бөглөөд байвал ходоодны шүүсний шүлтлэг чанар нь буурч, элэг бөөрний ажиллагаа удааширч, цөс ялгарах нь багасаж, улмаар шүд үйрэмтгий болж, цусанд гемоглобин буурна. Зүрхний ажиллагаа хамартай шууд холбоотой гэнэ.

(19) Үнэр идэгч гэж хүнийг ч хэлсэн байж болох юм. Нялх хүүхэд төрөхдөө анхны өдрүүдэд эхээ үнэрээр нь таньдаг байна. Үнэр хүн төрөлхтний нялх балчир үеийн гол эрдэм байж.

(20) Одоо бол хүн хиймэл үнэр гарган авч түүгээр гоёж гооддог болжээ. Үнэр шинжих ухаан буюу одорологийн тусламжаар янз бүрийн гоё үнэртэн үйлдвэрлэж, түүгээр орчин үеийн эмэгтэйчүүд гангалан гоёж байна. Үнэртэй усны болон гоо сайхны үнэртэнг эсвэл цэцгийн үнэрийг ялгах талаар хүний чадвар нохойныхоос арван мянга дахин илүү мэдрэмтгий ажээ. Үүгээрээ хүн адгууснаас их хол явж, гоо сайхны үнэр идэгч болон хувирчээ.

(21) Амьтны үнэрийн хэлийг бүрэн судалж дуусах үед хүн, адгуус хоёр бие биеэ улам гүнзгий ойлгодог болно. Үнэр идэгч гэгчийн утга тэр үед бүрэн ойлгогдоно.

(Л.Түдэв, 1983)

Асуулт даалгавар

а. Тохирох хариултыг сонгож, тайлбарлана уу.

№	Бодомж	Тийм	Үгүй
1	Хүн босоо явдаг болсны улмаас үнэрлэх чадвар суларч, оюун ухаан сайжирсан.		
2	“Ийм болоогүй гэвэл...”- (4), (5) догол мөрийг “сөргүүлэн лавшруулах” утгаар холбосон. “...дээр хэлснээр” гэсэн нь “дурдан сануулах” утгаар өмнөх догол мөртэй холбожээ.		
3	Хэлэнд үнэртэй холбоотой үг цөөн байдаг нь хамраараа бага мэдээлэл авдагтай холбогдоно.		
4	Үнэр мэдрэх гэгч нь амьдрах арга хэрэглүүр байсан.		
5	Үнэр мэдрэх гэгч нь харилцах арга хэрэглүүр.		
6	Үнэр мэдрэх гэгч нь биеэ хамгаалах арга хэрэглүүр юм.		
7	Үнэр мэдрэх гэгч нь танин мэдэх, бүтээх арга хэрэглүүр болсон.		

б. Дээрх эсэнд уран дүрслэл, хэлц үг хэллэгийг ямар зорилгоор ашигласныг ярилцаарай.

Үлгэрлэвэл: “Харин босоо явах болсноос хойш хүн хамраа сөхсөн хэрэг” гэсэн өгүүлбэр дэх “хамраа сөхөх” гэсэн хэлц нь “ихэмсэглэх, биеэ тоох” гэсэн утгатай хэдий ч “бусад амьтнаас хавьгүй өөр, давамгай болсон, онцгойрсон” гэсэн утгаар зохиогч санаагаа эрчимжүүлжээ. Тодруулбал, хойд хоёр мөч дээрээ босоо явдаг болсон нь хүний уураг тархины болон бусад эрхтний хөгжилд онцгой учир холбогдолтой, гайхалтай зүйл болсныг онцлох зорилгоор уг хэлцийг ашигласан байна.

үзгээр бичих →	<u>Адгуус</u> тэгээд <u>үнэрээр бичсэн захидал сонин</u>
хүн захидал, сонин хэрэглэх →	<u>хэрэглэдэг</u> гэхэд болно.
гол судас чухал нандин хэрэглүүр →	Амьтны үнэрийн хэлний гол <u>амин судас</u> нь заар юм.
далд зүйл →	Заарыг бүрэн судлах нь бараг л амьд ертөнцийн <u>зүрхний нууцыг</u> мэдэж авахтай адил.

Эхэд задлал хийж, нэгтгэн дүгнэе.

1. “Үнэр идэгч” эсээг дахин уншаад, чухал мэдээллийг олоорой.

а. Эсэнд бүхэлдээ юуны тухай өгүүлсэн байна вэ?


б. Эсээг эхлэл, үндсэн, төгсгөл хэсгээр зааглаарай.

Эхийн аль хэсэг		Догол мөр
Эхлэл хэсэг	Уг асуудлын талаарх зохиогчийн үзэл бодлыг илэрхийлсэн хөтөч санаатай байна.	(1)- (3)
Үндсэн хэсэг	Хөтөч санаа болон эхлэл цогцолборт өгөгдсөн гол санааг лавшруулах, дэмжих, нэмэн өргөжүүлэх мэдээллүүдийг агуулна.	
Төгсгөл хэсэг	Үзэл бодлоо дахин илэрхийлж, уншигчдад нөлөөлсөн хэсэг	

в. Дараах асуултад хариулаарай.

- Эхлэл хэсэгт уншигчдын анхаарал, сонирхлыг хэрхэн татсан байна вэ?
- Эсээний туршид чиглүүлэх үүрэгтэй хөтөч өгүүлбэр аль нь вэ?
- Үндсэн хэсэгт хөтөч санаатай холбогдох ямар ямар багц санаа байна вэ? Тус бүрийн толгой өгүүлбэр аль нь вэ?
- Зохиогч эсээний гол санааг илэрхийлсэн хөтөч санаагаа хэрхэн дүгнэсэн бэ?

г. Дараах загварын дагуу эсээний бүтэц зохиомжийг тайлбарлаарай.



2.а. Уншигчдад итгүүлэн үнэмшүүлэхэд баримт яагаад чухал вэ? Саналаа солилцоорой.

Тухайлбал: Аливаа хэл үгийн сантай байдаг шиг үнэрийн хэлэнд 200-аад үг байгааг эрдэмтэд олж мэдсэн талаарх сонирхолтой баримтыг уг эсээнд дурджээ. Үүнд:

1. Хүн (шар, хар, цагаан арьстан)
2. Амьтан (зөгий, голио, арслан, баавгай)
3. Ургамал (нарс, яргуй, дэрс, хус)

Үнэрийн хэлний үгийн сан

эр - эм
хүний - өөрийн
аюултай - аюулгүй
аймаар - гэмгүй
өлсгөлөн - цаггалан
эрүүл - өвчтэй

б. Баримтын зүйлийг цаг хугацаа (одоо-дээр үед)-аар нь хэрхэн харьцуулсан, ямар утга, үүрэг бүхий холбох хэрэглүүр ашигласныг олж, дүгнэлт гаргана уу. Дараах хүснэгтэд тохирох тулгуур үг хэллэгийг бичиж, дүгнэлт гаргахдаа ашиглаарай.

Хүн, амьтныг харьцуулсан баримтын зүйл	Одоо	Дээр үед (хүн босоо явж сураагүй байх үе)	Холбох хэрэглүүр	Догол мөрийн дугаар
Эрхтний үүргээрээ				
Хоол олж идэх хөдөлгөөний шинжээрээ				
Үнэрийг мэдрэх биеийн байрлалаараа				
Үнэрлэх чадвараараа				
Мэдээллийн багтаамжаараа				

в. Үнэр, өнгийг тодорхойлсон үг хэллэгийг цаг хугацаа (одоо-дээр үед)-аар нь харьцуулан ярилцаарай.

Үгийн сангийн багтаамжаараа	Одоо ямар байна вэ?	Дээр үед ямар байсан бол оо?
үнэрийн тухай үг		
өнгөний тухай үг		

г. Баримтаас төрсөн сэтгэгдэл, өвөрмөц бодол-эргэцүүлэл, таамаглалын аль нь болохыг шинжилж, эхээс холбогдох баримтыг олж, тайлбарлаарай.

Сэтгэгдэл, эргэцүүлэл, таамаглалын аль нь болох вэ?	Холбогдох баримт	
Хортон шавжийг жигшээх ургамлын үнэрийг хэрэглэж чадвал ... сэрэмжилж болно.	<i>эргэцүүлэл</i>	<i>Зарим ургамал хортон шавж хурьцэн очиход нь ... зар тараадаг байна.</i>
Үнэр идэгч гэгч нь утгагүй юм шиг бодогдоно.		
Хургаа голсон хонь, ботгоо голсон ингэ бодвол хурга, ботгонд нь өөр гаж үнэр шингэсэнээс болдог биз.		
... загасны хэлээр аль нэг усан санд дуудан аваачиж, төрцийг орхиулан өсгөж үржүүлэх боломж нээгдэх юм.		

д. Доорх хүснэгтийн дагуу баримтыг дүгнээрэй.

Догол мөрийн дугаар	Юуны тухай өгүүлсэн байна вэ?	Санаагаа ямар ямар баримтаар дэмжсэн байна вэ?	Тоон, судалгааны, бодит байдлын баримтын аль нь болох вэ?	Баримтаа ямар зорилгоор ашигласан бэ?
(4)-(10)	Хүн үнэрлэх чадвараа алдсан тухай	Жишээ нь: (6) Хүн нэг шоо дөрвөлжин сантиметр агаарт 7000000000 молекул үнэр хуралдсан байвал сая анзаарна. Гэтэл нохой мөн тийм хэмжээний агаарт 9000-хан молекул үнэр байхад л мэдэрч чадна.	тоон баримт	“Хэрэв хүн босоо явж сураагүй байсан бол мөн л ийм сайн үнэрч байх байсан байна” гэсэн санааг лавшруулан нотлох зорилгоор уг баримтыг ашигласан.
(11)-(17)				

3. Эсээг уншаад, ямар сэтгэгдэл төрсөн бэ? Зохиогчийн дүгнэлтийг өөрийнхөө үзэл бодолтой харьцуулаарай.

Л.Түдэв



Амьтны үнэрийн хэлийг бүрэн судалж дуусах үед хүн, адгуус хоёр бие биеэ улам гүнзгий ойлгодог болно. Үнэр идэгч гэгчийн утга тэр үед бүрэн ойлгогдоно.

Чиний хувьд юу гэж дүгнэх вэ? Яагаад?



4. “Хүн мичнээс үүсээгүй” хэмээх эхийг Л.Түдэвийн “Үнэр идэгч” эсээтэй харьцуулан уншаад, эргэцүүлсэн эсээ, шинжлэх ухааны хялбаршуулсан эхийн ялгааг жишээн дээр тайлбарлаарай.

Хүн мичнээс үүсээгүй

Хүн мичнээс үүсээгүй гэвэл та итгэж байна уу? Тэгвэл юунаас үүссэн байх вэ?

Оросын нүдний их эмч Эрнест Рифгатович Мулдашев энэхүү асуултад шинжлэх ухааны үндэслэлтэй хариу өгч байна. Энэ хүн хүний нүдийг эмчлэх явцдаа хүүхэн харааны диаметр нь том хүн болон хүүхдийн алинд нь ч тогтмол байдгийг тогтоожээ. Энэ тогтмолоо офтальмогеометрийн хууль ашиглан хүний дундаж нүдний хэлбэрийг тогтоосон байна.

Дэлхий дахины бүх хүний нүдний хөгжлийг судлахад хамгийн эртний нүд нь одоогийн төвөд хүний нүдтэй ойр байсан гэнэ. Хүний нүдний хэсэг, хэлбэрээр нь л тэр хүн ямар хүн болох, баярлаж, уурлаж байгаа зэргийг мэдэж болдог байна. Хамгийн сонирхолтой нь дундаж нүд, төвөд хүний нүд хоёр адил байгааг олж мэджээ.

Тиймээс хамгийн эртний хүмүүс анх Төвөдөөс үүссэн гэж үзжээ. Төвөд сүмийн ханан дээр байдаг үл таних нүд бас л дундаж нүдтэй адил байсан гэнэ. Тэр нь манай соёл иргэншлээс өмнө оршин тогтнож асан атлант хүний нүд гэдгийг баттай олж мэджээ.

Хүн мичнээс үүсээгүй	Үнэр идэгч
1. Эхэд харьцуулал байна уу?	
	<p><i>Тийм.</i> Тодорхой сэдвийн доторх нэг зүйлийг бус, олон зүйлийг харьцуулсан. Жишээ нь: Зөвхөн хүний үнэрлэх эрхтний тухай биш,</p>
2. Эхэд тухайн зүйлийн шинж чанарыг элдэв зөрчилгүйгээр баталсан уу?	
	<p><i>Үгүй.</i> "...амаараа биш, хамраараа ярьдаг байжээ" гэснийг үзвэл үнэмшиж боломгүй атлаа үнэн зүйлийн тухай ярьж байна. Өөрөөр хэлбэл, тухайн юм үзэгдлийн учир зүй наанаа зөрчилдөвч цаад зүй тогтлоороо өөр хоорондоо шалтгаалалцан нийцсэн өгүүлэмж болохын хувьд эргэцүүлсэн эсээ болж байна. ...</p>
3. Эхэд уран дүрслэл байна уу?	
	<p><i>Тийм.</i> Уул санаагаа ойлгомжтой болгохын үүднээс, уран дүрслэл, хэлц хэллэгийг түгээмэл ашиглажээ. Жишээ нь: "Үзгээр бичих"-ийг "үнэрээр бичих" гэж адилтгасан байна.</p>
4. Эхэд хэвшсэн ойлголт санаанаас өвөрмөц чухал шийдлийг дэвшүүлсэн хэсэг байна уу?	
	<p><i>Тийм.</i> Тухайн сэдвийн талаар чөлөөтэй сэтгэж, хэвшсэн ойлголт санаанд шинэ сэдэл төрүүлжээ. Жишээ нь: "Зарим ургамал, хортон шавьж очиход мөчир салаанаасаа муухай үнэр гаргаж, тэр хорхойнуудыг хөөн жигшээдгээр барахгүй энэ аюулын тухай ойр хавьдаа зар тараадаг байна" гэснээс шавьжтай тэмцэх муухай үнэрийг ялган авч, ой мод, тариалан, цэцэрлэгийг хамгаалж болох өвөрмөц чухал шийдлийг дэвшүүлсэн байна.</p>

ХОЛИМОГ НИЙЛМЭЛ ӨГҮҮЛБЭРИЙН УТГА, БҮТЭЦ, ХЭРЭГЛЭЭ

1. Энгийн өгүүлбэр холбон, нийлмэл өгүүлбэр бүтээцгээе.

Энгийн өгүүлбэрүүдийг зэрэгцүүлж холбоно уу. <i>Зэрэгцсэн өгүүлбэр</i>	Энгийн өгүүлбэрүүдийг угсарулж холбоно уу. <i>Угсарсан өгүүлбэр</i>
<div style="border: 1px solid black; padding: 5px; display: inline-block;">Гол өгүүлбэр</div> + <div style="border: 1px solid black; padding: 5px; display: inline-block;">Гол өгүүлбэр</div>	<div style="border: 1px solid black; padding: 5px; display: inline-block;">Гишүүн өгүүлбэр</div> + <div style="border: 1px solid black; padding: 5px; display: inline-block;">Гол өгүүлбэр</div>
<p>Хорь, хорин таван наснаас хүний үнэрлэх чадвар суларна. Жараад насандаа хамрын хөндийн ханан дахь судасны сүлжээ сийрэгшинэ. Салслаг хэсгийн илч нь буурдаг байна.</p>	<p>Адгуусан амьтад, хорхой шавж, ургамал хүртэл өөр өөрийн өвөрмөц тогтолцоо бүхий үнэрийн хэлтэй байдаг. Үнэрлэх эрхтнээрээ өргөн хүрээнд мэдээлэл солилцдог.</p>

2. а. Үйл явдлууд нэгнээсээ шалтгаалсан, эс шалтгаалснаас хамаарч, нэг цаг хугацаанд зэрэгцэж, эсвэл өөр цаг хугацаанд цуварч болдог. Тэгвэл дараах өгүүлбэрүүдийн үйл явдал цуварч, эсвэл зэрэгцэж байна уу гэдгийг мэдэхийн тулд задлал хийе.

Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр	Угсарсан нийлмэл өгүүлбэр
<p>- Үнэр шинжих ухаан буюу одорологийн тусламжаар янз бүрийн гоё үнэртэн үйлдвэрлэж, түүгээр орчин үеийн эмэгтэйчүүд гангалан гоёж байна.</p>	<p>- Үнэрийн тухай шинжлэх ухаан одоогоор нялх байгаа тул хүн үнэрийн нууцыг бүрэн тайлж чадаагүй явна.</p> <p>- Газар тариалангийн хортон шавжуудыг дуудах тусгай үнэр шингээсэн наалдамхай бодисыг самбарт түрхэж эрдэнэ шиш, хөвөн, улаан лоолийн тариалангийн захад босгож, хортонг цуглуулан наалдуулж устгадаг арга нь үнэндээ “үнэрийн хэл”-ийг ашиглан устгаж буй хэрэг юм.</p>

б. Дээрх гурван өгүүлбэрийг гишүүдээр ялган тэмдэглэнэ үү.

в. Дараах өгүүлбэрүүдийг задалж, ямар өгүүлбэр болохыг тайлбарлаарай. Өгүүлбэр тус бүрийг дугаарлан бичихдээ, юугаар холбогдсоныг ялган бичиж, зэрэгцсэн ба угсарсан (гишүүн өгүүлбэр) ямар өгүүлбэр болохыг зохих тэмдэгтээр хааж, нээж бичнэ үү.

Үйлгэрлэвэл:

1. [Хүн хамраа бөглөөд бай-вал].....(угсарсан өгүүлбэр)
2. ходоодны шүүсний шүлтлэг чанар нь буур-ч,(зэрэгцсэн өгүүлбэр)
3. элэг бөөрний ажиллагаа удаашир-ч,(зэрэгцсэн өгүүлбэр)
4. [цөс ялгарах-и^{нтэ} нь].....(харилцан угсарсан өгүүлбэр)
5. [багас-ж,].....(зэрэгцсэн өгүүлбэр)
6. улмаар шүд үйрэмтгий бол-ж,(зэрэгцсэн өгүүлбэр)

7. цусанд гемоглобин буур-на.

Энэ өгүүлбэр нь холимог нийлмэл өгүүлбэр болно. Учир нь, энгийн өгүүлбэрүүд нь угсрах (1), зэрэгцэх (2, 3, 5, 6), харилцан угсрах (4) холбоогоор холилдон холбогдсон байна.

Ажиллах өгүүлбэр:

1. Харилцааны болон мэдээллийн хэрэглүүр дуу авиагаар буюу механик аргаар л байж болно гэж үздэг үзэл одоо нэгэнт өөрчлөгдөж “үнэрийн буюу химийн хэл” гэгч бүхэл бүтэн систем нэмэгдлээ.
2. Үнэр шинжих ухаан (одорология) хөгжиж, үнэр нь долгион хэлбэрээр, хийн маягаар, нэвчих юм уу шингэх аргаар тархан түгдгийг нэгэнт нарийвчлан мэджээ.
3. Хамраараа хаана хоол унд, аюул осол байгааг, ижил сүрэг нь хаагуур явсан, тэдэнтэй ямар тохиолдол учрал болсон, тэд юу хийцгээсэн, нутгийн хязгаар хаана дуусах тэр бүхнийг үлдээсэн үнэрээр нь ялган танина.

3. Холимог нийлмэл өгүүлбэр хэрхэн холбогддогийг ажиглаж, дүгнэлт гаргаарай.

1. Үнэрийн харилцааг судлах-ын тулд.....*холбох үгээр*
2. амьтан, ургамлын үнэр солилцооны томъёог тодорхойл-ж.....*нөхцөлөөр*
түүндээ тулгуурл-н.....*нөхцөлөөр*
толь бичгийг бий болгууштай хэмээ-н...*хэмээ- язгуурт үйл үгээр*
үзэж буй бөгөөд.....*холбох үгээр*
3. амьтны ертөнцийн гол нууцад нэвтэр-х.....*нөхцөлөөр*
4. түлхүүр нь үнэрийн хэл болох ажээ.

4. Холимог нийлмэл өгүүлбэрийн бүтцийг тохирох жишээтэй нь харгалзуулаарай.

- | | |
|---|--|
| <p>а. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн аль нэгэнд эсвэл аль алинд нь гишүүн өгүүлбэр угсарч холбогдсон.</p> | <p>1. <i>Цас ормогц хүүхдүүд дулаан дээлээ өмсөж, анчид мөр хөөв.</i></p> |
| <p>б. Гол өгүүлбэрийн аль нэг гишүүнд хоёр ба түүнээс дээш өгүүлбэр зэрэгцэн холбогдсон.</p> | <p>2. <i>Өлөн чоно гүйцэшигүй, өшөөтөн дайсан барьшигүй, муу эзэнд учиршигүй энэ хүлэг бол бат идэр хурдан хүлэг ээ.</i></p> |
| <p>в. Гол өгүүлбэрийн аль нэг гишүүнд хоёр ба түүнээс дээш гишүүн өгүүлбэр тэгш эрхтэй захирагдаж холбогдсон.</p> | <p>3. <i>Тал уужирч, тариа долгион, трактор комбайн хүнгэнэн, ажил өрнөхлөөр хүн бүр баяртай.</i></p> |
| <p>г. Гишүүн өгүүлбэр нь хоёр ба түүнээс дээш гол өгүүлбэрийн аль алинд захирагдаж холбогдсон.</p> | <p>4. <i>Хасаг тэрэгний хяхнах тутам Лувсангийн сэтгэл уйтгарлаж, хүрэн шарын хашигнах бүр түүний уур хүрнэ.</i></p> |

5. Энгийн өгүүлбэрийг тохирох холбоосоор холбож, зөв найруулгатай нийлмэл өгүүлбэр бүтээж бичээрэй.

Африк шиг агаар нь нэмэх 50 хэм хүртэл хал-	-х -сан -даг -гч	газрын халуун агаарыг аль ч хүний хамар 36-37 хэм хүртэл хөргө-	-ж -н -өөд	уушгинд дамжуулдаг	бөгөөд буюу ба агаад тул учраас	хамар үнэндээ гайхамшигтай эрхтэн мөн.
---	---------------------------	---	------------------	--------------------	---------------------------------	--

- Өгүүлбэрийн холбоосыг солиход утга, бүтцэд ямар өөрчлөлт гарч буйг ярилцаарай.
- Зохиосон өгүүлбэрээ гишүүдээр ялган тэмдэглэнэ үү.

6. Тохирох хариултыг сонгож, тайлбарлана уу.

№	Бодомж	Тийм	Үгүй
1.	Холимог нийлмэл өгүүлбэр нь өөр хоорондоо өгүүлбэрзүйн холбооны өөр өөр хэв маягаар (угсрах, зэрэгцэх, харилцан угсрах) холбогдсон байна.		
2.	Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэрийн гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн нь заахын тийн ялгалаар хэлбэржсэн байна.		
3.	Олон гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр нь дан угсруулах холбоогоор бүтсэн байдаг.		
4.	Холимог нийлмэл өгүүлбэрт харьцангуй бие даасан өгүүлбэрүүд хойно хойноосоо цуварч байрладаг.		
5.	Гурав ба түүнээс дээш өгүүлэхүүн төвтэй нийлмэл өгүүлбэрийг олон гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр, холимог нийлмэл өгүүлбэр гэсэн хоёр хэв шинжид хуваана.		
6.	Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр, угсарсан нийлмэл өгүүлбэр нь нэг юм уу, эсвэл хоёр өгүүлэхүүн төвтэй байна.		

7. Өгүүлбэрийн найруулгын алдааг засаад, холимог нийлмэл өгүүлбэр болгон сийрүүлж бичээрэй.

Тухайн үед хэзээ, хаашаа нисэх билет авсан гэдгээрээ та ч гэсэн хөнгөлөлт авч болно. Бээжинд 6 сарын хугацаатай билет авбал 235 мянга болно. Тэгэхлээр билет гэдэг чинь талхны үнэтэй адил хатуу эд биш байгаа биз дээ. (Сониноос)

ТОДОРХОЙ АСУУДЛЫГ СЭТГЭГДЭЛ, ҮЗЭЛ БОДОЛТОЙГОО ХОЛБОН ОЛОН ТАЛААС НЬ ЭРГЭЦҮҮЛЭН БИЧИХ

Бичихдээ зорилго, агуулга, бүтэц, өнгө аяс, уншигч зэргийг цогцоор харгалзан, дүр дүрслэл, баримт мэдээллийг зохистой ашиглан зөв найруулах нь чухал.

Сонгосон сэдвийн хүрээнд бичихдээ юуны өмнө дараах асуултад хариулт олохыг хичээгээрэй. Үүнд:

- Ямар ямар асуудлууд байна вэ?
- Юуг сонгож, юуг нь чухалчлах вэ?
- Асуудлын талаарх хүмүүсийн сэтгэгдэл, үзэл бодол ямар байгаа бол?
- Асуудлын талаарх өөрийн тань үзэл бодол юу вэ? Асуудлыг аль талаас нь харж бичих вэ?
- Асуудлыг шийдэхийн тулд олон талаас үзсэнээ яаж нэгтгэн дүгнэх вэ?

Энэчлэн бүх зүйлийг тооцож, төлөвлөж, мэдээлэл цуглуулж, боловсруулж, ноороглож, хянаж, дахин засварлаж, сайжруулсаар эцэслэн дуусгана.

1. Зааврын дагуу эргэцүүлсэн эсээ бичнэ үү.

а. “**Нойрноос морио гэдэг ч ...**” сэдвээр хоёр буюу хэд хэдэн зүйлийг харьцуулан харшуулж гол санаагаа илэрхийлэх замаар эргэцүүлсэн эсээ бичнэ. Та нар ямар нэгэн таамаглал дэвшүүлбэл илүү сайн. Юуг баталж, юуг үгүйсгэмээр байна?

б. Бичихийн тулд хамгийн чухал санааг эхэлж гаргаад цааш дэлгэрүүлж бичнэ. Үүний тулд дараах сонирхолтой баримтаас сонгож ашиглаарай. Алийг нь дэмжиж бичмээр байна? Алинтай нь санал нийлэхгүй байна вэ?

в. Одоо агуулгын гол хэсгүүдийг дараах төлөвлөгөөний дагуу бичээрэй.

Судлаачдын нотолж байгаагаар хүн 6-7 хоног нойргүй байхад үхэх аюул тулгарна.	Нойрноос морио Чөмөгнөөс хутгаа
Аугаа Эйнштейн нойр сайтай хүний нэг байсан бөгөөд өндөр насалжээ.	Нойртой хүнийг сэрээхэд бэрх Залхуу хүнийг зарахад бэрх
Францын цэргийн алдарт жанжин Наполеон ямагт “мулгуу тэнэгүүд хийгээд сохор доголон хүмүүст л их нойр хэрэгтэй” гэж үздэг байж. Мань эр шөнийн 10 юм уу, 12 цагаас 2 цаг хүртэл унтаад босож ажилладаг, тэгээд дахин унтаж өглөөний 5-7 цаг хүргэдэг байжээ. Ажилч хөдөлмөрч энэ хүн 52 насалжээ.	Барс цагт босохгүй бол өдрийн ажил алдана Багадаа эрдэм сурахгүй бол насны ажил алдана.
Ерөнхийлөгч Пол Берг нойрыг тун эрхэмлэдэг, ялангуяа өдөр унтах тун ч дуртай нэгэн байв. Тэрээр ерөнхийлөгч болуутаа анхны зарлигаа юун тухай гаргасан гэвч. Энэ нь өдрийн хоолны дараа унтаж амрах байлаа.	Нойр гэгч биеийн жаргал бөгөөтөл унтаж хэтэрвэл өвчин болно.
Нойртой хоноё гэвэл Нохойгоо сайн торд Ноён больё гэвэл Зарцаа сайн торд.	Нойрондоо дарагдвал оройтохын тэмдэг Хоолондоо дийлэгдвэл үгүйрэхийн тэмдэг.
Нойр алдахгүй Морь эцээхгүй явж авах	Нойроо тэвчихгүй бол манаа бүү мана Эвээ чадахгүй бол яарч бүү ханил.

Нойр ноёноос айхгүй	Нойрмоглож суухаар Ном уншиж суу
Юуг ч бүү илүүдүүл. Эрт унтаж, эрт бос. Хүнийг эрүүл, баян, ухаалаг байлгадаг зүйл ердөө энэ. (Б.Франклин)	
Халуун орны урт хөлт, өндөр хүзүүт анааш өдөрт ердөө хоёрхон цаг унтдагаараа бусдаас онцгой гэнэ. Харин жижиг биетэй харх хулгана бүтэн 13 цаг унтдаг бол хүн 8 цаг, морь 3 цаг, далайн гахай 10 цаг, хэрэм 14 цаг унтдаг ажээ. Нэг сонирхолтой нь, далайн гахай гэгч амьтан усан доор 5-10 минутаас илүү байж чаддаггүй мөртөө хуурай эрэг дээр гараад нэг их унтаад байдаггүй хэрнээ усандаа л унтаж сурчээ. Тэгэхдээ бүр 10 цаг унтдаг нь сонин. Эрдэмтэд олон туршилтын явцад үүний учрыг олжээ. Далайн гахай унтаж байхад тархины нь хоёр тал ээлжлэн унтаж, сэрж байдаг учраас тэр унтаж байхдаа ч усан доор хэсэг байснаа амьсгалахын тулд мандал дээр гарч ирдэг байна.	

Эхлэл хэсэгт “Нойрноос морио гэдэг ч ...” гэсэн сэдвийн ерөнхий хүрээнд өөрийн үзэл бодлоор асуудал дэвшүүлэн бичээрэй. Үүнд, чиний өвөрмөц сөргүүлсэн санаа юу байж болох вэ?

Жишээ нь:

Оюун ухаан бидэнд нэг л замаар, гэхдээ нэг хэмээрээ явахыг тушаадаг; хэдийгээр ухаантай хүн хүсэл шуналдаа хөтлөгдөж замаасаа гарч зүгээ алддаггүй ч, алхаагаа хурдасгах, эс бөгөөс сааруулах явдал тохиолдоно. Бүр хамгийн төлөв төвшин хүнд ч дүрэлзэж догдлох, судасны нь цохилт түргэсэх үе гардаг гэж би боддог юм. Тиймээс зарим нэг аугаа их хүн тун чухал үед ч тайван, үл ажрах байдлаа хадгалж, тэр ч бүү хэл өөртөө нойр авах цаг гаргаж чаддаг байсныг нь үнэхээр ховор явдал гэж хэлүүштэй.

(Мишель Дө Монтэн. “Нойрны тухайд” эсээнээс)

Гол хэсэгт үзэл бодлоо дээрх баримтууд болон өөр бусад баримтыг ашиглан нотолж батлаарай.

Жишээ нь:

Дарийтай шийдвэрлэх тулалдаан хийхээр товлосон өдрөө Их Александр удтал маш бөх нойрссон бөгөөд байлдаан эхлэх цаг нэгэнт болчихсон тул Парменион амралтынх нь асарт орж хаанаа сэрээхийн тулд хоёр гурван ч удаа орных нь хажууд очиж дуудсан гэдэг.

Амиа хорлохоор шийдсэн яг тэр шөнөө Ромын эзэн хаан Отон гэр орныхоо бүх ажил хэргийг цэгцэлж, бэлэн мөнгөө зарц нартаа хуваан өгч, илднийхээ үзүүрийг хурцалчхаад, өөрийнх нь хүмүүс бүгдээрээ аюулгүй газарт нуугдаж амжсан эсэх тухайд хэл хүлээх зуураа нам тайван унтсан байна. Зарц нар нь бүр хурхирч байхыг нь сонсчээ.

Энэ эзэн хааны үхэл аугаа их Катоны үхэлтэй олон талаар, жижиг сажиг зүйлээрээ ч төстэй: Катон амиа хорлохоор зэхэн бүхнийг зохицуулж, аврахыг хичээсэн сенатчдаа хөлөг онгоцонд суугаад боомтоос хөдөлсөн тухай мэдээг л гагц хүлээж ахуйдаа нам унтсан бөгөөд зэргэлдээ өрөөнд жигдхэн амьсгаа нь дуулдаж байж. Боомт руу илгээсэн зарц нь түүнийг сэрээгээд хүчтэй шуурга дэгдсэний улмаас сенатчид задгай тэнгист гарч чадахгүй байгаа тухай дуулгахад, тэрээр ахин нэг хүнийг тийш явуулчхаад эргэн хэвтэж, мөнөөх элч нь сенатчид боомтоос хөдөлсөн тухай хэл авчрах хүртэл зүүрмэглэжээ.

Каталинагийн хуйвалдааны үеэр Помпейг цэрэгтэй нь буцаан дуудах тухай тогтоол гаргахыг хүссэн ардын трибун Метеллийн дэгдээсэн үймээнээс болж Катонд аймшигтай аюул учрахад тэрээр Александртай ч харьцуулж болохуйц биеэ авч явжээ. Дээрх тогтоолыг Катон л ганцаараа эсэргүүцэж байсан тул Метелл тэр хоёр сенат дээр хэрэлдэж, бие биедээ бүдүүлгээр заналхийлэхэд хүрцгээж. Харин эцсийн шийдвэрийг маргааш нь төв талбай дээр гаргах болсон бөгөөд тэртэй тэргүй, ард олны хийгээд Помпейн талд ашигтай байдлаар үгссэний улмаас Цезарийн дэмжлэгийг хүлээж хүчирхэгжсэн Метелл асар олон боолоор хүрээлүүлэн тийш ирэх ёстой байхад, Катон ердөө л эрс бардам зангаараа зэвсэглээд хүрч очихоор хатуу шийджээ. Үүнд ойр дотно хүмүүс, найз нөхөд нь маш их түгшиж, зарим нь бүр шөнөжин унталгүй, түүний хажууд байлцжээ. Эхнэр, эгч дүү нар нь гэртээ уйлалдаж байсан гэдэг. Катон ер сандралгүй, тэднийг тайвшруулж, ердийнхөөрөө оройн хоолоо идчихээд, унтахаар явжээ. Нөхдийнх нь нэг халз тулааны цаг болсныг сануулах хүртэл тэр маш бөх унтсан аж. Энэ хүний цаашидын амьдралаас бид аугаа их чанар, эр зоригийг нь бэлээхэн мэдэх тул, сэтгэл донлом үйл явдлыг ч ердийн хэрэгт тооцдог хосгүй дээгүүр сэтгэлээс л ийм авир төрөн гарна биз ээ хэмээн итгэлтэй дүгнэх боломж олдож байна.

Сицилийн эрэг орчимд болсон тэнгисийн тулалдаанд Август алдарт Помпейн хүү Секст Помпейг ялахдаа, яг тулалдаан эхлэхийн өмнөхөн гүн нойронд автаж, нөхөд нь түүгээр байлдаан эхлэх дохио өгүүлэхийн тулд сэрээж байв. Хожим нь Марк Антоны түүнийг цуст тулааныг нүдээрээ харахаас, цэргүүдийн өмнө гарахаас айсандаа ялалтын тухай Агрипп дуулгах хүртэл бүгсэн хэмээн шүүмжилсэн юм.

Бага Марийн хувьд харин тоогүй явдал тохиолдсон гэдэг. Султай хийсэн сүүлчийн тулалдааныхаа өдөр цэргүүдээ байрлуулж, байлдааныг эхлэх тушаал өгчхөөд, модны сүүдэрт жаахан амрахаар хажуултал нам унтаж орхиж. Түүнийг сэрээхэд салам цохиулсан цэрэг нь зугтаж байсан тул тулалдаан хэрхэн өнгөрснийг ч харж чадаагүй аж. Тэрээр цурам ч хийлгүй удал зүтгэсний эцэст ийн сульдаж унасан гэлцдэг бөгөөд байгаль эцсийн эцэст өөрийнхөөрөө шийдсэн нь тэр.

(Мишель Дө Монтэнь. “Нойрны тухайд” эсээнээс)

Төгсгөл хэсэгт үзэл бодлоо дахин илэрхийлж, дүгнэлт гаргаарай.

Жишээ нь:

Ер нь нойр гэдэг бидний амьдралыг өөрөөсөө хамаатуулдаг тийм зайлигүй зүйл мөн үү гэдгийг эмч нар шийдэх учиртай биз. Юутай ч, бид Македоны сүүлчийн хаан Персейг ромчууд олзолж аваад, унтах боломж олгохгүй зовоосоор үхүүлсэн жишээг мэднэ. Харин Плиний огт унталгүй он удаан жил амьдарсан хүмүүсийн тухай өгүүлсэн байдаг.

Хагас жил унтчихаад, хагас жилийн турш цурам хийлгүй сэргэлэн цовоо явдаг хүмүүс бүхий овог аймгууд байдаг талаар Херодот дурдсан нь ч бий.

Сэтгэгч Элименидийн амьдралыг бичсэн хүмүүс түүнийг нэг ч сэрэлгүйгээр тавин долоон жил унтсан хэмээн баталцгаадаг юм билээ*.

* - Крит арлаас гаралтай, нийтийн тооллын өмнөх V зууны үеийн Эртний Герегийн энэ гүн ухаантан 300 насалсан гэж түүхэнд бичээтэй буй.

(Мишель Дө Монтэнь. “Нойрны тухайд” эсээнээс)

г. Мишель Дө Монтенийн “Нойрны тухайд” эсээний талаарх саналаа солилцоорой.


д. Бичсэн эсээгээ дараах шалгуурын дагуу үнэлж, сийрүүлээрэй.

- Хөтөч өгүүлбэр нь гол санааг оновчтой илэрхийлэхэд хөтөлж чадаж байна уу?
- Үндсэн хэсэг бүрийн санааг хадгалсан шинэ өвөрмөц санаа бүхий толгой өгүүлбэртэй юу?
- Баримт жишээ, мэдээлэл, тайлбар нь сэдэвтээ тохирсон уу?
- Толгой өгүүлбэрийн гол санааг дэмжсэн янз бүрийн жишээ, тайлбар, баримт нь учир зүйн зөв дараалалд орсон уу?
- Эхийн цогцолбор хоорондын уялдаа холбоог хэр зөв гаргасан байна вэ?
- Дүгнэлт нь оновчтой болж чадсан уу?
- Сайн эхэлсэн шигээ сайн төгсгөж чадсан уу?
- Найруулгын болон зөв бичих дүрмийн алдааг сайтар хянасан уу?

ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ

Дараах баримт ба уран сайхан хосолсон өгүүлбэрийг уншаад, даалгаврыг хийгээрэй.

- Намар тэд буцахын цагтаа томоохон нууруудад тал талаасаа цугларч, хэд хонодог. Манайхан үүнийг хунгийн чуулга гэнэ. Дарьганга нутгийн Ганга нуур хунгийн чуулгаараа алдартай.
 - Жил жилийн намар хунгийн сүрэг дулаан орноо зорихын өмнө Ганга нууранд мянга мянгаараа сүрэглэн буудалладаг. (Ай.Төмөр-Очир)
 - Нуур санаа алдан гөлөрч хойноос нь ширтсээр хөлдөж, байгаль эхийнхээ аалийг аргадан хоног тоолон хүлээсээр нарыг наашлуулна. **Нэг л мэдэхнээ урь унаж, ус гэмсэгц дулаан орны хун шувуудын аргамжаа аргагүйн эрхэнд алдуурахад нуур нулимсаа мэлмэрүүлэн дэвхцэж хүлээдэг ээ.** (Ай.Төмөр-Очир)
 - Монголчууд аль 13-р зууны үеэс хун агнахыг хориглож байсан гэдэг. Манайд гангар, гунгар, хуруут хэмээх гурван төрлийн хун ирж зусдаг гэсэн мэдээ бий.
 - Намар оройн Гангад өглөө, оройдоо хунгийн ганганаа уянга түрэн эгшиглэх нь газар тэнгэрийн савслага дахь найрал хөгжим мэт байдаг. (Ай.Төмөр-Очир)
 - **Тэр жил Якутаас ирсэн хоёр найрагч Дарьгангаар зорчихдоо хун чуулахыг үзээд мэлмэртлээ уйлж байхыг хараад үнэхээр гайхан биширч явснаа хуульч Гансүх дурсан ярьсан байдаг.**
 - Хун чуулах үедээ алс хол нисэх бэлтгэлээ базааж, бага залуу нэгэндээ хол нисэх дадлага олгодог гэнэ.
 - **Оройн намрын Ганга захаасаа зайрмагтаж, дотогшилсоор хунгийн сүрэг аргагүйн эрхэнд халуун орноо зорин нисэх нь нэг л өглөө.** (Ай.Төмөр-Очир)
- а. Баримт ба уран санааг зөв байрлуулан, хослуулан найруулж, өөрийн санаагаар баяжуулаад эргэцүүлсэн эсээ бүтээгээрэй.
- б. Эсээгээ ямар сэдвээр бичих сэтгэгдэл төрж байна вэ? Сэдвээ сонгож төлөвлөөрэй.
- в. Эхэд ямар асуудлыг дэвшүүлмээр санагдаж байна вэ?
- г. Төгсгөлд дэвшүүлсэн асуудлаа дүгнээрэй.
- д. Онцолсон өгүүлбэрүүдийн бүтцийг тодорхойлоорой.



IV БҮЛЭГ

ТОЛЬ БИЧИГ, ТҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ

Эзэмших мэдлэг, чадвар

- Толь бичгийн төрөл, тэдгээрийн үүрэг, зориулалтыг мэдэх
- Монгол толь бичгийн уламжлал
- Толь бичгийг зөв ашиглах

ТОЛЬ БИЧГИЙН ТӨРӨЛ, ТЭДГЭЭРИЙН ҮҮРЭГ, ЗОРИУЛАЛТ

Толь бичгийг яагаад хэлний эрдэнэсийн сан гэдэг вэ?

Эхийн хэсгүүдийг уншихдаа дараах асуудлыг анхаарч, тайлбарлахад бэлтгээрэй.

1. Тухайн эх тус бүрээс өөрт чинь таалагдсан, оновчтой, шинэ санаа илэрхийлсэн ямар өгүүлбэр байна вэ?
2. Эхүүдэд ямар нийтлэг ба ялгаатай санаа байна вэ? Тайлбарлаарай.
3. Толь бичиг ямар ач тустай вэ?

А эх

“Толь бичиг бол цагаан толгойн үсгийн дараалалд оруулсан ертөнц мөн” гэж хэлсэн Францын алдарт зохиолч Антоль Франс толь бичигтэй холбогдуулан нэгэн удаа ийм зүйл өгүүлжээ.

Тухайн үед олонд алдаршаагүй залуу яруу найрагч Шарль Бодлер нэрт яруу найрагч Теофиль Готье-тэй уулзахаар нэгэн удаа гэрт нь иржээ. Тэд ярилцаж байгаад Готье Бодлероос:

- Чи толь бичиг уншдаг уу? гэж асуужээ. Тэгэхэд нь залуу яруу найрагч:
- Уншдаг, хэрэг болсон үед зайлшгүй уншина л даа гэжээ. Готье их л халуун дотноор:
- Зохиолч хүнд энэ бол маш чухал зүйл. Толь бичгийг уншсанаар үнэхээр их зүйл мэдэж авдаг юм шүү гэхэд Бодлер:
- Толь бичгийг байнга унших гэж үү? Яасан сонин юм бэ? Энэ чинь роман биш, адал явдалт зохиол биш шүү дээ. Яахаараа тийм чухал байдаг байна аа. Би тодорхой үгийг яаж зөв бичих, дуудахаа мэдэхгүй үедээ л ашигладаг гэж гайхан хариулав. Тэгэхэд нь Готье:
- Толь бичиг чинь зөвхөн үгсийн тайлбар, лавлах төдий зүйл биш шүү дээ. Харин үндэсний соёлын нэг хэсэг шүү дээ. Хэлний үг хэллэгт тухайн ард түмний амьдралын олон талт онцлог нэвт шингэсэн байдаг юм гэдгийг ойлгох хэрэгтэй гэж зөвлөжээ.

“Энциклопедия для детей” Том.10. Языкознание, Русский язык. Москва, Аванта, 2001, стр. 58.(Орчуулж авав)

Б эх

Монголчууд бичиг соёлын эртний уламжлалтай. Тэрхүү бичиг соёлын арвин баялаг уламжлал нь гарваль ба дуурьслын сан хөмрөгт хадгалагдаж, үеийн үед үл тасрах эрдэнэсийн хэлхээ болон дархлаажсан байдаг. Аливаа үндэстний соёл, сэтгэлгээ нь тухайн үндэстний хэлэнд, тухайлбал үг хэллэгт нь тусаж, дуурьслын сан хөмрөг болдог.

Монголчуудын соёл, сэтгэлгээний онцлогийг тусгасан үг хэллэгийн уурхай дундаршгүй их нөөцтэй. Тийм ч учраас баян тансаг үгийн сантай, аялгуу сайхан монгол хэл маань үндэстний оршин байх нэг баталгаа мөн.

Хэлний үгийн сан үргэлж арвижин баяжиж байдаг дундаршгүй эх ундаргатай. Энэхүү эх ундаргыг ариун дагшин байлгаж, түүнээс ундаалж, оюун ухаанаа тэтгэн тэжээж байх халдашгүй эрх үндэстэн бүхэнд заяажээ. Дуусашгүй эх ундаргатай монгол хэлнийхээ

үгийн их уурхайг уудалж, байгаа нөөцийг нь бүрэн дүүрэн тогтоох боломж үндэстэн бүхэнд байх боловч өнөө хүртэл тийм хүнд хэцүү ажлыг хэн ч хийсэнгүй. Ер нь цаашид ч хийхгүй биз ээ. Энэ нь өөрөө ийм байх зүй тогтолтой үзэгдэл юм. Нэг ч хором зогсолтгүй баяжиж байдаг юмыг тухайн цагт тохирсон тоо хэмжүүрээр тогтоох боломж нь хязгаарлагдмал байдаг. Харин тэр далай баялаг үгийн сангаас тухайн цаг үед хамгийн хэрэгцээтэй үгсийг нь шүүрдэн сонгож, тольчлон цомоглох буянтай үйлсийг үе үеийн эрдэм төгс мэргэд, бичгийн хүмүүс нэн эртнээс хийж иржээ.

Толь бичиг бол бүх нийтийн ерөнхий боловсрол, тусгай мэргэжил, эрдэм ухааны хэрэгцээнд зориулан сонгож цомоглосон үг хэллэгийн сан хөмрөг юм.

Ц.Өнөрбаян. Толь бичгийн хөгжлийг үечлэх асуудалд (2008) өгүүллээс хэсэглэн авав.

В эх

Толь бичиг гэдэг нь үгийн жагсаалт бүхий ном бөгөөд зөвхөн жагсааснаар хязгаарлагдахгүй уг үг ямар зүйл, ямар үйл явдлыг заасан болох, яаж бичиж, хэрхэн дууддаг, яаж хувилдаг зэргийг тайлбарласан, эс бөгөөс өөр нэг хэлний утга таацах үгтэй дүйлгэсэн байдаг билээ. Толь бичгийн тухай ярихын өмнө түүний үүсэл түүхийн талаар товч дурдах нь зүйтэй буй за. Судлаачдын тодорхойлсноор бичиг үсэг буй болсон тэрхүү дээр цагт толь бичиг үүссэн гэж нэгэн дуунаар зөвшөөрч байна. Харь болоод харь бус аль нэгэн хэлээр бичсэн бичгийг уншиж тайлах, эсвэл ямар нэгэн бичигт буй утга учир нь бүгт (тодорхойгүй) буюу хуучин үг хэллэгийг тайлбарлах зэрэг аж төрөхийн шаардлагаар хүн төрөлхтөн толь бичиг анх зохиож эхэлсэн ажээ.

...Толь зүй гэдэг бол хэл шинжлэлийн нэг томоохон бие даасан салбар ухаан. Толь бичиг гэдэг бол эхлээд толь зүйн үүднээс арга зүйгээ зөв боловсруулах, өргөн мэдлэг, цаг хугацаа, тэсвэр тэвчээр шаарддаг хүнд хүчир ажил бөгөөд тэр хэрээрээ ганц сэдэвт хийгээд зэрэг горилох зохиол бичихтэй огт адилгүй, гол онцлог нь олон түмэн хэрэглэгчээ тухайн хэлний зөв тогтолцооны зүгт заан хөтлөх үүрэгтэй байдагт оршино. Тийм ч учраас маргаантай, хэл шинжлэлийн үүднээс буруу зүйлийг толь бичигт оруулах ёсгүй.

Ц.Шагдарсүрэн. Монгол толь бичгийн уламжлал (2008) өгүүллээс хэсэглэн авав.

1. Эх тус бүрийн агуулгыг нь харьцуулаад нийтлэг ба ялгаатай санаа гаргана уу? Тайлбарлаарай.
2. Толь бичиг ямар ач тустай вэ? гэдгийг ярилцаарай.
3. Эдгээр мэдээллээс толь бичгийн талаар ямар ойлголт авснаа дүгнэж цэгцэлнэ үү.

Ойлголтоо нэгтгэе.

- а. “Толь бичиг хэлний эрдэнэсийн сан мөн.” гэсэн онч үгийн санааг дэлгэрүүлэн тайлбарлана уу.
- б. “Толь бичиг бол цагаан толгойн үсгийн дараалалд оруулсан ертөнц мөн.” (А.Франс) гэсэн онч үгийн утга санааг дэлгэрүүлэн тайлбарлана уу.
- в. Тухайн хэлний бүх үгийг нэг толь бичигт багтаан цомоглож болох уу?
- г. Толь бичгийн ач холбогдлыг дээрх эхүүдэд тулгуурлан тайлбарлаарай.
- д. “Чухамдаа толь зохиох гэдэг нь маш хүнд хүчир атлаа бодитой үнэлэгддэггүй ажил тул түүний алдаа мадагт нь ядаж ээвэргүү хандвал зохино” гэж Оросын эрдэмтэн А.И.Соболевский (1856-1929)-н хэлсэн санааг дэлгэрүүлэн тайлбарлаарай.

1. Толь бичгүүдээс сонгож авсан дараах баримтуудыг уншиж, “зүрх” хэмээх үгийн утгыг яаж тайлбарласныг ажиглаад, өгсөн даалгаврыг гүйцэтгэнэ үү.

1. **Зүрх**- Зүрх судасны тогтолцоо буюу цусны эргэлтийн гол эрхтэн. Анатомийн бүтцийн хувьд булчинлаг хөндий эрхтэн. Зүрх бол өөр лүүгээ цугтах венийн судсаар орох цусыг хүлээн авч, улмаар тэр цусыг уушгиар дамжуулан артерийн судсаар бие эрхтэнд тараадаг. Зүрх нь цээжний хөндийн зүүн тал, өвчүүний арын хэсэгт байрладаг... Насанд хүрсэн эрэгтэй хүний зүрх дунджаар 322-340 гр, эмэгтэй хүнийх 250-280 гр орчим байна. Зүрх хөндлөнгөөрөө 9-11 см, урд, ард хэсэг нь 6-8 см, урт нь 10-15 см, тосгуурын хананы зузаан 4-6 мм, зүүн ховдлын хананы зузаан дунджаар 9-11 мм орчим байна... (*...толиос хэсэглэн авав*)

2.1. **Зүрх** игоке 1. Хүн амьтны цусны эргэлтийн гол эрхтэн: **зүрх дэлсэх** (зүрх түг түг хийх)-Өвчтөний зүрх нь дэлсэж амьсгаа нь давхцан эхлэв. “Эрүүл мэнд” сэтгүүлээс; **зүрх өвдөх** (зүрх хөндүүрлэх, зүрхний өвчин эхлэх)-Бадарчийн зүрх нь өвдөөд хэд хоногоос эмнэлэгт хэвтэх байх гэнэ. “Хөдөлмөр” сонин;...**зүрх судас** хоршоо (хүн амьтны цусны эргэлтийн гол эрхтэн болоод цус гүйх гуурс)...2. Зориг цөс: **зүрх аллах** (айж төвөгшөөх)-Хэлтсийн даргын ширүүн харцаас зүрх алдаад байна. “Утга зохиол, урлаг” сонин; 3. Гол чухал: **амин зүрх** (амин гол)-Миний амин зүрх тэр явж байна. С.Эрдэнэ “Хулан бид хоёр”. **зүрхний угаас** (нэн дотноор, сэтгэлээсээ) (*...толиос хэсэглэн авав*)

2.2. **Зүрх** 1. сердце; **зүрхний цохилт** стук сердца сердцебиение; **зүрх шархлах** а) ранить в сердце; б) нанести сердечную рану; в) причинить душевную боль; 2. перен. сердечность, смелость отвага; Үүнийг хийхийн тулд зүрх хэрэгтэй. Это сделать нужна смелость; **зүрх алдах** потерять присутствие духа; пасть духа (буквь. Сердце упустить) (*...толиос хэсэглэн авав*)

heart [ha:t] n.1 зүрх **have~troubles/disease** зүрх муутай; зүрхний эмгэгтэй/ өвчтэй; 2. Зүрх сэтгэл **at heart** сэтгэлдээ, зүрхэндээ; **from one's heart** чин сэтгэлээсээ **cry one's heart out** дотроо онгойтол уйлах; 3. Мөн чанар, утга агуулга, учир **get to the heart of subject** хэргийн учрыг олох. 4. Гол, цөм **in the heart of the forest** Ойн гүнд... (*...толиос хэсэглэн авав*)


Асуулт даалгавар

а. Дээрх 1, 2 (2.1, 2.2) гэсэн хэсэг тус бүрээс “Зүрх” гэсэн үгийн талаар ямар ямар мэдлэг, мэдээлэл авсан бэ?

б. Эдгээр баримтуудыг харьцуулан ажиглаад ялгааг нь тайлбарлана уу?


в. 2-т авсан баримтыг яагаад 2.1, 2.2 гэж ялгасны учрыг юу гэж ойлгож байна вэ?

г. Одоо толь бичгийг агуулга, зорилгоор нь ангил гэвэл юу гэж нэрлэмээр байна?



Нэвтэрхий толь бичиг нь эрдэм ухааны ухагдахуун, ойлголтыг нэгэн тогтолцоонд оруулсан үсгийн цомог юм. Нэвтэрхий толь бичгийн нэгжид энгийн үгээс гадна нийлмэл үг, томъёо, тухайн агуулгын хүрээ, салбар ухаанд холбогдох хүн, газар усны нэр тэргүүтэн багтана. Нэвтэрхий толийг ерөнхий, тусгай буюу салбар ухааны толь гэж ангилна.

Ерөнхий нэвтэрхий толийн толгой үгийн тайлбарт хүн бүхний мэдэж байвал зохих, аж амьдралын явцад түгээмэл тохиолдох бүх юмс, тухайлбал: юмс үзэгдэл хийгээд хийсвэр ухагдахууны тодорхойлолт, алдар суут болон түүхт хүмүүс, шинжлэх ухаан, улс төрийн сонгодог бүтээлийн танилцуулга, газар усны нэрийн тайлбар тэргүүтнийг багтаасан байна.



Тусгай буюу салбар ухаан (тодорхой хүрээ)-ы толийн толгой үг нь ерөнхий нэвтэрхий толийг бодвол тооны хувьд хязгаарлагдмал, зөвхөн тухайн ухаан, хүмүүсийн нийтлэгт холбогдох юм үзэгдлийн тодорхойлолт, хүн, зохиол бүтээл, газар орны танилцуулга орсон байна.

Хэл шинжлэлийн толийг агуулга, зорилгоор нь нэг хэлний тайлбар толь, олон хэлний буюу орчуулгын толь гэж ангилна.



Тайлбар тольд тухайн хэлний гол, туслах бүх үгийг багтааж, үг тус бүрийн утга, үүргийг тайлбарлана. Толгой үгийн шууд ба шилжсэн утга, тэдгээрийн тайлбар, жишээ, зөв бичих, дуудах жишиг, ямар үгийн аймагт хамрагдах, тухайн үгтэй хоршиж хэрэглэгдэх тохиолдол, өвөрмөц ба хэвшмэл хэлц зэргийг багтаасан байна.

Олон хэлний орчуулгын толь нь хоёр ба түүнээс дээш олон хэлний үг тус бүрийн харилцан дүйх хэлбэр, утга, түүний тайлбарыг хадсан байна. Монгол хэлний орчуулгын анхны толиуд нь голдуу хятад-монгол, монгол-хятад, монгол-төвөд, төвөд-монгол, манж-монгол, монгол-манж, монгол-араб, араб-монгол гэх мэт хоёр хэлний, манж-төвөд-монгол-уйгар-хятад, манж-төвөд-монгол гэх мэт дорно дахины 3-5 хэлний толиуд байлаа. Орчин үед монгол-орос, монгол-англи, монгол-солонгос, монгол-япон, монгол-уйгар гэх мэт өрнө, дорнын хоёр хэлний толь бичиг олноор гарах болсон байна.



Агуулга, хэмжээ, зориулалт	Агуулга, хэмжээ зориулалт	Жишээ
Их гарын (дэлгэрэнгүй), бүх нийтэд зориулсан, ерөнхий (аль ч мэргэжлийн хүн ашиглана)	<ul style="list-style-type: none"> Толгой үгийн тоо олон Голдуу хоёроос дээш олон ботилсон Тайлбар дэлгэрэнгүй (баримт жишээтэй) Олон талын мэдээлэл агуулсан Номын санд голдуу байдаг 	
Дунд гарын (товч) ажил мэргэжлийн салбар ухааны хүмүүс, оюутан залууст зориулсан, тусгай	<ul style="list-style-type: none"> Толгой үгийн тоо цөөвтөр буюу бүх нийтийн өргөн хэрэглээний үгийг хамарсан Тухайн мэргэжил бүлэг хүний хэрэглээнд хамрагдах үг, нэр томъёо орсон Тайлбар товч, оновчтой, жишээ баримт цөөн, заримдаа жишээгүй Сургууль ажлын газар (ширээний), гэр оронд голдуу байна 	
Бага гарын (хураангуй), ерөнхий боловсролын сурагч, хүүхдэд зориулсан суурь мэдлэгийн чиглэлтэй	<ul style="list-style-type: none"> Толгой үгийн тоо цөөн Идэвхтэй хэрэглээний үг хэллэг орсон Цөөн мэдээлэл (зөв бичих, дуудах, гол утга гэх мэт) Цүнх, өвөр, халаасанд авч явах боломжтой. 	

Дараах толь бичгүүдийг дээрх ангилалд харгалзуулж ангилна уу. Хүснэгтийн жишээ хэсэгт дугаарыг бичнэ.

1. **Монголын үндэсний нэвтэрхий толь.** I-III боть, Улаанбаатар, 2009.
2. О. Ковалевский. **Монгольско-русский-французский словарь.** I-III боть, Казань, 1844-1849.
3. Я. Цэвэл. **Монгол хэлний товч тайлбар толь.** Улаанбаатар, 1966.
4. **Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь.** I-V боть. Улаанбаатар, 2008.
5. **English-Mongolian School Dictionary.** NEPKO Publishing, 2008.
6. **Монголын хүүхэд залуучуудын нэвтэрхий толь.** I-III боть, Улаанбаатар, 2016.
7. **Монгол хэлний толь.** ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдын хэрэглээнд. Улаанбаатар, 2014.

8. Монгол хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь. Улаанбаатар, 2015.
9. Монгол-Англи, Англи-Монгол өврийн толь. Улаанбаатар, 2008.
10. Я. Жамбалдорж. Анагаах ухааны танин мэдэхүйн толь. Улаанбаатар, 2009.

2. Дараах эхийг уншихдаа монгол толь бичгийн уламжлал ямар онцлогтойг анхаарч уншаарай.

Монгол толь бичгийн уламжлал


Монголчууд эрт цагаас эхлэн монгол хэлний янз бүрийн толь бичгийг удаа дараа зохиосоор ирсэн баялаг уламжлалтай билээ. Монгол толь бичгийн уламжлал Хүннү, Сяньбийн үеэс эхлэлтэй бөгөөд бидэнд одоогоор мэдэгдэж байгаа гарт олдсон монгол хэлний анхны толь бичиг бол 1389 онд барлагдан хэвлэгдсэн монгол-хятад хэлний “Хуа- и и иүй” толь бичиг юм. Мөн бидний гарт хүрээгүй ч, лавтай мэдэгдэж буй 1282 онд монгол бичгээр хэв сийлж тархаасан монгол нэвтэрхий толийн мэдээ занги Юан улсын сударт тэмдэглэгдэн үлджээ. Монголчуудын хүчирхэгжин мандаж байсан XIII-XIV зуунд монгол хэлний орчуулгын толь нэлээд гарчээ. Үүнд: Монгол үгийг арабаар галиглан тэмдэглэсэн араб-монгол хэлний “Мукаддимат ал-адаб” толь (XIII зуун), 1389 оны монгол-хятад хэлний “Хуа-и и иүй” толь, монгол-солонгос хэлний толь бичгийг дурдаж болно.

Уламжлагдан ирсэн монгол толь бичгийг ерөнхийд нь төрийн номын хэлний толь бичиг, шашны номын хэлний толь бичиг гэж ангилж болохоор байна.

Төрийн номын хэлний толь бичигт: Манж Чин улсын үед зохиогдсон 1717 оны манж-монгол үгийн нийт 21 дэвтэр бүхий “Хорин нэгтийн тайлбар толь”, энэхүү толийг нэмэн дэлгэрүүлсэн 28 дэвтэр бүхий “Хорин наймтын тайлбар толь”, 1746 оны манж-монгол үгийн 36 дэвтэр бүхий “Гучин зургаатын тайлбар толь”, 1908 онд чулуун бараар хэвлэгдсэн “Албан хэргийн тогтмол үг”, Ардын засгийн үед 1929 онд С. Шагжийн зохиосон “Эрэхүйеэ хялбар болгон зохиосон монгол хэлний тайлбар чандманий эрх” гэх мэт.

Шашны номын хэлний толь бичигт: Төвөд-монгол болон самгарди хэлний толь голлосоор иржээ. Үүний учир нь монголд бурхны шашны сургаал, номлол өргөн дэлгэрч, монголын эрдэмтэн зохиолч нар их, бага таван ухааны зохиол бүтээлээ гол төлөв төвөд хэлээр бичдэг байсан бөгөөд төвөд хэл нь тухайн үедээ, дундад зууны европ дахинд шинжлэх ухааны гол хэл болж байсан латин хэлтэй нэгэн адил үүрэгтэй байжээ. Энэхүү толь бичгийн зүйлд: “Таван зүйлийн үсэг хадмал зохист аялгууны толь”, “Мэргэд гарахын орон”, “Төвөд-Монгол дохионы бичиг”, “Арвай хээрийн арван дүймэн”, “Эгшгийг баясгах дууны нэмэлт тайлбар зохист аялгууны бүхний үүд” гэх мэт олон толь бичгийг дурдаж болно.

3. XVIII зууны үед зохиогдсон монгол хэлний уламжлалт толь бичиг болох Хорин наймтын тайлбар толиос “эрхлэх” хэмээх үгийн утгын тайлбарыг уншина уу. Ер аливаа хүн өөрт оногдсон ямарваа нэг ажлыг хүндэтгэн, хичээн чармайж ажиллах гэсэн санаа энэхүү “эрхлэх” хэмээх үгэнд агуулагдаж байна уу? Яагаад монгол бичигт ажил эрхлэхийн эрхлэхийг $frk\#ek$ бус, $frk\#ek$ хэмээн бичиж байна вэ? Эрхэм ($frk\#$), эрхэмлэх ($frk\#ek$) гэх үгстэй жишин бодоорой.



4. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь (2008. Д-Л)-оос сонгож авсан “жин” гэдэг үгийн тайлбарт тулгуурлан дараах даалгаврыг гүйцэтгэнэ үү.

- а. “Жин” гэсэн толгой үгсийн тайлбарт ямар ямар мэдээлэл орсон байна вэ?
- б. (ЖИН I), (ЖИН II)-үгийн тайлбарыг ажиглаад, дараах тэмдэглэгээний учрыг тайлбарлана уу.
 - Толгой үгэнд орсон 1;2;3 гэсэн араб тоогоор юуг ялгаж тэмдэглэсэн бэ?
 - Толгой үгийн ардах I;II;III гэсэн ром тоо юуг ялган зааж байна вэ?
 - Яагаад зарим үг хэллэгийг тодоор, заримыг налуу, жижиг үсгээр бичсэн бэ?
 - Тайлбарт хэрэглэсэн цэг тэмдэг тус бүрийн учрыг тайлбарлаарай.
- в. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд ЖИН I-IX буюу есөн толгой үг тайлбарласан байна. Та хэдэн янзын ЖИН гэсэн үг мэдэх вэ? Мэдэх үгээ дээрх жишгээр үргэлжлүүлэн, тольчлон тайлбарлаж бичнэ үү?

ЖИН I ^{iiät}

1. Хүнд хөнгөний хэмжээ, нэг жин нь арван зургаан лан, зургаан зуун (596,81) граммтай тэнцэнэ - *Мянган жин шороог тунгааж нэгэн ширхэг алмасыг олдог биш үү. С. Эрдэнэ. Малын хөлийн тоос*; 2. Хөл хөнгөнийг мэдэх дэнсний адил том бөгөөд иш туухайгаар бүрдсэн хэмжүүр, жинлүүр: **жингийн годил** (жингийн тухай), **жингийн туухай** (жингийн үзүүрт өлгөх, нэгэн этгээдэд дээр нь тэнцүүлэн тавьж хэмжих, хэмжээтэй төмөрлөг зүйл), **гар жин** (гараар барьж хэмжих жин, бага оврын жин), **жин хэмжүүр** хоршоо (хүндийг хэмжих багаж хэрэгсэл)- *Атан тэмээний хэрийн том бухлыг ац модоор сэвхийтэл өргөж байгаа эрчүүдийн хүдэр бор булчингууд жингийн туухай мэт зангиралдан байдаг. Ж. Дамдин. Үймээний жил*; 3. Хүнд хөнгөний багцаа: **жин алдах** (а. жин хорогдох; б. турах), **жин багасах** (хүндийн хэмжээ багасах), **жин дарах** (хүнд байх), **жин нэмэх** (хүндийн

хэмжээ нэмэгдэх), **жин хасах** (хүндийн хэмжээ багасах), **жин хөнгөрөх** (хүндээ алдах), **амьдын жин** (амьд мал амьтны цэвэр жин), **бохир жин** (хүндийн буруу дүн, дайвартай жин), **хүндийн жин** (хүндийн хэмжээ), **цэвэр жин** (бодот жин, хүндийн үнэн дүн) – *Сумнаас гаргасан дөчин жингийн иргэн хонь хоёрыг тууж иржээ. С.Дашидэндэв. Улаан наран.*

ЖИН II ^{iiət}

Аян тээвэр: **жин огторлох** (жин тээх нэг хэлбэр, жинг тээхээр тохиролцсон зарим этгээд уг ачаа барааг зохих газар нь хүргэлгүй зам зуур бусад этгээдэд анх авсан хөлснөөсөө хямд хөлсөөр дам тээвэрлүүлж, завсраас нь ашиг олохыг хэлнэ), **жин тээх** (ердийн хөсгөөр алсад ачаа бараа тээх), **жинд явах** (жин тээхэд оролцох), **жингийн тэмээ** (хол газар ачаа бараа тээвэрлэдэг тэмээ), **жингийн цуваа** (жин тээж яваа аян тээвэр)- *Итгэлийн урт жингийн цуваа хүрээнд орж ирлээ. Ч. Лодойдамба. Тунгалаг Тамир, аян жин хоршоо (олон хоногоор хол явах жин тээвэр), жин тээвэр хоршоо (ердийн хөсгөөр хийх холын аян тээвэр), жин хөсөг хоршоо (холын замд ачаа бараа тээвэрлэх хөсөг)- Анхандаа дан жингийн чиглэлийн нэгдэл гэж үүсгээд дараа нь мал аж ахуйн чиглэлд орсон байна. Б.Бааст. Алтайн хөх дөнөн.*

ЖИН III ^{iiət ...}

Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Улаанбаатар, 2008, Д-Л, 902-р тал.

5. Харь үгийн толь дахь үгийн тайлбар нь бидний танилцсан “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-иос ямар ялгаатайг ажиглаж ярилцаарай.

ДЭВТЭР

перс. *daftār*; мо.б. *ᠳᠡᠪᠳᠡᠷ* (тө: *deb-ther*; манж: *debtelin*); цаас давхарлан үдээслэн товхисон бичигтэй буюу бичиггүй цаас.

О.Сүхбаатар. Харь үгийн толь. УБ., 1997, 93-р тал.

НОМ

согд. *nwm*(<перс. *nomos*) мо.б. *ᠨᠣᠮ*; шашны сургаал, хууль; 1. ном бичиг, бурхны шашны судар; 2. Махбод хийгээд сэтгэц зүйн шинж тэмдгүүдийн эгэл жирийн маш зохистой үзэгдлийн үндэс суурийг тэмдэглэсэн буддын гүн ухааны нэр томъёо болох дхарма.

О.Сүхбаатар. Харь үгийн толь. УБ., 1997, 148-р тал.



СУДАР

самгард. *sūtra*; мо.б. *ᠰᠤᠳᠠᠷ*; “товч”; Энэтхэгийн гүн ухааны үзлийн гол утгыг илтгэсэн оновчтой үг буюу түүний эмхэтгэл гэсэн утгатай; 1. Зохиолын утгын оньсыг цөөн үгээр үзүүлсний товч хураангуй; 2. Буддын шашны зохиолыг Винайн аймаг, Авидармын аймаг, Судрын аймаг гэж гурав хуваасны гутгаарын нэр; 3. Буддын зохиосон Их хөлгөний зохиолыг судар, дандар гэж хоёр хуваасны нэгдүгээрийн нэр; 4. Аливаа ном, бичиг, түүх шастир; 5. Үдээс хавтасгүй урт хөндлөнгөөр дэвтэрлэсэн ном зохиол; удам судар (угсаа удам); нутаг дэвсгэр (газар нутаг); сударчлах (ном бичгийг судар маягтай хийх)

О.Сүхбаатар. Харь үгийн толь. УБ., 1997, 171-172-р тал.

6. Толгой үгийн агуулга, түүнд туссан мэдээллүүдийг хэрэглэе. Дараах дөрвөн толгой үгийг уншаад, тухайн толгой үг тус бүрд ямар ямар мэдээлэл байгааг ярилцаарай.

авах

ү.ү. 1.Аливаа юмыг өөрийн болгох, эзэмших: **машин авах; авахаа мэдвэл өгөхөө мэд** цэцэн. (өр зээл удаашруулж, нэхэл дагал болоход хэлэх үг); 2. Хувцас хэрэглэлийг тайлах, салгах; **бөгжөө авах**, 3. Хүн амьтны биеэс өвчилсөн зүйлийг салгах: олгой авах (мухар олгой авах, мэс засал хийх) 4. Биед ямар нэгэн гэмийн согог суух; **хатгаа авах**, 5. Нэгэнт үйлдэх санаа; **алдааг нь хэлээд авах, *хүч авах** (хүч нэмэгдэх), ***шарх авах** (шархдах), ***зүрх авах** (айх, эмээх), ***элэг авах** (инээд хүрэх, ихэд инээх), ***гартаа авах** (эрхшээлдээ оруулах)

Монгол хэлний толь. ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдын хэрэглээнд. Улаанбаатар, 2014. 3-р тал.

нүд

ж.н. 1. *бие зүй.* хүн амьтны харах эрхтэн:

нүдний уг (хүүхэн харааны эсрэг тал дахь нүдний дотор талын хэсэг)

нүдний цэцгий (нүдний хүүхэн хараа)

нүдний цэцгий (нүдний хүүхэн хараа, нүдний цэцгий томрох)

нүдний шил (нүдэнд зүүх хэрэгсэл: нүдний шил зохих)

нүд ирмэх (дохио өгөх: нүдээ ирмэнгүүт гарах)

нүд алдах (алсыг харж гүйцэхгүй байх: нүд алдам тал) б. *шилж.* гайхаж төөрөлдөх: нүд алдан алмайрах

нүд булаах (а. анхаарал сонирхол татах: нүд булаам охин; б. нүд булаасан хувцас

нүд үзүүлэх (гадуурхах, ад үзэх: юм болгонд нүд үзүүлэх)

2. дөрвөлжин юм буюу нүх: **хананы нүд** (монгол гэрийн хананы дөрвөлжин онгорхой), **шургуулгын нүд** (шургуулганы жижиг татуурга)...3. юмны цоохор толбо: **тогосны нүд** (тогос шувууны өдөн дээр байх цоохор толбо), **торгоны нүд** (торгоны хээний нэг дугуй нүд)

Монгол хэлний толь. ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдын хэрэглээнд. Улаанбаатар, 2014. 350-352-р тал.


бөөрөнхий тэм. 1. Бөмбөрцөг, бөмбөгөр, бөмбөг хэлбэртэй: **бөөрөнхий сонгино** (булцгар сонгино), *** бөөрөнхий хэлтэй** (бага зэрэг тултираа); 2. шилж. Шийдвэргүй, гуйвамтгай, тогтворгүй: **бөөрөнхий үг** (тодорхой шийдвэргүй үг)

Монгол хэлний сурагчийн тайлбар толь (Сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдад зориулав), Улаанбаатар, 2016. 101-р тал.

нян нэр. анагаах. Нүдэнд үл үзэгдэх бичил махбод; өвчин тараадаг: **нян тархах** (ямар нэгэн өвчнийг цаашид түгээн дэлгэрүүлэх боломжит бичил махбод тархах), **өвчний нян** (тухайн өвчнийг тараах чадал бүхий нүдэнд үл үзэгдэх бичил махбод)

Монгол хэлний сурагчийн тайлбар толь (Сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдад зориулав), Улаанбаатар, 2016. 498-р тал.

Лавлах тайлбар
Нэг. Голлох мэдээллүүд



Хоёр. Ердийн болон тодруулсан үсгийн тиг, таслал, зэрэгцээ цэг, цэгтэй таслал, цэг зэргийг ямар үүргээр хэрэглэснийг ажиглаарай.

Толь бичиг ашиглах тухай

1. Юуны өмнө ямар зорилгоор ямар толь ашиглахаа шийднэ. Өөрөөр хэлбэл, нэвтэрхий толь, нэг хэлний тайлбар толь, олон хэлний буюу орчуулгын толь, дэлгэрэнгүй товч, хураангуй зэрэг толийн алийг нь сонгож ашиглахаа шийднэ гэсэн үг.
2. Толь бичгийг олж сонгосны дараа уг толийнхоо ерөнхий танилцуулгатай болох. Тухайн толь бичгийг хэн зохиосон, хэзээ хаана хэвлэсэн, багтаамж (хэдэн толгой үгтэй, тайлбар үг хэллэгийн тоо), хүрээ хэмжээ (ерөнхий, тусгай, дэлгэрэнгүй, товч, аль цаг үеийн (эртний, орчин цагийн) үг, хэллэг, ухагдахуун ойлголтыг хамарсан).
3. Хэнд зориулсан толь болохыг мэдэх (бүх нийтэд, тусгай мэргэжлийн хүмүүст, хүүхэд залуучуудад, оюутан суралцагчдад гэх мэт)
4. Дээрх (2, 3-т байгаа) мэдээллийг ихэнх толийн “Өмнөх үг” гэсэн хэсэгт бичсэн байдаг. Зарим товч, хураангуй толь бичигт “Өмнөх үг” байдаггүй тул тольтойгоо сайн танилцах хэрэгтэй.
5. Тухайн толь бичгийн толгой үгийн байршил буюу дарааллыг мэдэх. Толгой үгийн байршил дараалал нь цагаан толгойн үсэг дараалсан, зүйл хуваасан гэсэн хоёр янз байдаг. Орчин үеийн толиуд тухайн улс үндэстэнд хэрэглэж байгаа үсэг бичгийн цагаан толгойн үсэг дараалсан байрлалтай байдаг.
6. Толь бичиг ашиглахын өмнө түүний ашиглах заавартай заавал танилцаарай. Энэ нь “Толь ашиглагчдын анхааралд”, “Толь хэрэглэгчдийн анхааралд”, “Толь ашиглах заавар”, “Толь ашиглагчдад зөвлөх нь” гэх мэт нэртэй байдаг.
7. Тухайн тольд хэрэглэсэн цэг цэглэл, тэмдэг тэмдэглэгээ, товчилсон үг, нэр томъёоны учрыг сайтар уншиж судлахыг зөвлөж байна.

Өвөрмөц ба хэвшмэл хэлцийг толь бичигт хэрхэн тусгадаг вэ?

Тухайн хэлний өвөрмөц ба хэвшмэл хэлцийг тайлбар болон орчуулгын тольд тусгаж утгыг нь тайлбарласан байдаг. Сүүлийн үед нэг хэлний болон олон хэлний өвөрмөц хэлцийн зүйлчилсэн тайлбар толиуд олноор гарах болсон байна.

Толь бичигт өвөрмөц ба хэвшмэл хэлцийг яаж тольчилсныг тайлбарлаарай.

1. AMI_fen

1. Хүн амьтны хоёр уруулын хоорондох сүв, хоол идэх эрхтэн...аман зохиол (ард түмний дунд ам дамжин уламжлагдаж ирсэн, зохиолч нь тодорхойгүй уран зохиол), аман хуур хөгжим (олон жижиг нүхэнд төмөрлөгөөр хэл тааруулан хадсан бөгөөд нүхээр нь үлээвэл төмөрлөг хэл нь доргиж дуугарах хөгжмийн зэмсэг), аман хүзүү (хүзүүний нэгдүгээр нугалам, толгойн яс, хатан хүзүү хоёрын хоорондох хүзүү), ...ам хамар *хоршоо* (Хүн амьтны толгойн өмнө этгээд болон уруулын завсарх сүв)...***ам тосдох** а. хоол идэх; амь зуулгатай байх, идэх хоолтой байх; -Ингэвэл бид ам тосдох малгүй болж хувхайрна. (Д. Маам. Газар шороо) ***ам хагарах** (хэлэхээс бэрхшээж байснаа хэлэх) ***ам халах** (б. *шилжсэн*. Хүний сэтгэл хөөрч, яриа нь олшрох, хэтэрхий их ярих) ***аманд орсон шар тосыг хэлээрээ түлэх** *цэцэн* (олзноос татгалзах сайхан боломжийг алдах гэсэн санаа)...

Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. А-Г. УБ., 2008, 85-86-р талаас товчлон авав.

2. Ам тосдох (тослох) 1. Хоол идэх. Өрхийг минь эвдэн цөмлөсөн энэ хирс манайх боллоо. Анчин ирэхээс өмнө бид амаа тосдож, гэдэс гарлаа. Б. Ринчен. Заан Залуудай, 2. Амь зуулгатай байх, идэх хоолтой байх. [Хомоо да] Хошуу сүрийг тэр чигээр нь булааж авсан ч бид...ам тосдох малгүй болж хувхайрна. Д. Маам. Газар шороо.

Г.Аким. Монгол өвөрмөц хэлцийн тайлбар толь. Нэмж зассан хоёр дахь хэвлэл. Улаанбаатар, 1999. 19-р тал.

3. Ам муруйх (түнжин хагарах)

1. BE AT LOGGER-HEADS
2. THERE IS BAD BLOOD BETWEEN TWO PEOPLE
3. SLANGING MATCH

Ам барих (гэмших)

1. WRING ONE`S HANDS
2. TO REGRET, TO BE SORRY

Ц. Дашидондов. Монгол-Англи өвөрмөц хэлцийн толь. ШУА. ХЗХ. Улаанбаатар, 2012, 48-49-р тал.

Тодорхойлолт:

Өвөрмөц хэлц: Хэлний эх, өгүүлбэр, үг, бүтээврийн шууд буюу хэлц бус утга санаа нь зүйрлэх, адилтгах, солих, төлөөлөх, тойруулах замаар шилжиж, шинэ утга санаа үүсэх ёс. Өвөрмөц хэлцийн нэгжүүд нь голдуу шууд ба шилжсэн утгын хослолтой байна.

	Шууд утга	Өвөрмөц хэлц
Ам халах	ам халах	сэтгэл хөөрч, үг яриа нь ихдэх
Зүрх өвдөх	зүрхээр хаггах, зүрх өвдөх	сэтгэл санаа зовох
Магнай тэнийх	магнайн үрчлээ тэнийх	баярлах, сэтгэл уужрах
Үхрийн нүд	үхрийн нүд	нэг төрлийн жимс
Толгой	амьтны толгой	өвсний толгой
Хал үзэж, халуун чулуу долоох	хал үзэж, халуун чулуу долоосон хүн	зовж зүдрэх, бэрхийг туулах, хатуужих

Хэвшмэл хэлц: Хэлний эх, өгүүлбэр, үг, бүтээврийн бүтэц, утга нь тогтвортой болж хэвших. Тухайн нэгжийн шууд утга хэвшиж, тогтвортой нэгж болох ёс. Утга санаа нь шууд утгатайгаа дүйх боловч хэлбэр бүтэц нь салшгүй хэвшсэн байна.

Нийлмэл үг: Номын сан, эдийн засаг, эрх чөлөө, аз жаргал

Цэцэн үг: Эрийг нас, уулыг цас дарна.

Онч үг: Өсөхөөс сурсан үндэсний хэл мартаж болшгүй соёл.

/Д. Нацагдорж/

* - тэмдэгтээр толь бичигт өвөрмөц хэлцийг тэмдэглэнэ.

ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ

Толь бичигтэй холбогдох дараах даалгавруудыг гүйцэтгээрэй.

1. Толь бичгийг зорилго, агуулгаар нь юу юу гэж ангилдаг вэ? Зөв гэж үзэж байгаа хариултын дугаарыг дугуйлна уу.

А. Дэлгэрэнгүй, товч	Б. Тайлбар толь, хураангуй толь
В. Үсэг дараалсан, зүйлчилсэн	Г. Нэвтэрхий толь, хэл шинжлэлийн толь
2. Хэл шинжлэлийн толийг агуулга, зорилгоор нь юу гэж ангилдаг вэ?

А. Хоёр хэлний, олон хэлний	Б. Тайлбар толь, орчуулгын толь
В. Ерөнхий, тусгай	Г. Их гарын, бага гарын
3. Толь бичгийг агуулга, багтаамж, толгой үгийн тоогоор нь зөв ангилсан хэсгийг олно уу.

А. Үсэг дараалсан, зүйлчилсэн	Б. Нэвтэрхий толь, хэл шинжлэлийн толь
В. Дэлгэрэнгүй, товч	Г. Тайлбар толь, орчуулгын толь
4. Дараах толиудаас аль нь журамласан тольд багтах вэ?

А. С.Лувсанвандан, Б. Сумьяабаатар. Монгол хэлний ойролцоо үгийн товч толь. Улаанбаатар, 1966.

Б. Ц.Дамдинсүрэн, Б.Осор. Монгол үсгийн дүрмийн толь. Улаанбаатар, 1983.

В. Г.Аким. Монгол өвөрмөц хэлцийн товч тайлбар толь. Улаанбаатар, 1982.

Г. О. Сүхбаатар. Монгол хэлний харь үгийн толь. Улаанбаатар, 1997.
5. “ба, бөгөөд, харин, шүү, даа, эсвэл...” зэргийг толь бичигт толгой үг болгож тайлбарлах уу? Хэрвээ тайлбарлавал ямар тольд тусгах вэ?
6. Дараах онцлогууд ямар төрлийн толь бичигт байдаг вэ? (Тохирох шинж хэд ч байж болно)

А. Ойлголт, ухагдахууны тайлбар, тодорхойлолт
Б. Нэр алдартай хүмүүсийн товч танилцуулга
В. Газар усны нэрийн тайлбар
Г. Нийлмэл үг, нэр томъёоны тайлбар
7. Дараах ерөнхий шаардлагуудаас аль нь бүх толь бичигт байдаг вэ? Зөв гэж үзсэнээ дугуйлаарай.

А. Толгой үгсийг цагаан толгойн үсэг болон утгын зүйлчилсэн дарааллаар байршуулах
Б. Үгийн олон утга ба ижил үгсийг тольд тусгайлан ялгах
В. Толь бичгийн эхэнд тухайн толийг ашиглах заавар бичсэн байх
Г. Нийлмэл үг, нэр томъёог толгой үг болгохгүй байх
8. Монгол хэлний тайлбар тольд хар I, хар II... гэсэн толгой үгсийг тайлбарла гэвэл та яаж тайлбарлах вэ? (Хэдэн ч толгой үг байж болно)

Түлхүүр:

- 1Г, 2Б, 3В, 4Б, 5. Хэл шинжлэлийн тайлбар ба орчуулгын тольд тусгадаг,
6. Нэвтэрхий тольд, 7. А, В, 8. “Хар” гэсэн үгийн тайлбарыг монгол хэлний тайлбар толиудаас үзнэ үү.